



# **ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

2024.04.29

# АГУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын зарлал	03
Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн тогтоол	05
Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын дэг	07
Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд:	09
<b>Шийдвэрлэх асуудал:</b>	
1. ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;	09
2. ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;	50
<b>Танилцуулах асуудал:</b>	
1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.	55
<b>Шийдвэрлэх асуудал:</b>	
3. ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;	57
4. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай;	61
5. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тухай;	66
6. ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай – Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу;	71
7. ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай - Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу;	88
8. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай;	113
9. Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;	148
10. ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай;	157
11. ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай.	161
Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслүүд	165
Тооллогын комиссын бүрэлдэхүүн	180
Саналын хуудсын загварууд	181



# ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАРЛАЛ

ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-20 дугаар тогтоолын дагуу Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсгийг үндэслэн, хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг үүгээр зарлаж байна.

**Компанийн нэр, байршил:** ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72

**Хурал болох өдөр, цаг, газар:** 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла Зочид Буудлын их танхимд хосолсон (танхим болон цахим) хэлбэрээр зохион байгуулагдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах **бүртгэлийн өдөр:** 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр

## Хурлаар хэлэлцэх асуудал:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.

## Шийдвэрлэх асуудал:

1. ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
3. ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тухай;
6. ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай – Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу;
7. ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай - Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу;
8. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай;
9. Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
10. ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай;
11. ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалуудтай танилцах бол 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн банкны цахим хуудсанд ([www.xasbank.mn](http://www.xasbank.mn)) болон ажлын өдрүүдэд өөрт ойр үнэт цаасны брокер, дилерийн компаниудад 10:00-17:00 цагийн хооронд хандах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч нь өөрийн саналыг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны

өдрөөс эхлэн 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цаг хүртэл хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан, эсхүл ХасБанкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан өгөх боломжтой. Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигч нь хурал эхлэх хүртэл буюу 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цаг хүртэл хугацаанд санал өгөх боломжтой.

**Холбоо барих:**

Утас: +(976)-8508-1888

Цахим шуудангийн хаяг: investor-relations@хасbank.mn

Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2024 оны 03 сарын 15 өдөр

№ R-2024-20

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх хэсэг болон 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорсоо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.1 дэх хэсэг, мөн ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2024 оны 3 дугаар сарын 12-15-ны өдрийн хооронд хийсэн цахим санал хураалтаар гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ НЬ:

1. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулах үүрэгтэй болохыг; мөн
2. ТУЗ нь дараах шийдвэрийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

### ТОГТООХ НЬ:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Их танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг танхим болон цахим байдлаар хосолсон хэлбэрээр зохион байгуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Банкны ТУЗ-ийн дарга Санжай Гүптаг зарласугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавыг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт ([www.xacbank.mn](http://www.xacbank.mn)), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХасБанкны төв байр,  
Ерөнхий сайд Амарын гудамж,  
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,  
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888  
Утас: 7577-1888  
Веб: [www.xacbank.mn](http://www.xacbank.mn)  
И-мэйл: [info@xacbank.mn](mailto:info@xacbank.mn)

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, хурлын танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 4 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсуудыг 5 болон 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдэд саналыг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан, эсхүл Банкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан авах боломжийг бүрдүүлэн ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай. Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэх хүртэл буюу 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цаг хүртэл хугацаанд өгөх боломжтой болохыг дурдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдээс урьдчилан цаасаар болон цахимаар өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал дээр өгсөн саналтай нэгтгэн, тооллогын дүнд оруулан тооцохыг Тооллогын комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Цаг	№	Үйл ажиллагаа	Хариуцах ажилтан
8:30-9:00	1	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл	Тооллогын комисс
9:00-9:05	2	Хурлын ирцийн танилцуулга	Тооллогын комисс
9:05-9:35	3	Хурлын үйл ажиллагааны нээлт	Хурлын дарга
9:35-9:40	4	Хурлын дэгийн танилцуулга	Гүйцэтгэх захирал
9:40-9:50	5	ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга	Гүйцэтгэх захирал
9:50-9:55	6	Асуулт, хариулт	
9:55-10:05	7	ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн танилцуулга	Санхүү хариуцсан захирал
10:05-10:10	8	Асуулт, хариулт	
10:10-10:15	9	ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	Хурлын дарга
10:15-10:20	10	Асуулт, хариулт	
10:20-10:35	11	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан	ТУЗ-ийн хараат бус гишүүд
10:35-10:40	12	Асуулт, хариулт	
10:40-10:50	13	ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга	Гүйцэтгэх захирал
10:50-10:55	14	Асуулт, хариулт	
10:55-11:00	15	Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэм болон Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тухай танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
11:00-11:05	16	Асуулт, хариулт	
11:05-11:10	17	Фреймворк гэрээний танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
11:10-11:15	18	Асуулт, хариулт	
11:15-11:20	19	Бодлогын гэрээний танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
11:20-11:25	20	Асуулт, хариулт	
11:25-11:40	21	ХасБанкийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах тухай танилцуулга	Гүйцэтгэх захирал
11:40-11:45	22	Асуулт, хариулт	
11:45-11:55	23	Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалтын танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД

Цаг	№	Үйл ажиллагаа	Хариуцах ажилтан
11:55-12:00	24	Асуулт, хариулт	
12:00-12:10	25	ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох асуудлын болон ТУЗ-ийн 2024 оны төсвийн танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
12:10-12:15	26	Асуулт, хариулт	
12:35	27	Санал хураалтын хаалт	Хурлын дарга
12:35-13:05	28	Завсарлага – санал тоолох	Тооллогын комисс
13:05-13:15	29	Санал хураалтын нэгдсэн дүнг танилцуулах	Тооллогын комисс
13:15-13:25	30	Хурлыг хаах	Хурлын дарга

**Санал хураалт/тоолох зарчим:** Хувьцаа эзэмшигч нь хэлэлцэх асуудлаар цаасаар болон цахимаар урьдчилан санал өгч болно. Саналыг цаасаар урьдчилан өгөх хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цагт хаагдана. Саналыг цахимаар урьдчилан өгөх хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагт хаагдана. Урьдчилан санал өгөөгүй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр санал хураах асуудал тус бүрээр дэгт заасан хугацаанд саналаа өгнө.

**Хориглох зүйл:** Хувьцаа эзэмшигч нь санал хэлэх, асуулт тавих дараалал зөрчих, хэлэлцэх асуудалд хамааралгүй асуудал дэвшүүлэх болон үймээн дэгдээх зэргээр хурлын дэг зөрчихийг хориглоно.



## **Хурлаар шийдвэрлэх нэгдүгээр асуудал:**

ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх  
ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай






# САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ БАЙДЛААР




# Санхүүгийн гол үзүүлэлтүүд


**Татварын дараах цэвэр ашиг** Тэрбум төгрөгөөр




**aROE\***



**Зээл, санхүүгийн түрээсийн багц** Тэрбум төгрөгөөр



**Харилцах, хадгаламж** Тэрбум төгрөгөөр



**Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа**



**Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ**



**P/E 4.57**

**EPS 138.1**  
төгрөгөөр

YoY Өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт.

\* Тайлант хугацааны цэвэр ашгийг сарын дундаж өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцсон.

### Онцлох үйл явдал

- Санхүүгийн үзүүлэлт
- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт
- Сангаас хаасан зээлийн тайлан
- Компанийн засаглалын тайлан

## Онцлох үйл явдал




### Нээлттэй хувьцаат компани боллоо

ХасБанк нийт хувьцааныхаа 5.01% буюу 35.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр 52.7 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосноос анхдагч зах зээл дээр 9,944 хөрөнгө оруулагчийн 41.8 тэрбум төгрөгийн захиалга ирж, арилжаа 117.2%-ийн биелэлттэй хаагдлаа.



### 205 сая ам.долларын эх үүсвэр татлаа

Бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжихээр Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нидерландын Хөгжлийн Агентлаг, rA, GCPF, БлюОрчард, Симбиотикс, Инкофин, Уур Амьсгалын Ногоон Сан зэрэг байгууллагуудаас нийт **205 сая ам.долларын** эх үүсвэр татлаа.



### ТОП-100 ААН-ийн нэгээр шалгарлаа

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас зарладаг ТОП-100 ААН-ийн нэгээр дахин шалгарлаа.



### Оюу толгой компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулав

Оюу толгой” ХХК-тай “Тэтгэвэр/хуримтлалын сан” үйлчилгээний гэрээ байгуулж, тус компанийн ажилтнууд урт хугацаанд тогтвортой өсөх хуримтлал бий болгоход хамтран ажиллаж эхэллээ.



### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал боллоо

Хурал 95.55 хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр зохион байгуулагдаж, ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг IPO хийсний дараах байдлаар 105.27 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэн тогтоох тухай болон ХасБанк ХК-ийн дүрмийг батлах тухай асуудлыг хэлэлцэн батлав.



### Moody's агентлаг: Ирэх 12-18 сарын хугацаанд ХасБанкны зээлжих зэрэглэл тогтвортой байна

Олон улсын үнэлгээний Moody's investors services агентлагаас 2023 оны 12-р сарын 1-ний өдөр гаргасан тайландаа ХасБанк ХК-ийн зээлжих зэрэглэлийн “B3/тогтвортой” үнэлгээг хэвээр үлдээснээ мэдээллээ.



# Онцлох үйл явдал



## Онлайн хадгаламж

Онлайнаар хадгаламжийн данс нээх, цалингаасаа хуримтлал үүсгэх боломжийг дижитал суваг дээр бий болголоо. Энэ бүтээгдэхүүн нь хадгаламжийн хүүнээс гадна тогтвортой хуримтлал үүсгэсэн харилцагчид хүүний урамшуулал олгох, зарлага гаргах эрх нээх гэх мэт нэмэлт нөхцлүүдийг санал болгож хуримтлалыг зуршил бий болгох, орлогоо тогтвортой хуримтлуулах сэдлийг дэмжих зэрэг нэмэлт давуу талуудтай.



## Орон сууцны зээл

Монгол банктэй хамтарсан аймаг, орон нутагт хэрэгжих 3 хувийн хүүтэй зээлийг зах зээлд нэвтрүүллээ.



## Амар зээл

Цалингийн орлоготой иргэдийн хувьд цалингаа буухыг хүлээх зуур үүсдэг яаралтай, гэнэтийн мөнгөний хэрэгцээг нь хангах зорилгоор шуурхай, амар зээлийг зах зээлд нэвтрүүллээ. Тус зээлийг харилцагч Дижитал Банкны аппликейшнээ ашиглан хоромхон зуур авах боломжтой юм.



Стор-Пэй финтек компанитай хамтран 30 сарын хугацаатай, 30 сая хүртэлх дүнтэй "Уртаар" онлайн зээлийн бүтээгдэхүүн зах зээлд шинээр нэвтрүүллээ.



## ХАА-н салбарыг дэмжих зээлийн хөтөлбөр

ХХААХҮЯ-тай хамтарсан хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хүүгийн татаастай зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүллээ.



## Онлайн цалингийн зээл

Цалингийн зээлийг салбарт ирэлгүйгээр дижитал банкны аппликейшнээрээ дамжуулан хурдан хугацаанд авах боломжтой боллоо. Ямар ч банкны харилцагч тус зээлийг авах боломжтойгоороо онцлог юм.


Олгосон зээл: **₮258.8** Тэрбум



## Эмэгтэй бизнес эрхлэгчийн зээл

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих бизнесийн зээлийг зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Барьцааны хөнгөлөлтөөс гадна зээл шийдвэрлэх хугацааг ажлын 8 цаг хүртэл богиносгосон нь гол давуу тал болсон.

Олгосон зээл: **₮329.7** Тэрбум



Дижитал хэрэглэгч **▲ 31.3%**    POS терминал **▲ 36.0%**    Нийт гүйлгээ **▲ 11.4%**



## Онцлох үйл явдал



### Магадлан итгэмжлэлийн эрхээ сунгаж, 8 сая ам.доллар татан авлаа.

ХасБанк НҮБ-ын Уур амьсгалын ногоон сантай “Магадлан итгэмжлэлийн мастер гэрээ” байгуулж магадлан итгэмжлэлийн эрхээ дахин 5 жилээр сунгаж шинэчиллээ.

Мөн ногоон Эрчим хүчний хэмнэлттэй халаагуур, дулаалга болон амины орон сууц санхүүжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 11 сард нэмэлтээр 8 сая ам.доллар татан авлаа.



ХасБанк нь 2023 онд эко хэрэглээний зээлийн санхүүжилтээр хүлэмжийн хийн ялгарлыг нийт 5,557 тонноор бууруулсан байна.

### "Ногоон зээлийн өдөрлөг"

2023 оны 09-р сарын 9, 10 ны өдөр Эрх чөлөөний талбайд 2 өдөр үргэлжилсэн "НОГООН ЗЭЭЛИЙН ӨДӨРЛӨГ" зохион байгуулсан. Тус өдөрлөг дээр иргэдэд ХасБанкны жилийн 2-3%-ийн хүүтэй Эко хэрэглээний зээлээр эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, дулаалгын шийдэл, байгальд ээлтэй эко бохирын системүүдээс газар дээр нь сонгон зээл авах боломжийг бүрдүүлсэн.



### ХасБанк Тэнгэр Даатгал - Tenger Insurance болон BASE олон улсын байгууллагууд хамтран "Эрчим хүчний хэмнэлтийн даатгал"-ын механизмыг Монголд анх удаа нэвтрүүлж нээлтийн үйл ажиллагаа зохион байгууллаа.

Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизм нь зөвхөн даатгалын бүтээгдэхүүн бус санхүүгийн болон бусад механизмыг хослуулан сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг юм. Даатгалын механизм нь зах зээлд бий болсноор ААН байгууллага болон иргэдийн хэрэглээний дадлыг өөрчилж үр ашигтай, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, байгальд ээлтэй ногоон технологийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд дэмжлэг болно.



### ТОС- ХасБанк Тогтвортой санхүүжилтийн "Онцлох ТоС байгууллага"-аар шалгарлаа.

"Монгол Улсын тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөр"-ийн хүрээнд ТоС холбоо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран жил бүр Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлогыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд салбартаа манлайлан, үнэтэй хувь нэмэр оруулсан банкуудыг тодруулдаг уламжлалтай бөгөөд 2023 оны "Онцлох ТоС Байгууллага"-аар ХасБанк шалгарсан.





## Онцлох үйл явдал



### Эко Лизинг

Байгаль орчинд ээлтэй цахилгаан машиныг хөнгөлөлттэй нөхцөлтэй лизингээр санхүүжүүлж байна. Тухайн онд 8.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий цахилгаан машиныг санхүүжүүлээд байна.



### Банкны бүх үйлчилгээг 1 цэгээс

Бэлтгэн нийлүүлэгчийн хамтын ажиллагааны хүрээнд харилцагчдад лизингийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх зорилгоор Toyota-Таванбогд, Benz-MCM төвийн шинэ байранд Лизингийн салбарууд нээгдэн банкны бусад үйлчилгээг үзүүлж байна.




### ХасМоргейж

ХасМоргейж нь “1 ӨДӨРТ” шийдвэрлэдэг амины орон сууц худалдан авах зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ. Амины орон сууцаас гадна 80м2 дээш талбайтай орон сууц худалдан авах зээлийг мөн адил 1 өдөрт багтаан шийдвэрлэж байна.



### Автомашинны зээлийн төв

2023 оны 05-р сард байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлж байсан Автомашинны зээлийн 2 төвийн нийт багц 28.2 тэрбум төгрөгт хүрч, амжилттай ажиллаж байна.



## Хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого

ХасБанк үүсгэн байгуулагдсан цагаасаа “Жендерийн тэгш байдлын бодлого”-ыг хэрэгжүүлж, байгууллагын зөв соёл, үлгэр жишээ сайн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлж, шударга тогтвортой хөдөлмөрийн харилцааг үүсгэхийг зорин ажиллаж ирсэн. Иймдээ ч Хасчууд маань банкиндаа тогтвортой тууштай ажилладаг ба ажилласан дундаж хугацаа 7.8 жил юм. Мөн банк дотроосоо дэвшүүлэн ажиллуулах бодлогыг баримталж ирсэн бөгөөд нийт удирдлагуудын 90% нь дотроосоо дэвшин ажиллаж байна.

Нийт ажилтан




 Эрэгтэй  Эмэгтэй


Гүйцэтгэх удирдлагын баг



Төв албаны дунд шатны удирдах ажилтан



Салбарын захирлууд



- Онцлох үйл явдал

### Санхүүгийн үзүүлэлт

- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт
- Сангаас хаасан зээлийн тайлан
- Компанийн засаглалын тайлан




## Ашигт ажиллагаа

ХасБанк сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагааг сайжруулан ажиллаж байна. Инфляцаас үүдэлтэй мөнгөний хатуу бодлого нь төгрөгийн болон ам.долларын бодлогын хүүгээр дамжин банкны санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, маржинд сөрөг нөлөө үзүүлж байгаа ч ХасБанк орлого олдог активт эзлэх зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлж (багцын өсөлт +33.9%) активын чанарыг сайжруулж чадсанаар 2023 онд банкны нийт цэвэр ашиг 142.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 34.2%-р өссөн байна.


### Татварын дараах цэвэр ашиг

Тэрбум төгрөгөөр



### aROE

%, сарын дундаж өөрийн хөрөнгөд харьцуулсан




\* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

## АКТИВ

ХасБанкны нийт актив 5 их наяд төгрөг давж оны эхнээс 30.2%-р өссөн амжилттай ажилласан байна. Банкны орлого олдог актив болох зээл болон санхүүгийн түрээсийн багц, төв банкны үнэт цаасны үлдэгдэл оны эхнээс тус тус 33.9% болон 83.6% өссөн нь активын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлсэн байна.


### Нийт актив

Тэрбум төгрөгөөр



### aROA

%, сарын дундаж активт харьцуулсан




\* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

## Зээл, санхүүгийн түрээсийн багц

Зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк, Байгууллагын банк, Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг. 2023 онд Иргэдийн банкны зээлийн багц 37.0%-р, Байгууллагын банкны зээлийн багц 13.1%, Хаслизингийн багц 54.1%-р тус тус өслөө. Иргэдийн банкны зээлийн багц өсөхөд “Таблет Банкинг” үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэсэн бол Хаслизингийн багц нэмэгдэхэд Монгол Улсын гадаад худалдаа, түүний тээврийн асуудал хэвийн горимд шилжиж буйтай зэрэгцээд шинэ машин, механизмын худалдаа сайжирсан нь голлон нөлөөлсөн.

### Зээл ба санхүүгийн түрээсийн үлдэгдэл


Тэрбум төгрөгөөр



### Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөгөөр

■ 2022 ■ 2023




\* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

## Активын чанар

Нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 33.9% өссөнтэй зэрэгцээд банк активын чанараа сайн хэвээр хадгалж ажиллаа. Үүний үр дүнд нийт багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт өмнөх оноос **1.1 нэгж хувиар буурч 2.9%-д** хүрсэн байна.


### Чанаргүй зээлийн үлдэгдэл

Тэрбум төгрөгөөр



### Багцад эзлэх чанаргүй зээлийн хувь

%




\* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк нь 2021 онд нэгдсэн болно.

## Харилцах, хадгаламж

ХасБанк нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Харин хадгаламжийн бүтээгдэхүүн энгийн хугацаагүй хадгаламжаас эхлээд хүүгээ сар бүр зарлагадах боломжтой хугацаатай хадгаламж, хүүхдийн урт хугацааны хуримтлалын хөтөлбөрүүдээс бүрддэг. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах цахим сувгийг нэмэгдүүлсний үр дүнд 2023 онд банкны нийт хадгаламж, харилцах 17.9%-р өссөн.

### Харилцах, хадгаламжийн үлдэгдэл


Тэрбум төгрөгөөр



### Харилцах, хадгаламж бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөгөөр

■ 2022 ■ 2023




\* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

## Гадаад эх үүсвэр

ХасБанк нь харилцагчдадаа урт хугацаатай санхүүжилт олгох зорилгоор Олон Улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2023 онд нийт 205.5 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн бол үүний 130 сая ам.доллар нь 2022 онд ОУСК болон FMO зэрэг байгууллагуудтай байгуулсан урт хугацаат эх үүсвэрийн гэрээний дагуу орж ирсэн бол үлдсэн 75.5 сая ам.доллар нь 2023 онд шинээр эхлүүлсэн хэлцлүүд болно.

### Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллараар



\* ХасЛизингийн үр дүнг ХасБанктай нэгтгэн харуулав. ХасЛизинг болон ХасБанк 2021 онд нэгдсэн болно.

### Санхүүжүүлэгч түнш байгууллагууд



## Зээлжих зэрэглэл

Банк 2008 оноос дэлхийн хамгийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Moody's Investors Service болон Fitch Ratings байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг тасралтгүй хийлгэж байна. 2023 оны 12 сарын 01-ний өдөр ХасБанк ХК-ийн зээлжих зэрэглэлийг “B3/тогтвортой” хэвээр үлдээснээ мэдээллээ.

### MOODY'S

	ХасБанк	Монгол Улс
Зээлжих зэрэглэл - Гадаад валют	B3/NP	B3/NP
Зээлжих зэрэглэл- Төгрөг	B2/NP	B3/NP
Банкны хадгаламж	B3/NP	
Суурь зээлжих зэрэглэл	B3	B3
Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл	B3	B3
Хэтийн төлөв	Тогтвортой	Тогтвортой

### FitchRatings

	ХасБанк	Монгол Улс
Урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл	B/Тогтвортой	B/Тогтвортой
Богино хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл	B	B
Урт хугацааны төгрөгийн зээлжих зэрэглэл	B/Тогтвортой	B/Тогтвортой

- Онцлох үйл явдал
- Санхүүгийн үзүүлэлт

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт

- Сангаас хаасан зээлийн тайлан
- Компанийн засаглалын тайлан




## Монголбанкнаас тогтоосон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт


Монголбанкнаас банкуудад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 9%-р тогтоосон байдаг. Мөн системийн нөлөө бүхий банкуудад нөөц интервалын шаардлага 3%-4% хүртэл нэмж тогтоодог. ХасБанк нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтээ тайлант хугацаанд 20.7% буюу байвал зохих хэмжээнээс 8.2 нэгж хувиар давуулан хангаж ажиллалаа. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтийг байвал зохих хэмжээнээс давуулан хангах нь аливаа болзошгүй эрсдэлийг хүлээх чадвар тэр хэмжээгээр нэмэгддэг болно.

### Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт

ХасБанкны хувьд байвал зохих хэмжээ >12.5%



### Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт




## Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт

Арилжааны банкуудад Монголбанкнаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 25%-аар тогтоосон байдаг. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг тооцохдоо банкны балансад бүртгэлтэй “Түргэн борлогдох актив хөрөнгө”-г “Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө”-д харьцуулан тооцдог. ХасБанк нь өөрийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд түргэн борлогдох актив хөрөнгийг бэлэн мөнгө эсхүл хамгийн бага эрсдэлтэйд тооцогдох хэрэгсэлд байршуулан удирдаж байна.


### Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт

Байвал зохих хэмжээ >25.0%



### Түргэн борлогдох актив

Нийт 1,601.3 тэрбум төгрөг



\* 2020 онд КОВИД цар тахлаас үүдэлтэй сөрөг нөлөөг даван туулах зорилгоор зээлийн багцын хэмжээг бууруулж, бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлсний үр дүнд төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа үзүүлэлт өндөр байсан.

## Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2020	2021	2022	2023
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.8%	-1.1%	6.2%	-1.3%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-4.2%	-2.2%	6.9%	-1.4%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	77.2%	72.8%	66.6%	38.6%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	2.5%	1.7%	1.7%	1.3%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.0%	7.1%	7.7%	7.8%

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2020	2021	2022	2023
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):				
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.8%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.2%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	1.8%	1.8%	1.6%	3.2%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):				
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.8%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.5%	0.4%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	4.5%	3.8%	3.2%

- Онцлох үйл явдал
- Санхүүгийн үзүүлэлт
- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт

Сангаас хаасан зээлийн тайлан

- Компанийн засаглалын тайлан

## Сангаас хаасан зээлийн тайлан

2023 оны 11 дүгээр сарын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагыг бүрэн хангасан зээлүүдийг сангаас хаасан. Банк нь зээлийг сангаас хаасан эсэхээс үл хамаарч өр төлүүлэх ажиллагааг хэвийн үргэлжлүүлж ажиллана.

### Сангаас хаасан зээл, бүтээгдэхүүнээр

Сая төгрөг

Бүтээгдэхүүн	Сангаас хаасан зээлийн хэмжээ Сая төгрөг	Зээлийн тоо
Бичил, жижиг, дунд бизнесийн зээл	2,885	30
Орон сууцны зээл	138	3
Хэрэглээний зээл	745	136
Тээврийн хэрэгслийн санхүүгийн түрээс	226	3
<b>Нийт</b>	<b>3,994</b>	<b>172</b>

### Сангаас хаасан зээл, үндэслэлээр

Сая төгрөг

Бүтээгдэхүүн	Сангаас хаасан зээлийн хэмжээ Сая төгрөг	Зээлийн тоо
Шүүхийн шийдвэр гарснаас хойш 180 хоногийн дотор төлбөр бүрэн төлөгдөөгүй	3,232	45
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн	105	1
Банкны үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж дүгнэсэн	657	126
<b>Нийт</b>	<b>3,994</b>	<b>172</b>

- Онцлох үйл явдал
- Санхүүгийн үзүүлэлт
- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт
- Сангаас хаасан зээлийн тайлан

Компанийн засаглалын тайлан

# ХасБанк ХК-ийн Засаглалын тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

- 1 Удиртгал
- 2 Банкны удирдлага болон зохион байгуулалт
  - 2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал
  - 2.2 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
  - 2.3 Төлөөлөн удирдах зөвлөл
    - 2.3.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн манлайлал
    - 2.3.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал
    - 2.3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
    - 2.3.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд
    - 2.3.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
    - 2.3.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ
    - 2.3.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сургалт
    - 2.3.8 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин
  - 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод
    - 2.4.1 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
    - 2.4.2 Эрсдэлийн удирдлагын хороо
    - 2.4.3 Аудитын хороо
- 3 Гүйцэтгэх захирал
  - 3.1 Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ
- 4 Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга
- 5 Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их хэмжээний хэлцэл
- 6 Дотоод аудитын тогтолцоо
- 7 Ногдол ашгийн мэдээлэл
- 8 Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа
- 9 Мэдээллийн ил тод байдал



## 1. Удиртгал

ХасБанкны хувьд 2023 он засаглалын олон үйл явдал өрнөсөн, өөрчлөлт дагуулсан жил байлаа. ХасБанк 2023 онд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбогдуулан өөрийн засаглалын бүтцэд олон шинэ өөрчлөлтийг хийхийн зэрэгцээ ХасБанкны түүхийн салшгүй хэсэг байсаар ирсэн сайн засаглалын зарчмуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

Энэхүү шилжилтийн хугацаанд бид зохицуулалтын шинэ орчинд бүрэн дасан зохицож, оролцогч талуудтай нээлттэй, найрсаг харилцааг бий болгохын тулд жижиг хувьцаа эзэмшигчидтэй харилцах харилцаагаа сайжруулахад анхаарч ажилласан. Бид энэ чиглэлд илүү их амжилтад хүрэх амлалттайгаар энэ оныг дуусгаж байна.

Тайлант хугацаанд, ХасБанк хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсанаас хойших хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит бус хурал 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Блю Скай Зочид Буудал, 3 дугаар давхар, хурлын Даймонд танхимд цахим болон танхим хосолсон хэлбэрээр амжилттай хуралдсан. Хурлын ирц 95.55 хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр бүрдэж, ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болгон нэмэгдүүлэн тогтоох тухай болон ХасБанк ХК-ийн дүрмийг батлах тухай асуудлыг хэлэлцэн баталсан байна.

ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотой өөрчлөлтүүдийг найрсагаар угтан авч, ил тод байдлын өндөр стандартыг үргэлжлүүлэн баримтлахаар хичээнгүйлэн ажиллаж байна.

## 2. Банкны удирдлага болон зохион байгуулалт

Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь эрх барих дээд байгууллага байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлаар шийдвэр гаргадаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкныг стратегийн удирдлагаар хангадаг. Мөн, Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж танилцуулдаг ба Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулдаг.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон Гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкныг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол тайлагнах үүрэгтэй.

### 2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны ердийн олонх буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг болон Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал болон нийт гаргасан Хувьцааны 5 хувиас дээш хувийг эргүүлэн авах, ногдол ашиг хуваарилах, өөрийн хөрөнгийн 2 хувиас дээш дүнгээр хөрөнгө оруулах зэрэг Банкны дүрмийн 8.6 дахь хэсэгт заасан стратегийн ач холбогдол бүхий асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулдаг.



## 2.2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк 2023 оны 2 дугаар улиралд нийт зарласан энгийн хувьцааныхаа 5.01% буюу 52,700,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө татан төвлөрүүлж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болж өөрчлөгдсөн. Ийнхүү ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, нийт зарласан болон гаргасан хувьцааны, 5.01 хувийг олон нийт, үлдсэн хувь буюу 94.99 хувийг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН") эзэмшиж байна.

ТСН нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоод болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд болон хувь хүмүүсээс бүрдсэн нийт 10 хувьцаа эзэмшигчидтэй.

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

#	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь	#	Хувьцаа эзэмшигч	Хувь
1	<b>ТСН</b>	<b>1,000,000,000</b>	<b>94.99%</b>	1	МАК Инвест Кей Эф Ти	19.37%
				2	Олон Улсын Санхүүгийн Корпораци / ОУСК/	16.63%
				3	ОРИКС Корпораци	16.28%
				4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/	12.50%
				5	Канадын Үндэсний Банк /NBC/	10.18%
				6	Ронок Партнерз Кей Эф Ти	9.83%
				7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	6.42%
				8	Триодос Фэр Шэр Фанд	3.61%
				9	Иргэн Магваны Болдоо /иргэн/	0.10%
				10	Иргэн Чулууны Ганболд /иргэн/	0.09%
2	<b>Олон нийт</b>	<b>52,700,000</b>	<b>5.01%</b>			
	<b>Нийт</b>	<b>1,052,700,000</b>	<b>100%</b>			

## 2.3. Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны гол хэлбэр нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан явуулах болон эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг зохицуулалттай.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаас бусад хурлуудыг Zoom зэрэг харилцааны холбооны хэрэгслүүдээр дамжуулан зохион байгуулж хуралдуулж байна.
- Ээлжит хурлын чөлөөт цагт, хуваарийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээллийн чанартай онлайн уулзалтуудыг зохион байгуулж Гүйцэтгэх удирдлагаас цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч байна.

### 2.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн манлайлал

ХасБанк нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн актууд, Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн нийт 22 дүрэм, журам, бодлого болон засаглалын кодексийг шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан.

#### Шинээр баталсан:

1. ХасБанкны засаглалын кодекс;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагааны журам;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журам;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
5. Мэдээллийг ил тод болгох ерөнхий журамд;
6. Харилцагчийг таньж мэдэх ерөнхий журам;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам;
8. Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам;
9. Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам;
10. Засаглалын төлөвлөгөө 2023-2026;
11. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам; мөн
12. Ногдол ашгийн бодлого.

#### Нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан:

1. ХасБанк ХК-ийн дүрэм;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дүрэм;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм;
5. Ажилтны зээлийн ерөнхий журам;
6. Дотоод аудитын дүрэм;
7. Дотоод аудитын бодлого;
8. Шүгэл үлээх бодлого;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам; мөн
10. Авлига, хээл хахуулийн эсрэг ерөнхий журам.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөл нь хагас жилийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах боломжийг нээх зорилгоор ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулан, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулав.

## 2.3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 удаагийн ээлжит хурлыг оролцуулан нийт 13 удаа хуралдсан бөгөөд нийт 84 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал тус бүрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын өмнөх шийдвэр, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулдаг.

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц*

#	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	Ирц (хувиар)
1	Санжай Гүпта, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	100%
2	Албертус Брагинк, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	100%
3	Анджей Витак, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	100%
4	Г.Цэвэгжав, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал	100%
5	Ив Жако, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	69%
6	Майкл Мадден, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	100%
7	Нираж Вэдва, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	100%
8	Сюзанна Карр, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	84.6%
9	Б.Уламбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	100%
10	Н.Цэлмүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	92.3%
11	Эми Чой, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	87.5%

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй ээлжит хурлын үеэр нүүр тулсан ганцаарчилсан уулзалтууд хийх болон Гүйцэтгэх захиралтай тохиролцсоноор банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр тодорхой мэдээлэл хүсэх, авах, харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

## 2.3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Төлөөлөн удирдах зөвлөл нь гишүүн бүрийг асуудлын хэлэлцүүлэгт оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хангах, нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж, түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргахад Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, гишүүдийн тоо, чадвар, мэргэшсэн дадлага туршлага, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус гишүүдийн оролцоог хангах зарчмаар ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны дүрмийн дагуу 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж буйгаас ТУЗ-ийн дарга 1, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох 1 гишүүн, Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 6 гишүүн болон хараат бус гишүүн 3 байна.

Тайлант хугацаанд 1 хараат бус гишүүн үүрэг ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргаснаар хараат бус гишүүний 1 сул орон тоо гарсан. Үүнтэй холбогдуулан 2023 оны 7 дугаар сараас эхлэн нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж нэр дэвшигчдийг бүрдүүлэх ажлыг ХасБанкны Засаглал, нэр дэвшүүлэх,

цалин урамшууллын хороо гүйцэтгэсэн. Улмаар 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшигчдийг танилцуулж, хувьцаа эзэмшигчдээр сонгуулахаар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, аливаа хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд бус гишүүн гүйцэтгэдэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд банкны салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

(2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

#	Нэр	Албан тушаал	Төлөөлөл
1	Санжай Гүпта	<b>Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга</b>	-
2	Албертус Браггинк	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ОРИКС
3	Анджей Витак	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ЕСБХБ
4	Гүмэнжавын Цэвэгжав	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал	Дүрэмд заасны дагуу
5	Ив Жако	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Канадын үндэсний банк
6	Майкл Мадден	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Ронкок Партнерз Кэй Эф Ти
7	Нираж Вэдва	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Хараат бус
8	Сюзанна Карр	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	ОУСК
9	Баянсаны Уламбаяр	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Хараат бус
10	Нямтайширын Цэлмүүн	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	МАК Инвест Кэй Эф Ти
11	Эми Чой	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Хараат бус

## 2.3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд

### **1 – Санжай Гүпта, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

Санжай Гүпта нь 2017 оны 3 дугаар сараас ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр, 2019 оны 3 дугаар сараас Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилогдон ажиллаж байна. Тэрээр Дели дэх Сэинт Стивинг коллежийг Физикийн шинжлэх ухааны бакалавр, Дели Их Сургуулийн Менежментийн факультетыг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 1981 оноос 2001 оны хооронд БНЭУ, Англи болон ХонгКонг дахь Банк оф Америка банкинд ажиллаж байснаас дурдвал, Байгууллагын банк хариуцсан захирал, Энэтхэг дэх Файнэншл Инститюшнс Групп хариуцсан захирал, Европ, Ойрх Дорнод, Африкийн (ЕОДА) Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, ЕОДА-ийн Стракчард Кредит Группийн гүйцэтгэх захирал, Ази дахь Инвестмент Банкинг Группийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. 2001 оноос 2005 оны хооронд тэрээр Кредит Лионассд Ази, Номхон далайн бүсийн Байгууллагын Зээл хариуцсан захирлаар ажиллаж байсан. Мөн тэрээр 2006 оноос 2015 оны хооронд Кредит Агриколь Группэд Ази дахь зээлийн дахин санхүүжилт хариуцсан захирал Глобал Энержи Группийн Ази хариуцсан захирал зэрэг албан тушаал хашиж байсан арвин туршлагатай банкир юм.

### **2 – Гүмэнжавын Цэвэгжав, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн ба Гүйцэтгэх захирал**

Гүмэнжавын Цэвэгжав нь 2019 оны 5 дугаар сараас ХасБанкны Гүйцэтгэх захирал болон ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 2011 оноос өнөөг хүртэлх хугацаанд ХасБанкинд Ерөнхий захирал, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, ХасЛизинг ХХК-д Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Санхүү хариуцсан захирал зэрэг албан тушаалуудад тус тус ажиллаж байсан. Г.Цэвэгжав нь АНУ дахь томоохон компаниудад ажиллаж байсан туршлагатай.

Тэрээр АНУ-ын Колорадогийн Их Сургуулийг Бакалавр, Рэжис Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.

### **3 – Албертус Браггинк, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Албертус Браггинк нь 2020 онд Орикс Корпорациас нэр дэвшин ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Албертус Браггинк нь Нидерландын хамгийн том санхүүгийн байгууллага болох Рабо банкинд 30 гаруй жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир юм. Тэрээр 2004-2016 оны хооронд тус банкинд гүйцэтгэх удирдлагын түвшинд санхүү болон эрсдэлийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан. Одоо тэрээр Орикс Корпорацийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвлөхөөр ажиллахаас гадна Нидерландын болон бусад улс орны томоохон байгууллага, компаниудад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Албертус Браггинк нь Нидерландын Твенте их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр болон докторын зэрэгтэй.

### **4 – Анджей Витак, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Анджей Витак нь 2019 оноос Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-с нэр дэвшиж, ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай нэгэн бөгөөд Украин, Узбекистан зэрэг улс дахь ЕСБХБ-ны суурин төлөөлөгч, орлогчоор ажиллаж байсан. Мөн тэрээр ОХУ, Польш, Монгол, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд болон зүүн Европ дахь улс орнууд дахь байгууллагуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан. Одоогоор чанаргүй актив, эрсдэлтэй зээлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж буй ЕСБХБ-ны төслүүдэд бие даасан зөвлөхөөр ажиллаж байна. Анджей Витак нь Польш улсын Силезиа их сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

### **5 – Майкл Мадден, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Майкл Мадден нь 2009 оноос Ронк Партнерзаас нэр дэвшиж ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүү, олон улсын төлбөр тооцооны салбарт нийт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр иргэдийн банк, картын болон дижитал төлбөр тооцооны өргөн мэдлэгтэй, хөгжиж буй эдийн засаг бүхий улс орнуудад хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын туршлагатай. Өмнө нь тэрээр Американ Экспресс санхүүгийн байгууллагын Ирланд дахь салбарт хэд хэдэн албан тушаал хашиж, ОХУ-д карт нутагшуулах ажлыг гардан гүйцэтгэж, хамгийн сүүлд Их Британид дэд ерөнхийлөгч, Европ, Ойрх Дорнод, Африкийн франчайз хариуцсан захирлын албан тушаал хашиж байсан. Тэрээр АНУ-д санхүүгийн зөвлөгөө үзүүлэгч “Тенео” компанид Санхүүгийн зөвлөх, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын албан тушаалыг 2011 оноос хойш хашиж байна. Мөн тэрээр цахим төлбөр тооцооны чиглэлээр зах зээлдээ тэргүүлж буй ОнГөү компанийг Мянмар Улсад үүсгэн байгуулсан ба тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

### **6 – Нямтайширийн Цэлмүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Нямтайширын Цэлмүүн нь 2012 оноос Монголын Алт (МАК) ХХК-иас нэр дэвшиж ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр ТСН-ийн хувьцаа эзэмшигч МАК Инвест Кей Эф Ти-ийн толгой компани болох МАК ХХК-ийн Ерөнхийлөгч/Гүйцэтгэх захирлын албан тушаал хашдаг бөгөөд олборлох үйлдвэрлэл, барилгын материал боловсруулах болон агаарын тээврийн салбарт хөрөнгө оруулалт, бизнесийн өргөн мэдлэг, туршлагатай. Н.Цэлмүүн нь АНУ-ын Индиана мужийн Валпараисо Их Сургуулийг Бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн бөгөөд санхүүгийн инженерингийн чиглэлээр Стэнфордын Их Сургуулийн Хонгконг гэрчилгээт сургалт, Харвардын Бизнесийн сургуулийн хөтөлбөрүүдэд тус тус суралцсан.

### **7 – Ив Жако, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Ив Жако нь 2016 онд Нэйшнл Банк оф Канада (Канадын үндэсний банк)-аас нэр дэвшиж түүнээс хойш ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Франц улсын И Эс Эс И Си их сургуулийн дипломтой бөгөөд АНУ-ын Вартон сургуульд санхүүгийн чиглэлээр докторын ухааны зэрэг хамгаалахаар тэтгэлэгт хамрагдсан. Тэрээр банкны салбарт тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд Эй Экс Эй Групп болон Бред Банк Групп зэрэг томоохон банк санхүүгийн байгууллагуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, дэд захирлын албан тушаалд ажиллаж байсан. Тэрээр иргэдийн банк, хөрөнгийн зах зээл, хөрөнгө зохицуулалт, байгууллагын банк, хөрөнгийн удирдлага зэрэг чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Өдгөө тэрээр Канадын үндэсний банкны тэргүүн дэд ерөнхийлөгч, Эй Би Эй Банк, Эй Ти Эй Ай Ти, Наткан Интернейшнл зэрэг байгууллагуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

### **8 -Сюзанна Херринг Карр, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Сюзана Херринг Карр нь 2022 онд ОУСК-иас нэр дэвшиж ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлд томилогдон ажиллаж байна. Тэрээр хөгжиж буй санхүүгийн зах зээлд 30 гаруй жил ажилласан туршлагатай юм. Тэрээр хөрөнгө оруулалтын бүтэц, багцын удирдлага, зээлийн бодлого, хөгжлийн нөлөөлөл хэмжилт, компанийн засаглал зэрэг өргөн хүрээний асуудлаар арвин туршлагатай. Тэрээр өмнө нь Бүгд Найрамдах Серби улсад төвтэй ПроКредит Банк болон Люксембургт төвтэй Бичил Санхүүжилтийг Сайжруулах Хөтөлбөр зэрэг байгууллагуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан. Мөн 1996-2016 оны хооронд ОУСК-д удирдах албан тушаалуудад ажиллаж байсан. Тэрээр Дьюкийн их сургуулийг Эдийн засгийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

### **9– Нираж Вэдва, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Нираж Вэдва нь 2018 оноос эхлэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 36 жилийн турш банкны салбарт мэдээллийн технологийн чиглэлээр удирдлагын түвшинд ажилласан туршлагатай. Нираж Вэдва нь Тек Махиндра (Энэтхэг Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, технологийн чиглэлээр дэлхийн Топ 20-д багтдаг компани), Швейцар Улсын Темонос (банкны программ хангамж чиглэлээр дэлхийд тэргүүлэгч) болон Нуклеус Софтвэр (зээлийн программ хангамж чиглэлээр тэргүүлэгч улс дамнасан компани) зэрэг компаниудад ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2019 оны 6 дугаар сард мэдээлэл технологийн зөвлөх үйлчилгээний чиглэл бүхий Акселерик Эф Зи компанийг Арабын Нэгдсэн Эмират улсад байгуулсан бөгөөд тус компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн тэрээр технологийн компаниудад зөвлөх албан тушаал хашдаг байна. Нираж Вэдва нь Дели их сургуулийн бакалавр зэрэгтэй, Индира Гандигийн нэрэмжит их сургуулийг магистрын зэрэгтэй төгссөн.

### **10– Баянсаны Уламбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Баянсаны Уламбаяр нь 2015 оноос эхлэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байна. Тэрээр өмнө нь Токио хотод Лиман Бродерс болон Номура Секьюритис зэрэг хөрөнгө оруулалтын банкуудад ажиллаж байсан ба Монголд эргэн ирээд Дрэйпер Капитал болон Композит Капитал зэрэг хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөх болон Монгол хариуцсан захирлаар ажиллаж байсан. Мөн богино хугацаанд Алтай Холдинг группийн гүйцэтгэх захирлаар ажилласан. Б.Уламбаяр нь хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр ажиллахаас өмнө Японы Сони корпорацид судалгаа хөгжүүлэлтийн инженерээр ажиллаж байсан туршлагатай. Б.Уламбаяр нь Токиогийн Технологийн Их Сургуулийг электроникийн инженерийн бакалавр, магистрын зэрэгтэй төгссөн. Мөн АНУ-ын Чикагогийн Их Сургуулийн Бизнесийн сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж, магистрын зэрэг хамгаалсан.

### **11–Эми Чой, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Эми Чой нь 2023 оноос эхлэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 1994 оноос Хонконг дахь Сити банкинд систем хөгжүүлэлтийн менежерээр ажиллаж банк, санхүүгийн салбарын ажлын гараагаа эхлүүлсэн бөгөөд Хятадын Гуангфа Банк, Пинг Ан Банк болон бусад банк, санхүүгийн байгууллагуудад салбарын менежерээс эхлээд Гүйцэтгэх захирлын орлогч, Дэд ерөнхийлөгч болон Иргэдийн банк хариуцсан Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч зэрэг удирдах албан тушаалуудад ажиллаж байсан туршлагатай. Банкны салбарт ажиллаж эхлэхээс өмнө тэрээр 16 жил Мэдээлэл технологийн салбарт буюу Хонконг дахь АйБиЭм-д банк, даатгалын салбарын системийн автоматжуулалт чиглэлээр ажиллаж байжээ. Ажилласан банкууддаа тэрээр иргэдийн банкны дижитал өөрчлөлт болон банкны үйлчилгээг олон сувгаар шууд хүргэх шинэтгэлийн ажлыг амжилттай удирдаж байсан. Эми Чой нь Хонконгийн Политехникийн их сургуулийг Мэдээллийн системийн шинжилгээ, дизайны чиглэлээр дипломтай төгссөн ба Лондонгийн Сити их сургуулиас Бизнесийн шинжилгээ, дизайны чиглэлээр шинжлэх ухааны магистрын зэрэг авсан байна.

## **2.3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох**

ХасБанк нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний залгамж халааны төлөвлөгөөг жил бүр хэлэлцдэг. Уг төлөвлөгөө хэлэлцэх процессыг журамлах зорилгоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний залгамж халааг бэлдэх бодлого”-ыг мөн 2025 оны II дугаар улирал гэхэд боловсруулан баталсан байхаар төлөвлөсөн.



Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуулийн хугацаа дуусах үед гишүүн үүрэгт ажлаа хүлээлгэн өгөх буюу хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. Төлөөлөн удирдах зөвлөлд орон тоо гарах эсхүл Дүрэмд заасан бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр түр томилж болно. Түр томилогдсон гишүүн нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж гаргаж танилцуулах асуудлыг хариуцдаг.

Хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг Банкнаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай мэдэгддэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сонгодог.

### **2.3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ**

Зохистой засаглалын зарчмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өөр хоорондын үнэлгээг тус бүр хийдэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийг бэхжүүлэх, сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломж болохоос гадна үүсгэн байгуулагчид, бусад талуудад өөрийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг.

ХасБанкны Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь 2023 оны 4 сард болсон Төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлын гүйцэтгэл, хурлын ирц, хуралд оролцсон байдал, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг, ажлын гүйцэтгэлийг тийнхүү тайлагнасан.

### **2.3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сургалт**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг компанийн засаглалын сургалтад нэн тэргүүнд хамруулж Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн засаглалын онцлогийг таниулах сургалтыг зохион байгуулдаг.

Мөн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн анх томилогдмогц түүнд (а) ХасБанкны онцлогийг таньж мэдэхэд зориулсан багц материал, үүнд Өмнөх оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, өмнөх хурлын тэмдэглэл зэрэг бичиг баримтууд, (б) өөрийн үйл ажиллагааг зохистой удирдан явахад зориулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам, ХасБанкны Засаглалын кодекс, ХасБанк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам, Монголбанкнаас баталсан компанийн засаглалын баримт бичгүүд зэрэг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хамаарах бусад бичиг баримтуудыг хүргүүлдэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Гүйцэтгэх захиралтай тохиролцон, Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүй байдлаар Банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж асууж тодруулах, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангагддаг.

### **2.3.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалингийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Төлөөлөн удирдах зөвлөл, Хорооны хуралд оролцох



болон бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой цалин авдаг ба Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тухайн жилд олгох цалин хөлс нь түүний оролцох шаардлагатай Төлөөлөн удирдах зөвлөл, түүний хороо болон хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэлээс хамааран тодорхойлогдоно. Цалин хөлсийг улирал тутамд олгоно. Зохистой засаглалын зарчмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй байхаар тогтоодог.

Банкинд давхар албан тушаал хашдаггүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хувьцаа эзэмшигчдээс тогтоосон цалин, хороо удирдсантай холбогдуулан олгох нэмэгдлээс өөр бусад шагнал урамшуулал авдаггүй.

## **2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод**

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслэх зорилготой. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах байнгын хороодтой.

- i. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- ii. Эрсдэлийн удирдлагын хороо; мөн
- iii. Аудитын хороо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон Аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж буй гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн Хороодод гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын өмнөх өдөр товлогддог.

2023 онд ХасБанк нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор байнгын Хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, олонхыг хараат бус гишүүдээр бүрдүүлсэн.

### **2.4.1. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо**

#### **2.4.1.1 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагаа, чиглэл**

Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

Хорооны дүрмийг 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шинэчлэн баталсан.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журамтай доорх холбоосоор орж танилцан хорооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авна уу: <https://www.xacbank.mn/page/board-committees>

### 2.4.1.2 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн 2023 онд дараах байдалтай байв:

1. Майкл Мадден, дарга
2. Баянсаны Уламбаяр, гишүүн (Хараат бус)
3. Эми Чой, гишүүн (Хараат бус)
4. Нираж Вэдва, гишүүн (Хараат бус)
5. Нямтайширын Цэлмүүн, гишүүн

### 2.4.1.3 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хурал, ирц

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь тайлант хугацаанд нийт 11 удаа хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна. Энэ нь хараат бус гишүүний сул орон тоонд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулах ажлыг өргөн хүрээтэйгээр зохион байгуулж, олон шатны ярилцлагуудыг зохион байгуулж ажилласантай холбоотой.

Хорооны хурлын ирц

#	Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүд	Ирц (хувиар)
1	Майкл Мадден, Хорооны дарга	100%
2	Нираж Вэдва, Гишүүн (Хараат бус)	62.5%
3	Баянсаны Уламбаяр, Гишүүн (Хараат бус)	100%
4	Нямтайширын Цэлмүүн, Гишүүн	72.7%
5	Эми Чой, Гишүүн (Хараат бус)	100%

## 2.4.2. Эрсдэлийн удирдлагын хороо

### 2.4.2.1 Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа, чиглэл

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журамтай доорх холбоосоор орж танилцан хорооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авна уу: <https://www.xacbank.mn/page/board-committees>

### 2.4.2.2 Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

Хороо нь 2023 онд дараах бүрэлдэхүүнтэй ажиллалаа:

1. Ив Жако, дарга
2. Албертус Браггинк, гишүүн
3. Баянсаны Уламбаяр, гишүүн (Хараат бус)
4. Нираж Вэдва, гишүүн (Хараат бус)
5. Эми Чой, гишүүн (Хараат бус)

### 2.4.2.3 Эрсдэлийн удирдлагын хорооны хурал, ирц

2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал 4 удаа хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

#	Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүд	Ирц (хувиар)
1	Ив Жако, Дарга	50%
2	Албертус Браггинк, Гишүүн	100%
3	Баянсаны Уламбаяр, Гишүүн (Хараат бус)	100%
4	Нираж Вэдва, Гишүүн (Хараат бус)	100%
5	Эми Чой, Гишүүн (Хараат бус)	100%

## 2.4.3. Аудитын хороо

### 2.4.3.1 Аудитын хорооны үйл ажиллагаа, чиглэл

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Аудитын хорооны дүрмийг 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

Аудитын хорооны үйл ажиллагааны журам, Аудитын бодлоготой доорх холбоосоор орж танилцан хорооны чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг авна уу: <https://www.xacbank.mn/page/board-committees>

### 2.4.3.2 Аудитын хорооны бүрэлдэхүүн

Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг.

Аудитын хорооны бүрэлдэхүүн:

1. Баянсаны Уламбаяр, дарга (Хараат бус)
2. Нираж Вэдва, гишүүн (Хараат бус)
3. Эми Чой, гишүүн (Хараат бус)
4. Анджей Витак, гишүүн
5. Сюзанна Херринг Карр, гишүүн

### 2.4.3.3 Аудитын хорооны хурал, ирц

2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурал 5 удаа хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

#	Аудитын хорооны гишүүдийн ирц	Ирц (хувиар)
1	Б.Уламбаяр, Дарга (Хараат бус)	100%
2	Нираж Вэдва, Гишүүн (Хараат бус)	100%
3	Эми Чой, Гишүүн (Хараат бус)	100%
4	Анджей Витак, Гишүүн	100%
5	Сюзанна Херринг Карр, Гишүүн	100%

### 3. Гүйцэтгэх захирал

2019 оны 5 сараас эхлэн ХасБанкны Гүйцэтгэх захирлаар Гүмэнжавын Цэвэгжав ажиллаж байна. Гүйцэтгэх захирал нь банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг удирдаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан стратеги, зорилт, бодлогыг хэрэгжүүлж ажиллахаас гадна стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны дотоод дүрэм журам, эрдсэл, хяналтын системийг боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр манлайлж ажилладаг.

#### 3.1. Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл болзол, Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн талаар гаргасан Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээ нь түүнд олгох цалин урамшууллыг тодорхойлох үндэслэл болно.

Гүйцэтгэх захирлын 2023 оны ажлын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны гуравдугаар сарын ээлжит хурлаар хэлэлцэж цэвэр ашиг, өөрийн хөрөнгө болон бусад гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт үндэслэн урамшуулал олгосон байна.

### 4. Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга

ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан, ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилгоор 2023 онд “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна жилд 2 удаа бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй.

ХасБанк нь өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталсан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойш холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

### 5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их хэмжээний хэлцэл

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 онд нийт 27 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг батламжилсан. Ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримталсан.

Тайлант хугацаанд батлагдсан сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийн жагсаалт

№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)
1	Банкны эрх бүхий албан тушаалтан	244,179,750
2	Банкны эрх бүхий албан тушаалтан	50,000,000
3	Банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан	147,000,000
4	Банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан	1,200,000
5	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
6	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	3,600,000
7	Банкны нэгдлийн оролцогчийн холбогдох этгээд	50,000,000
8	Банкны нэгдлийн оролцогчийн холбогдох этгээд	50,000,000
9	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалттай компани	7,000,000,000
10	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	100,000,000
11	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
12	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	608,646.96
13	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	429,084.02
14	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	655,112.16
15	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	591,127.27
16	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалттай компанийн эрх бүхий албан тушаалтан	5,000,000
17	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалттай компанийн эрх бүхий албан тушаалтан	3,000,000
18	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	90,000,000
19	Банкны нэгдлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
20	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000
21	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	500,000
22	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
23	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000
24	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	500,000
25	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	100,000,000
26	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	180,000,000
27	Банкны эрх бүхий албан тушаалтан	417,300,000

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.

## 6. Дотоод аудитын тогтолцоо

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэл тайлбар өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2023 онд хөндлөнгийн аудитороор Эрнст Янг компани аудит хийж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяа Аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд улирал бүр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг.

- Санхүүгийн тайлан, санхүүгийн үзүүлэлтүүдийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд болон эрх зүйн бусад актуудтай нийцэж байгаа эсэхийг хянах;
- Банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, үнэлэлт, дүгнэлт өгөх, Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, гол эрсдэлүүд, түүнийг хэрхэн удирдаж буй талаар чиглэл өгөх;
- Дотоод аудитын хараат бус байдлыг хангах, төсвийг батлах, удирдах, гүйцэтгэлийг хянах, дотоод аудитын тайланг хэлэлцэх, Аудит хариуцсан захирлыг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах, цалин, урамшууллыг тогтоох; мөн
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, чөлөөлөх, гүйцэтгэлийг үнэлж холбогдох саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх.

Дотоод аудит нь банкны дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг үнэлж, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг аудитлуулагч талд бэлтгэн хүргүүлж, тухайн зөвлөмжийн мөрөөр хийгдсэн ажилд хяналт тавьж, үр дүнг нь тайлагнах байдлаар банкны үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулдаг.

Дотоод аудитын газар нь Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны гурав дах хамгаалалтын шугам болж ажилладаг бөгөөд Дотоод аудиторуудын хүрээлэнгээс гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, ёс зүйн дүрмийг дагаж мөрддөг.

## 7. Ногдол ашгийн мэдээлэл

ХасБанк нь олон нийтэд хувьцаа гаргахаас өмнө буюу 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 2022 оны санхүүгийн жилийн цэвэр ашгаас 30 тэрбум төгрөгийн ногдол ашгийг ХасБанкны хувьцаа эзэмшигчдэд хуваарилах шийдвэрийг гаргаж хуваарилсан.

Үүний дараа, ХасБанкны 2023 оны эхний хагас жилийн ногдол ашгаас 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг зарлаж, хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлэн 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн нэрийн дансанд байршуулан тарааж дууссан байна.

Ийнхүү цаашид хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах боломжийг нээх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл мөн дээрх хурлаар ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлууллаа.

## 8. Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа

ХасБанк нь хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар болон цахим шуудангаар харилцах харилцааг үнэн зөв, ижил жигд, хууль тогтоомжид нийцсэн байдлаар удирдан зохион байгуулах зорилгоор “Хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журам”-ыг 2023 оны 11 сарын 30-ны өдөр шинээр баталсан.

ХасБанк нь өөрийн хасbank.mn цахим хуудсаар дамжуулан оролцогч талуудад мэдээллийг тогтмол хүргэж, түүний санал, гомдол хэсгээр дамжуулан оролцогч талуудтай харилцан ажиллаж байна.

## 9. Мэдээллийн ил тод байдал

ХасБанк нь өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод тайлагнан, мэдээлэх зорилгоор “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг 2023 оны 7 сарын 07-ны өдөр шинээр баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж буй бөгөөд, Төлөөлөн удирдах зөвлөл нь түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.







## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-12

Улаанбаатар хот

2023 оны үйл ажиллагааны тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу, ХасБанк ХК ("ХасБанк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ("ТУЗ")-ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрийн хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны гүйцэтгэх удирдлага ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг тусгасан тайлан ("2023 оны үйл ажиллагааны тайлан")-г энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар бэлтгэснийг; мөн
- ТУЗ хэлэлцээд 2023 оны үйл ажиллагааны тайлан нь ХасБанкны үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв бөгөөд бодитоор илэрхийлсэн гэж дүгнэсэн ("ТУЗ-ийн дүгнэлт") болохыг тус тус дурдав.

### ТОГТООХ нь:

- ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт ХасБанкны хувьцаа эзэмшигчдэд өргөн мэдүүлэхээр баталсугай.
- Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд 2023 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, удахгүй тохиох ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэж танилцуулах зэрэг энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



## **Хурлаар шийдвэрлэх хоёрдугаар асуудал:**

**ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх  
ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай**



## САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН ХасБанк ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

### Дүгнэлт

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг ХасБанк ХК (“Банк”)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Банкны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

### Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд дараахыг багтаасан.

- Аудитын онцгойлсон асуудал - Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох “Зээлийн үнэ цэнийн бууралт” байсан.

### Санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага юм.

### Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) 810 буюу “Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил”-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.



*Ernst & Young Mongolia Audit LLC*  
Эрнст энд Янг Монголия Аудит Ххк  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Буланбай Хабылхайрат  
Захирал

Баталсан



Адриан Чу  
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2024 оны 3 дугаар сарын 15


2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн

➤ **Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан**

	2023 мян.төг	2022 мян.төг
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү болон түүнтэй адилтгах орлого	526,401,210	362,440,045
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүү болон түүнтэй адилтгах орлого	12,159,064	14,218,509
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(278,569,871)	(156,331,816)
<b>Хүүний цэвэр орлого</b>	<b>259,990,403</b>	<b>220,326,738</b>
Хураамж ба шимтгэлийн орлого	36,904,130	30,701,660
Хураамж ба шимтгэлийн зардал	(13,509,402)	(11,288,762)
<b>Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого</b>	<b>23,394,728</b>	<b>19,412,898</b>
Арилжааны цэвэр ашиг	13,612,534	16,983,711
БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого	5,376,193	3,349,898
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого	4,777,551	3,597,709
<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>	<b>307,151,409</b>	<b>263,670,954</b>
Үнэ цэнийн бууралтын буцаалт/(зардал)	8,118,712	(9,153,357)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>315,270,121</b>	<b>254,517,597</b>
Үйл ажиллагааны зардал	(125,711,392)	(109,334,959)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	1,129,888	1,506,637
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>190,688,617</b>	<b>146,689,275</b>
Орлогын татварын зардал	(48,629,972)	(40,850,689)
<b>Тайлант хугацааны ашиг</b>	<b>142,058,645</b>	<b>105,838,586</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</b>		
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:		
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөцийн өөрчлөлт, татварын дараах	277,438	854,230
<b>Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах</b>	<b>277,438</b>	<b>854,230</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>142,336,083</b>	<b>106,692,816</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):</b>		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	138.05	105.84
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	138.05	105.84

2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.

  
**ГҮМЭНЖИВЭНГ ДЭВЭГЖАВ**  
 (Гүйцэтгэх захирал)

  
**ГАНЗӨРИГИЙН ЭРДЭНЭБАЯР**  
 (Санхүү хариуцсан захирал)

**Тайлан бэлтгэх үндэслэл.** Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

## Санхүүгийн байдлын хураангуй тайлан

	2023 МЯН.ТӨГ	2022 МЯН.ТӨГ
<b>ХӨРӨНГӨ</b>		
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	358,359,279	431,341,650
Монголбанк дахь заавал байлгах нөөц	239,378,375	255,682,837
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	56,800,918	107,798,730
Санхүүгийн хэрэгслүүд	110,309,146	83,897,165
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	93,116,520	102,764,818
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө		
Өмчийн хэрэгслүүд	5,052,206	4,682,289
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө		
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	393,769,064	282,232,458
Урвуу репо хэлцэл	99,740,669	–
Өрийн хэрэгслүүд	960,070,624	596,387,687
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,627,234,410	1,900,052,627
Бусад хөрөнгө	71,277,148	71,527,286
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	1,387,250	2,063,167
Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө	75,388,849	68,221,257
Биет бус хөрөнгө	18,667,114	18,895,588
Хойшлогдсон татварын хөрөнгө	8,870,069	5,232,744
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,119,421,641</b>	<b>3,930,780,303</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ</b>		
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	14,332,115	1,639,595
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр		
Репо хэлцэл	149,611,113	–
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	36,937,419	51,866,980
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,876,117,299	2,438,619,569
Зээлээр авсан санхүүжилт	1,238,768,595	857,363,227
Хойшлогдсон нөхцөлт хандив	12,564,957	7,970,706
Түрээсийн өр төлбөр	7,675,609	5,310,092
Бусад өр төлбөр	131,592,516	68,482,406
Орлогын албан татварын өглөг	29,759,280	23,840,068
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,497,358,903</b>	<b>3,455,092,643</b>
<b>ЭЗНИЙ ӨМЧ</b>		
Энгийн хувьцаа	105,270,000	100,000,000
Нэмж төлөгдсөн капитал	30,586,768	1,817,773
Нөөцүүд	86,418,906	95,708,103
Хуримтлагдсан ашиг	399,787,064	278,161,784
<b>НИЙТ ЭЗНИЙ ӨМЧ</b>	<b>622,062,738</b>	<b>475,687,660</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ</b>	<b>5,119,421,641</b>	<b>3,930,780,303</b>





**ХАСБАНК**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 15 өдөр

№ R-2024-19

Улаанбаатар хот

ХасБанкны 2023 оны санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу, ХасБанк ХК-ийн ("ХасБанк") Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн хэлэлцүүлгийг үндэслэн:

**ТЭМДЭГЛЭХ нь:**

- ХасБанкны 2023 оны санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-ын дагуу гаргаж, Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК хянасан ("2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан") ба ийнхүү хянаад тайланг зөрчилгүй гэж дүгнэсэн болохыг;
- ХасБанкны Аудитын хороо 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцээд 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг батлахыг ТУЗ-д санал болгосныг;
- ТУЗ нь 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг Аудиторын дүгнэлтийн хамт хянан хэлэлцсэнийг; мөн
- ТУЗ нь 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан нь ХасБанкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу үнэн зөв бөгөөд бодитоор тайлагнасан гэж дүгнэснийг ("ТУЗ-ийн дүгнэлт") тус тус дурдав.

**ТОГТООХ нь:**

- ХасБанкны 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт ХасБанкны хувьцаа эзэмшигчдэд өргөн мэдүүлэхээр баталсугай.
- Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нарт 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд гарын үсэг зурах эрх олгосугай.
- Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нарт 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, удахгүй болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэж танилцуулах зэрэг энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



## **Хурлаар танилцуулах асуудал:**

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАЙЛАН



Миний бие ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс тайлан танилцуулж байна.

ХасБанк 2023 онд санхүүгийн хувьд гайхалтай үр дүнд хүрсэн. Татварын дараах цэвэр ашиг 142 тэрбум төгрөгт хүрч, түүхэн дээд амжилт тогтоосон байна. Санхүүгийн бүх гол үзүүлэлтүүд нь өнгөрсөн оны үнэт цаасны танилцуулгад тусгасан төлөвлөгөөт тоонуудыг давсан байна. Энэхүү онцгой үр дүн үзүүлэхийн зэрэгцээ, чанаргүй зээлийн харьцааг салбартаа тэргүүлэхүйц бага түвшинд

байлгаж, жилийн эцсийн байдлаар 2.9% болгосон. Мөн ХасБанк 2023 онд IPO амжилттай хийж хувьцаагаа олон нийтэд санал болгосон нь онцлох үйл явдал болсон. Энэхүү гайхалтай гүйцэтгэлд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн зүгээс Гүйцэтгэх захирал болон удирдлагын баг хамт олонд талархаж байна.

Түүнчлэн, Банк нь дижитал технологид үргэлжлүүлэн хөрөнгө оруулж, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн, шинэлэг бүтээгдэхүүнээ хүргэхийг зорьж ажиллаж байгааг тэмдэглэмээр байна. ТУЗ саяхан банкны стратегийг хэлэлцэх зорилтот уулзалт зохион байгуулж, үндсэн үзүүлэлтүүдээр цаашид үргэлжлүүлэн өсөхөд шаардлагатай урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг ярилцлаа.

Банк 2023 оны эхний хагас жилд 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан ба удирдлагын зүгээс 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 26.6 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлүүлэх гэж байна. Ийнхүү ХасБанк 2023 оны хувьд нийт 42.1 тэрбум төгрөгийг тарааж буй нь нийт цэвэр ашгийн ~30%-тай тэнцэж байна. Энэхүү ногдол ашгийн хэмжээ нь Банкны түүхэн дэх хамгийн өндөр дүн бөгөөд санал болгож буй хэмжээ нь IPO танилцуулгын төлөвлөгөөтэй нийцэж байна. Хараат бус гишүүдийн зүгээс тус ногдол ашгийн хэмжээг тохиромжтой гэж үзэж, энэ саналыг дэмжсэн.

Хараат бус гишүүд бид банкинд компанийн сайн засаглалыг сахин хамгаалахад дэмжлэг үзүүлсээр ирсэн. Одоогоор, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 3 Хараат бус гишүүн ажиллаж байна. Бүх хараат бус гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх 3 Хороодын гишүүд бөгөөд хороо тус бүрийн 2/3-ыг бүрдүүлдэг. Уламбаяр миний бие, 2022 оноос хойш ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар ажиллаж байна. Энэ удаагийн банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын үр дүнд, ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь хуулийн шаардлагыг хангасан нийт 4 хараат бус гишүүнтэй болно гэж итгэж байна.

Банкны засаглал, ашиг сонирхлын зөрчил болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувьд, ТУЗ болон удирдлагын хүрээнд ямар нэгэн ноцтой асуудал илрээгүй болохыг тэмдэглэж байна.

Өнгөрсөн жил ТУЗ-ийн хурлаар, олон улсын санхүүгийн байгууллагууд болох ЕСБХБ, ОУСК-тай байгуулах бодлогын гэрээ, хэлэлцээрийн талаар танилцаж хэлэлцсэн. Хараат бус гишүүдийн зүгээс, тус саналыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд оруулан хувьцаа эзэмшигчдээр эцэслэн шийдвэрлүүлэх ТУЗ-ийн дүгнэлтийг дэмжсэн.

Банкны тухай хуулийг дагаж мөрдөхийн тулд, Банк өөрийн толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг өөртөө нэгтгэх нь нэн чухал байна. Энэ асуудалд хувьцаа эзэмшигчдээс анхаарал хандуулж, цаг алдалгүй шийдвэрлэж өгөхийг хүсч байна.

Эцэст нь, Хараат бус гишүүдийн зүгээс ТУЗ-ийн бүх шийдвэртэй санал нийлж, дэмжсэн болохыг тэмдэглэж байна.

Баярлалаа.

ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн

Хараат бус гишүүн

**Б.Уламбаяр**



## **Хурлаар шийдвэрлэх гуравдугаар асуудал:**

**ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас  
ногдол ашиг хуваарилах тухай**


# Агуулга

2023 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах санал

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг болон ХасБанк ХК-ийн дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг үндэслэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар ногдол ашиг тараахыг санал болгож байна.

Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашиг	25.25 төгрөг
Ногдол ашгийн нийт дүн	26,580,675,000 төгрөг
Ногдол ашиг тараах огноо	2024 оны 5-р сар: холбогдох бүх шийдвэр, зөвшөөрөл гарснаар
Ногдол ашиг тараах хэлбэр	ҮЦТХТ-өөр дамжуулан нэрийн дансаар
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийг Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоох.


## Ногдол ашиг тараах хугацаа



\*Банк нь ногдол ашиг тараах эсэх асуудалд зөвшөөрөл авахаар Монголбанкинд 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдөр холбогдох журмын дагуу хүсэлт гаргасан бөгөөд 60 хоногийн дотор Монголбанкнаас албан хариу авахаар тооцож байна.

## Ногдол ашиг олгох харьцаа

ХасБанк нь 2023 оны 1-р хагас жилийн цэвэр ашгаас 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан бөгөөд 2023 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас 26.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар санал болгож байна. Ингэснээр 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашгийн 30%-ийг ногдол ашиг хэлбэрээр тарааж, Үнэт цаасны танилцуулгад тусгасан зорилтыг биелүүлж байна.



\* ХасЛизинг ХХК нь ХасБанк ХХК-д 2021 онд нэгдсэн бөгөөд ХасБанкны санхүүгийн тайланг бэлтгэхдээ ХасЛизинг ХХК-ийн санхүүгийн үзүүлэлтийг 2020 оноос эхлэн нөлөөлүүлж, толилуулсан болно. Энэ талаар ХасБанкны аудитлагдсан тайлангийн №11-12 хуудаснаас үзнэ үү.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2024 оны 02 сарын 19 өдөр

№ R-2024-02

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 болон 46.5 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалт болон Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

#### ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 болон 46.8 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх талаар санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэх шаардлагатай болохыг;
2. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2023 оны санхүүгийн жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (“Ногдол ашиг”)-ыг ТУЗ-д санал болгосныг;
4. Хуваарилах ногдол ашгийн хэмжээ нь 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан гарсны дараа бүрэн тодорхойлогдох боломжтой болохыг; мөн
5. ТУЗ нь 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

#### ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан Ногдол ашигт нийт 26,580,675,000.00 (хорин зургаан тэрбум таван зуун наян сая зургаан зуун далан таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 25.25 (хорин таван төгрөг хорин таван мөнгө) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

ХасБанкны төв байр,  
Ерөнхий сайд Амарын гудамж,  
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,  
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888  
Утас: 7577-1888  
Веб: www.xacbank.mn  
И-мэйл: info@xacbank.mn



3. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойших 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлж эхэлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A black ink signature, likely belonging to Н.Мөнхцэлмэг.

Н.МӨНХЦЭЛМЭГ



## **Хурлаар шийдвэрлэх дөрөвдүгээр асуудал:**


Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

## ХАСБАНК ХК-ИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46.1 дэх хэсэгт ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) гаргахаар заасан байдаг.

Түүний дагуу ХасБанк ХК-ийн Дүрэм (“Банкны Дүрэм”)-ийн 6.5 дахь хэсэг, 8.6 (ii) дахь заалтад зааснаар ногдол ашиг тараах болон хуваарилах асуудлыг эцэслэн шийдвэрлэх эрхийг хувьцаа эзэмшигчид эдэлдэг.

Дээрх зохицуулалтын дагуу ногдол ашиг тараах үйл явцыг зураглалаар харуулбал ХасБанкны ногдол ашиг хуваарилах эцсийн шийдвэр 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногуудад гардаг ба ногдол ашгийн тараалт, дансанд шилжүүлэх үйл ажиллагаа түүнээс хойш хийгдэхээр байна.



Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”) 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр 49 дүгээр тогтоол гаргаж, 2020 оны 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолдоо өөрчлөлт оруулан, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор тарааж дууссан байхыг үүрэг болгосон.

Шинэ зохицуулалтыг дагаж мөрдөн СЗХ-ноос тогтоосон хугацаанд ногдол ашгийг тараахад ХасБанкны Дүрэм болон Ногдол ашгийн бодлогод зааснаар хувьцаа эзэмшигчдээс эцсийн зөвшөөрөл авах шаардлагатай байгаа нь практикт ихээхэн хүндрэл учруулж байгаа тул Банкны Гүйцэтгэх удирдлагын зүгээс Банкны Дүрэмд өөрчлөлт оруулж, ногдол ашиг зарлах, хуваарилах асуудлыг ТУЗ-ийн бүрэн эрхэд шилжүүлэх саналаа илэрхийлсэн бөгөөд үүнийг ХасБанкны ТУЗ 2024 оны R-2024-17 тоот тогтоолоороо дэмжсэн болно.

Иймээс СЗХ-ны шаардлагад нийцүүлэх үүднээс Банкны Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, 8 дугаар зүйлийн 8.6 (ii) дахь заалтыг хүчингүй болгохыг Хувьцаа эзэмшигчдэд санал болгож байна.

Одоогийн заалт	Өөрчлөлт оруулсан заалт
<p>6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.</p>	<p>6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс <del>тогтоож</del>, <del>Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны</del> <u>шийдвэрлэсний</u> үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.</p>
<p>8.6 Дор дурдсан асуудлыг энэхүү Дүрэмд заасан “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ. Стратегийн ач холбогдол бүхий асуудлын талаар аливаа шийдвэрийг гагцхүү ТУЗ-өөр хэлэлцсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна: (ii) ногдол ашиг тараах болон хуваарилах аливаа шийдвэр;</p>	<p>8.6 Дор дурдсан асуудлыг энэхүү Дүрэмд заасан “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ. Стратегийн ач холбогдол бүхий асуудлын талаар аливаа шийдвэрийг гагцхүү ТУЗ-өөр хэлэлцсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна: (ii) <del>ногдол ашиг тараах болон</del> <del>хуваарилах аливаа шийдвэр;</del></p>



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 24 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-17

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрийн хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны хувьцаа эзэмшигчид өмнө нь ХасБанк ХК-ийн Дүрэм (“Банкны Дүрэм”)-ийг SR-2023-22 дугаартай тогтоолоор баталсан болохыг;
- Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолдоо өөрчлөлт оруулж, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор СЗХ-нд ирүүлэхийг үүрэг болгосныг;
- СЗХ нь 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 3/712 тоот албан бичгээрээ нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Банкинд үүрэг болгосныг;
- Банкны хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дүрэмд заасны дагуу ногдол ашиг тараах эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэдэг бөгөөд энэ нь СЗХ-ноос тогтоосон ногдол ашиг хуваарилах, тайлагнах үүрэгт хугацааг дагаж мөрдөхөд бэрхшээл үүсгэж байгааг; мөн
- Гүйцэтгэх удирдлага нь СЗХ-ны тогтоосон журмыг дагаж мөрдөх зорилгоор Компанийн тухай хуулийн 46.1 дэх хэсгийг харгалзан ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргах бүрэн эрхэд холбогдуулан Банкны Дүрэмд дараах өөрчлөлт оруулахыг санал болгосныг тус тус тэмдэглэв.

### ТОГТООХ нь:

- Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Банкны Дүрмийн 6.5 дахь хэсэгт дараах байдлаар өөрчлөлт оруулсугай:

Одоогийн заалт	Өөрчлөлт оруулсан заалт
6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд	6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд

ХасБанкны төв байр,  
Ерөнхий сайд Амарын гудамж,  
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,  
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888  
Утас: 7577-1888  
Веб: www.xacbank.mn  
И-мэйл: info@xacbank.mn

ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны шийдвэрлэсний үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.

ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн журлаас баталсны шийдвэрлэсний үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.

2. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг хүчингүй болгосугай.
3. Банкны Дүрэмд оруулах дээр дурдсан өөрчлөлтүүдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ






## **Хурлаар шийдвэрлэх тавдугаар асуудал:**

Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тухай

## ХАСБАНК ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГОД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод зааснаар ногдол ашиг тараах болон хуваарилах асуудлыг эцэслэн шийдвэрлэх эрхийг хувьцаа эзэмшигчид эдэлдэг.

Дээрх зохицуулалтын дагуу ногдол ашиг тараах үйл явцыг зураглалаар харуулбал ХасБанкны ногдол ашиг хуваарилах эцсийн шийдвэр 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногуудад гардаг ба ногдол ашгийн тараалт, дансанд шилжүүлэх үйл ажиллагаа түүнээс хойш хийгдэхээр байна.



Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ") 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр 49 дүгээр тогтоол гаргаж, 2020 оны 28 дугаар "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолдоо өөрчлөлт оруулан, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор тарааж дууссан байхыг үүрэг болгосон.

Шинэ зохицуулалтыг дагаж мөрдөн СЗХ-ноос тогтоосон хугацаанд ногдол ашгийг тараахад ХасБанкны Дүрэм болон Ногдол ашгийн бодлогод зааснаар хувьцаа эзэмшигчдээс эцсийн зөвшөөрөл авах шаардлагатай байгаа нь практикт ихээхэн хүндрэл учруулж байгаа тул Банкны Гүйцэтгэх удирдлагын зүгээс Банкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулж, ногдол ашиг зарлах, хуваарилах асуудлыг ТУЗ-ийн бүрэн эрхэд шилжүүлэх саналаа илэрхийлсэн бөгөөд үүнийг ХасБанкны ТУЗ 2024 оны R-2024-18 тоот тогтоолоороо дэмжсэн болно.

Иймээс СЗХ-ны шаардлагад нийцүүлэх үүднээс Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулахыг Хувьцаа эзэмшигчдэд санал болгож байна.

Одоогийн заалт	Өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулсан заалт
<p>3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</p> <p>3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй.</p> <p>4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ.</p>	<p>3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <del>Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг</del> Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</p> <p>3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>шийдвэрлэсэнээр</u> шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй.</p> <p>4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ</u> шийдвэрлэнэ.</p>



**ХАСБАНК**

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-18

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод  
өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)–ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрийн хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны хувьцаа эзэмшигчид өмнө нь ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг SR-2024-01 дугаартай тогтоолоор баталсан болохыг (“Ногдол ашгийн бодлого”);
- Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолдоо өөрчлөлт оруулж, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор СЗХ-нд ирүүлэхийг үүрэг болгосныг;
- СЗХ нь 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 3/712 тоот албан бичгээрээ нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Банкнд үүрэг болгосныг;
- Гүйцэтгэх удирдлага нь СЗХ-ны тогтоосон журмыг дагаж мөрдөх зорилгоор Ногдол ашгийн бодлогод дараах өөрчлөлт оруулахыг санал болгосныг тус тус тэмдэглэв.

### ТОГТООХ нь:

- Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Ногдол ашгийн бодлогын 3.2, 3.3 болон 4.1 дүгээр хэсгүүдэд дараах өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт өөрчлөлт оруулсан заалт
3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах	3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа

ХасБанкны төв байр,  
Ерөнхий сайд Амарын гудамж,  
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,  
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888  
Утас: 7577-1888  
Веб: www.xacbank.mn  
И-мэйл: info@xacbank.mn

Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан  
ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тухай

шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. 3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэснээр шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй. 4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ шийдвэрлэнэ.	эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. 3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэснээр шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй. 4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ шийдвэрлэнэ.
---	--

2. Ногдол ашгийн бодлогод оруулах дээр дурдсан өөрчлөлтүүдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A black ink signature written in cursive.

Н.МӨНХЦЭЛМЭГ



## **Хурлаар шийдвэрлэх зургаадугаар асуудал:**

ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай – Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу



## **ХАСБАНК БОЛОН ЕСБХБ НАРЫН ХООРОНД ФРЕЙМВОРК ГЭРЭЭ БАЙГУУЛАХЫГ ЗӨВШӨӨРЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД ФРЕЙМВОРК ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХЫГ ДААЛГАХ ТУХАЙ**

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг ХасБанкны нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН")-ийг ХасБанкинд нэгтгэх замаар хангахаар, өөрчлөн байгуулалтын асуудлыг энэ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж байгаа билээ.

Нэгтгэх өөрчлөн байгуулалтыг хийснээр ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний үйлчлэл зогсох юм. Уг гэрээгээр ХасБанк нь ТСН-ийн охин компанийн хувьд ТСН-ийн онцлог бүхий хувьцаа эзэмшигчид буюу олон улсын санхүүгийн байгууллагууд болох Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ"), Олон Улсын Санхүүгийн Корпораци ("ОУСК") нарын байгаль орчин, нийгмийн асуудал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, авлигын эсрэг зэрэг комплайнсын бодлого журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг ба ийнхүү нэгтгэлийн дараа ЕСБХБ, ОУСК-ийн бодлого журмыг мөрдөх үүргийг ХасБанкинд үргэлжлүүлэн хүлээлгэхийн тулд ЕСБХБ, ОУСК нар олон улсын санхүүгийн байгууллага болохын хувьд тусгайлан гэрээ байгуулах хүсэлтийг гаргасан.

ТСН нь уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцэн дэмжээд ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахыг ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлд албан ёсоор хүсэлт тавьж, эдгээр гэрээг байгуулсан нөхцөлд Нэгтгэх гэрээг байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Хүсэлтийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны R-2024-13 дугаар тогтоолоороо Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад ЕСБХБ-тай Фреймворк гэрээ байгуулах зөвшөөрлийг ХасБанкинд олгох, Фреймворк гэрээг ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулсан өдөр эсхүл түүнээс өмнө байгуулж, гарын үсэг зурахыг ХасБанкны Гүйцэтгэх захиралд даалгах тухай асуудлыг оруулсан болно.

Иймд ХасБанк нь, Нэгтгэх өөрчлөн байгуулалтыг хийх замаар Хуулийн шаардлагыг цаг алдалгүй хангах зорилгоор, ТСН-ийн тавьж буй шаардлага болох ЕСБХБ-тай байгуулахаар санал болгосон Фреймворк гэрээний төслийг хувьцаа эзэмшигчиддээ ийнхүү танилцуулж байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2024 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-13

Улаанбаатар хот

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд зарим асуудал нэмж оруулах тухай

ХасБанк ХК ("ХасБанк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТҮЗ")-ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрийн хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ нь:

- ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН") нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг ("Хуулийн шаардлага");
- ХасБанкны хувьцаа эзэмшигчид өмнө нь SR-2023-01 дүгээр тогтоол гаргаж, ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх замаар энэхүү Хуулийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзсэн, нэгдлийн үр дүнд ХасБанк үйл ажиллагаагаа үргэлжлүүлж үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохыг ("Нэгтгэх өөрчлөн байгуулалт");
- ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх өөрчлөн байгуулалттай холбогдуулан, ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ")-тай Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпораци ("ОУСК")-тай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд, Нэгтгэх гэрээг байгуулахыг SGR-2024-03 дугаар тогтоолоороо шийдвэрлэсэн болохыг;
- ТСН нь дараах асуудлуудыг ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар санал оруулсныг ("Хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар санал болгосон асуудлууд"):
  - Нэгдлийн үр дүнд ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болох олон улсын санхүүгийн байгууллага ЕСБХБ-тай Фреймворк гэрээ байгуулах зөвшөөрлийг ХасБанкинд олгох, Фреймворк гэрээг ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулсан өдөр эсхүл түүнээс өмнө байгуулж, гарын үсэг зурахыг ХасБанкны Гүйцэтгэх захиралд даалгах тухай ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргуулах санал; мөн
  - Нэгдлийн үр дүнд ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болох олон улсын санхүүгийн байгууллага ОУСК-тай Бодлогын гэрээ байгуулах зөвшөөрлийг ХасБанкинд олгох, Бодлогын гэрээг ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулсан өдөр эсхүл түүнээс өмнө байгуулж, гарын үсэг зурахыг ХасБанкны

ХасБанкны төв байр,  
Ерөнхий сайд Амарын гудамж,  
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,  
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888  
Утас: 7577-1888  
Веб: www.xacbank.mn  
И-мэйл: info@xacbank.mn

**ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай**

Гүйцэтгэх захиралд даалгах тухай ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргуулах саналыг тус тус болно.

5. ТУЗ нь ХасБанкны хувьцааны 94.99%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч ТСН-ийн хүсэлтийг хүлээн авч, Хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар санал болгосон асуудлуудыг удахгүй болох ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

**ТОГТООХ нь:**

1. Хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар санал болгосон асуудлуудыг ирж буй ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай



Төсөл: 2024 оны 2-р сарын 8-ны өдөр

(Үйл ажиллагааны дугаар 38404)

**ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК**

болон

**ХАСБАНК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ**

хооронд байгуулсан

**ФРЕЙМВОРК ГЭРЭЭ**

2024 оны [ \_\_\_\_\_ ]-ны өдөр



## АГУУЛГА

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ – НЭР ТОМЬЁО .....	1
1.01 дэх хэсэг. Нэр томьёо .....	1
1.02 дахь хэсэг. Тайлбар .....	3
ХОЁРДУГААР ЗҮЙЛ – МЭДЭГДЭЛ БОЛОН БАТАЛГАА .....	4
2.01 дэх хэсэг. Энэхүү Гэрээний талаарх мэдэгдэл .....	4
ГУРАВДУГААР ЗҮЙЛ – ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ .....	5
3.01 дэх хэсэг. Байгаль орчин, нийгмийн нийцэл .....	5
3.02 дахь хэсэг. Дотоод журам .....	5
3.03 дахь хэсэг. Мэдээллээр хангах .....	5
3.04 дэх хэсэг. Мэдээллийг ил болгох .....	6
3.05 дахь хэсэг. Залилан, Авлига .....	6
3.06 дахь хэсэг. Худалдан авах ажиллагаа .....	6
ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ – БУСАД ЗҮЙЛ .....	6
4.01 дэх хэсэг. Мэдэгдэл .....	6
4.02 дахь хэсэг. Англи хэл .....	7
4.03 дахь хэсэг. Зохицуулах хууль .....	7
4.04 дэх хэсэг. Арбитр болон харьяалал .....	7
4.05 дахь хэсэг. ЕСБХБ-ны эрх ямба, дархан эрх .....	8
4.06 дахь хэсэг. Эрх залгамжлагч, Эрх хүлээн авагч; Гуравдагч этгээдийн эрх .....	9
4.07 дахь хэсэг. Бүх тохиролцоо; Нэмэлт өөрчлөлт, Татгалзал .....	9
4.08 дахь хэсэг. Бүрэн эрхт, дархан эрхээс татгалзах .....	9
4.09 дэх хэсэг. Гэрээний хувь .....	10



## ФРЕЙМВОРК ГЭРЭЭ

Энэхүү Фреймворк гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г 2024 оны [ ]-ны өдөр дийд гэрээгээр:

- (1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа нээлттэй хувьцаат компани болох **ХАСБАНК ХК** (цаашид “Компани” гэх); болон
- (2) Олон улсын хэлэлцээрийн дагуу үүсгэн байгуулагдсан олон улсын байгууллага болох **ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК** (цаашид “ЕСБХБ” гэх) нар байгуулав.

### ДОР ДУРДСАНЫГ:

(А) Компани нь Банкны тухай хуулийн холбогдох шаардлагыг ханган 2023 оны 5-р сарын 12-ны өдрийн үнэт цаасны танилцуулга (цаашид “Танилцуулга” гэх)-д заасны дагуу шинээр гаргасан энгийн хувьцаагаа нийтэд санал болгон анх удаа (цаашид “Нийтэд санал болгох” гэх) гарган олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон. Нийтэд санал болгосны дараа, Компанийн нийт гаргасан болон зарласан хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх)-г Монгол Улсын Улаанбаатар хот дахь Монголын Хөрөнгийн Биржээр нийтэд арилжаалсан болохыг,

(В) ЕСБХБ нь Хувьцааны 94.99%-ийн эзэмшигч Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (цаашид “ТСН” гэх)-ийн нийт гаргасан болон зарласан хувьцааны 13.15%-ийг эзэмшдэг. Нийтэд санал болгосны дараагаар Банкны тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн, ТСН-ийг Компанитай нэгтгэж буйд холбогдуулан (цаашид “Нэгтгэл” гэх), энэхүү Гэрээг байгуулах өдөр эсхүл түүнтэй ойролцоо өдөр байгуулах ТСН болон Компанийн нэгтгэх гэрээнд заасан харьцаа үзүүлэлтийн дагуу ТСН-д эзэмшиж буй хувьцааг хувь тэнцүүлэн Хувьцаанд хөрвүүлэх (цаашид “Хөрвүүлэлт” гэх)-ийг ТСН-ийн хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг,

(С) Компани нь ЕСБХБ-ны холбогдох бодлого, шаардлагуудыг дагаж мөрдөхийг зөвшөөрч байгаа болохыг,

**ТУС ТУС ТЭМДЭГЛЭН**, талууд дор дурдсаныг харилцан тохиролцов:

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ – НЭР ТОМЬЁО

### 1.01 дэх хэсэг. Нэр томьёо


Энэхүү Гэрээ болон Хавсралтуудад хэрэглэсэн дараах нэр томьёо нь агуулгын хувьд өөрөөр илэрхийлэгдээгүй бол дор дурдсан утгыг илэрхийлнэ:



ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай



“Харилцан хамаарал бүхий этгээд”	гэж аливаа этгээдийн хувьд шууд болон шууд бусаар хянадаг, хяналтад нь байдаг эсхүл түүнтэй хамт нэгдмэл хяналтад байдаг аливаа этгээдийг хэлнэ.
“Банкны тухай хууль”	гэж Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 1-р сарын 28-ны өдөр батлагдсан, тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Банкны тухай хуулийг хэлнэ.
“Тодорхой гүйцэтгэлийн шаардлагууд”	гэж ЕСБХБ-ны 2019 оны 4-р сарын Гүйцэтгэлийн шаардлагуудын 2, 4, 9 дүгээр Гүйцэтгэлийн шаардлагууд (эсхүл агуулгад зааснаар тухайн Гүйцэтгэлийн шаардлагуудын аль нэг нь) болон 2019 оны 4-р сарын Байгаль орчин, нийгмийн бодлоготой холбоотой шаардлагуудыг хэлнэ.
“ЕСБХБ-ны Хувьцаа”	гэж Хөрвүүлэлтийн үр дүнд ЕСБХБ-ны авах, эзэмших Хувьцааг хэлнэ.
“Албадан хэрэгжүүлэх бодлого, журам”	гэж ЕСБХБ-ны 2017 оны 10-р сарын 4-ний өдрийн Албадан хэрэгжүүлэх бодлого, журмыг хэлнэ.
“Байгаль нийгмийн тогтоомж”	орчин, хууль гэж байгаль орчин, ажилтнууд, нийгмийн бүлгүүд, төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хамгаалахтай холбоотой аливаа улсын холбогдох хууль тогтоомжийг хэлнэ.
“Байгаль нийгмийн асуудал”	орчин, гэж Байгаль орчин, нийгмийн хууль тогтоомжид хамаарах аливаа асуудлыг хэлнэ.
“Санхүүгийн жил”	гэж жил бүрийн 1-р сарын 1-ээс эхэлж, 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болох хугацааг эсхүл Компаниас тухай бүр Компанийн нягтлан бодох бүртгэлийн жилээр тогтоосон бусад хугацааг хэлнэ.
“ТХХБМ”	гэж 2019 оны 4-р сарын Төслийн хариуцлагын бодлогод тусгагдсан тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчилсэн ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизмыг хэлнэ.
“Материаллаг мэдээлэл”	гэж Компани, Компанийн нийтэд арилжаалсан үнэт цаастай шууд болон шууд бусаар холбогдох нийтэд ил болоогүй, хэрэв нийтэд ил болговол тухайн үнэт цаас, холбогдох үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх эсхүл үнэт цаасны зах зээлд тогтмол оролцогч нь тухайн үнэт цаасыг арилжаалах хэлцлийн нөхцөлийг тодорхойлоход ач холбогдолтой мэдээллийг хэлнэ.



“Нийтэд санал болгох”	гэдэг нь дээр дурдсан удиртгал хэсгийн (А)-д заасан утгатай байна.
“Парисын хэлэлцээр”	гэж Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцод нэгдэн орсон улсуудын 21 дэх удаагийн бага хурлаар баталсан олон улсын хэлэлцээрийг (FCCC/CP/2015/10/Add.1) хэлнэ.
“Хориотой ажиллагаа”	үйл гэдэг нь энэхүү Гэрээг байгуулсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Албадан хэрэгжүүлэх бодлого, журамд тодорхойлсон утгыг агуулна.
“Танилцуулга”	гэдэг нь дээр дурдсан удиртгал хэсгийн (А)-д заасан утгатай байна.
“Хувьцаа”	гэдэг нь дээр дурдсан удиртгал хэсгийн (А)-д заасан утгатай байна.
“Нийгмийн төслүүд”	гэж Тогтвортой Бондын Баримт бичигт тодорхойлсон холбогдох нийгмийн шалгууруудыг хангасан төсөл, хөрөнгийг хэлнэ.
“НҮБ-ОУХЭЗК-ын дүрэм”	гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрхийн комиссын Арбитрын дүрэм (2010 онд шинэчилсэн)-ийг хэлнэ.
“Ам. доллар” буюу “доллар”	гэж Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг хэлнэ.

#### 1.02 дахь хэсэг. Тайлбар

- (a) Агуулгын хувьд өөрөөр илэрхийлээгүй бол, энэхүү Гэрээний ганц тоо нь олон тоог, олон тоо нь ганц тоог илэрхийлэх бөгөөд этгээдүүд гэдэгт корпораци, нөхөрлөл, бусад хуулийн этгээд хамаарах бол этгээд гэдэгт түүний эрх залгамжлагчид, зөвшөөрөгдсөн шилжүүлэн авагчид, зөвшөөрөгдсөн эрх хүлээн авагчид хамаарна.
- (b) Энэхүү Гэрээнд Зүйл, Хэсэг, Хавсралтыг иш татсан бол энэхүү Гэрээний Зүйл, Хэсэг, Хавсралтыг иш татсан гэж ойлгоно.
- (c) Энэхүү Гэрээнд гарчиг болон гэрээний Агуулгыг зөвхөн иш татахад хялбар болгох үүднээс оруулсан бөгөөд эдгээр нь Гэрээг тайлбарлахад нөлөөлөхгүй.
- (d) Энэхүү Гэрээний "хууль" гэдэгт аливаа холбогдох улсын хуулийн хүчин төгөлдөр буюу дагаж мөрдөх нь тухайн улсын нийтлэг практикт нийцсэн аливаа хууль (нийтлэг эрх зүйн болон заншлын хэм хэмжээ зэрэг), хэлэлцээр, үндсэн



хууль, батлагдан гарсан хууль, хууль тогтоомж, тогтоол, хэм хэмжээний акт, дүрэм, журам, шүүхийн шийдвэр, тушаал, гүйцэтгэх хуудас, хориг, шийдэл, арбитрын шийдвэрийг хэлнэ.

(е) Энэхүү Гэрээнд хуулийн аливаа заалтыг иш татсан бол тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан заалтыг иш татсанд ойлгоно.

(f) Энэхүү Гэрээнд заасан "этгээдүүд" гэдэгт аливаа хувь хүн, хуулийн этгээд, фирм, компани, корпораци, засгийн газар, улс, засгийн газрын агентлаг, ямар нэг холбоо, траст, нөхөрлөл (тусдаа хуулийн этгээдийн эрхтэй эсэхээс үл хамааран) эсхүл хоёр ба түүнээс дээш тооны дээр дурдсан этгээдүүд хамаарах бөгөөд "этгээд" гэдэгт түүний эрх залгамжлагчид, зөвшөөрөгдсөн шилжүүлэн авагчид, зөвшөөрөгдсөн эрх хүлээн авагчид хамаарна.

(g) Энэхүү Гэрээнд "үүнд хамаарах" ба "хамаарах" гэсний араас "үүгээр хязгаарлагдахгүйгээр" гэж заагаагүй ч гэсэн эдгээр үгсийн араас "үүгээр хязгаарлагдахгүйгээр" гэж заасанд тооцно.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ – МЭДЭГДЭЛ БОЛОН БАТАЛГАА

### 2.01 дэх хэсэг. Энэхүү Гэрээний талаарх мэдэгдэл

Компани нь дараах мэдэгдэл, баталгааг гаргаж байна.

(a) **Компанийн бүрэн эрх.** Компани нь энэхүү Гэрээг байгуулах, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болно.

(b) **Шаардлагатай зөвшөөрөл; Хэрэгжилт.** Энэхүү Гэрээ нь Компанийн зохих ёсны зөвшөөрлийн үндсэн дээр байгуулагдсан бөгөөд Компанийн хувьд хүчин төгөлдөр, хууль ёсны, заавал биелэгдэх шинжтэй үүргийг агуулж энд заасан нөхцөлийн дагуу хэрэгжинэ.

(c) **Хориотой үйл ажиллагаа явуулахгүй байх.** Компани нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Компани нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн VII бүлгийн дагуу аливаа эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ, эсвэл хязгаарлалтын арга хэмжээнд ороогүй (эсвэл өөр бусад байдлаар хамаарахгүй) бөгөөд Компани нь тийнхүү аливаа эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалтын арга хэмжээнд орсон этгээдийн эзэмшил (шууд болон шууд бусаар) болон хяналтад байдаггүй, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаггүй болно. Компанийн зохих ёсоор, анхааралтай шалгасны үндсэн дээр мэдэж байгаагаар аливаа эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалтын арга хэмжээнд орсон этгээд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 ба түүнээс дээш хувийг (шууд болон шууд бусаар) эзэмшдэггүй болно. Компани, компанийн аливаа албан тушаалтан, ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий ажилтан, Харилцан хамаарал бүхий этгээд, агент, төлөөлөгч нар нь Нийтэд санал болгох, Нэгтгэл, энэхүү Гэрээнд заасан аливаа хэлцэлтэй холбоотойгоор Хориглосон үйл ажиллагаа явуулаагүй, хэрэгжүүлээгүй болно.



(d) **Төлбөрийн хязгаарлалт.** Компани нь Хувьцаатай холбоотойгоор төлөх шаардлагатай аливаа төлбөрийг материаллаг байдлаар хориглох, хязгаарлах, хойшлуулах үр дагавартай буюу үр дагаварт хүргэхүйц аливаа зохицуулалт, хууль (үүнд хориг арга хэмжээг хамруулан)-ийн үйлчлэлд хамаарахгүй болно.

### ГУРАВДУГААР ЗҮЙЛ – ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

Энд заасан өдрөөс хойш болон ЕСБХБ нь ЕСБХБ-ны Хувьцааг эзэмшиж байгаа нөхцөлд ЕСБХБ өөрөөр зөвшөөрөөгүй бол:

#### 3.01 дэх хэсэг. Байгаль орчин, нийгмийн нийцэл

(a) Компани нь Тодорхой гүйцэтгэлийн шаардлагуудын дагуу үйл ажиллагаагаа явуулах бөгөөд гэрээлэгч нараас тус шаардлагуудын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг шаардана.

(b) Компани нь санхүүгийн урсгалаа хүлэмжийн хийн ялгаруулалтыг бага байлгах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжилд хүрэхэд нийцүүлж, Компанийн санхүүжилтийн бүхий л үйл ажиллагааг Парисын хэлэлцээрийн зорилтуудад дэс дараатайгаар нийцүүлэн ажиллахад анхаарна.


#### 3.02 дахь хэсэг. Дотоод журам

Компанийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, залилан, болон бусад авлигын эсвэл хууль бус зорилгоор ашиглах хэрэгсэл болохоос урьдчилан сэргийлэх үүднээс Компани нь ЕСБХБ-ны шаардлагад нийцсэн дотоод журмуудтай байна.

#### 3.03 дахь хэсэг. Мэдээллээр хангах

(a) Компани нь боломжтой болмогц, гэхдээ ямар ч тохиолдолд Санхүүгийн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор тухайн Санхүүгийн жилийн хугацаанд Компани болон түүний үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн Байгаль орчин, нийгмийн асуудлын тухай ЕСБХБ-ны шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий тайланг ЕСБХБ-д хүргүүлнэ.

(b) Компани нь 2.01(c) болон 3.05 дахь хэсгийг зөрчсөн талаарх аливаа мэдээллийг олж авмагц ЕСБХБ-д нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв ЕСБХБ нь 2.01(c) хэсэг эсхүл 3.05 дахь хэсгийг зөрчсөн байж болзошгүй талаар Компанид мэдэгдсэн тохиолдолд Компани нь тус зөрчил гарсан эсэхийг дүгнэх үүднээс ЕСБХБ болон түүний төлөөлөгчидтэй үнэнч шударгаар хамтран ажиллаж, дээрхтэй холбогдуулан, ЕСБХБ-ны үндэслэл бүхий хүсэлтийн дагуу мэдээллийг ЕСБХБ-д нэн даруй олгож, мөн шаардлагатай бол ЕСБХБ-ны үндэслэл бүхий хүсэлтийн дагуу ЕСБХБ-ны төлөөлөгчдөд (үүнд ЕСБХБ-ны зөвлөхүүд хамаарна) Компанийн үйл ажиллагаа явуулж буй аливаа байранд нэвтэрч, хөрөнгө, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгүүд, данс, бүртгэлтэй танилцахыг зөвшөөрнө (үүнд (i) ЕСБХБ-наас Компанийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, ТХХБМ-д өгсөн Компанитай холбоотой аливаа хүсэлтийг шалгаж, шийдвэрлэх боломжийг ЕСБХБ-д олгох, мөн (ii) Компанийн үйл ажиллагаа эсхүл энд дурдсан хэлцэлтэй холбоотой Хориотой үйл ажиллагаа явагдсан эсэхийг үнэлэх хамаарна).



### 3.04 дэх хэсэг. Мэдээллийг ил болгох

Компани болон ЕСБХБ нь Компани холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу Материаллаг мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэйг, мөн гагцхүү 3.03(b) хэсгийн эхний өгүүлбэрт заасны дагуу болон холбогдох хуулийн дагуу тухайн мэдээллийг тайлагнаж байгаагаас бусад тохиолдолд, Компани нь энэхүү Гэрээний дагуу тайлагнах үүргийнхээ хүрээнд аливаа Материаллаг мэдээллийг нийтэд ил болох хүртэл, эсхүл холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу хязгаарлалтгүй болох хүртэл ЕСБХБ-д задруулахгүй гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа болно. Тус зорилгоор Компани нь энэхүү Гэрээний дагуу Компанийн тайлагнах үүргийн хүрээнд ЕСБХБ-д өгөх Материаллаг мэдээллийг холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу олон нийтэд мэдээлэх болон хязгаарлалтгүй болгохын тулд боломжит хүчин чармайлт гаргах үүрэг хүлээнэ.

### 3.05 дахь хэсэг. Залилан, Авлига

Компани нь өөрийн албан тушаалтан, ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий ажилтан, Харилцан хамаарал бүхий этгээд, агент, төлөөлөгчдөө энэхүү Гэрээ, Нийтэд санал болгох, Хөрвүүлэлт, Нэгтгэл зэрэгт тусгагдсан үйл ажиллагаа, хэлцэлтэй холбоотойгоор аливаа Хориотой үйл ажиллагаа явуулах эрхийг олгох, зөвшөөрөл олгохыг хориглоно. Энэхүү Гэрээний бусад заалтыг үл харгалзан, ЕСБХБ нь энэхүү Гэрээний дагуу хийх хэлцэлтэй холбоотой Хориотой үйл ажиллагаа (үүнд 2.01(c) хэсэг хамаарна)-ны талаарх мэдэгдэлтэй холбоотойгоор Албадан хэрэгжүүлэх бодлого, журмыг хэрэгжүүлж болохыг тус Компани үүгээр хүлээн зөвшөөрч байна.

### 3.06 дахь хэсэг. Худалдан авах ажиллагаа

Компани нь зах зээлийн үнээр бараа, үйлчилгээг зөв сонгож, худалдан авах ажиллагааны оновчтой аргыг ашиглаж, цаг ямагт хөрөнгө оруулалтаа үр ашигтайгаар хийнэ.


## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ – БУСАД ЗҮЙЛ

### 4.01 дэх хэсэг. Мэдэгдэл

Энэхүү Гэрээний дагуу ЕСБХБ буюу Компанид өгөх аливаа мэдэгдэл, бусад захидал харилцааг бичгээр үйлдэнэ. Энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол мэдэгдэл, хүсэлт, бусад захидал харилцааг талуудын дор дурдсан хаягаар гараар, агаарын шуудангаар эсвэл pdf буюу түүнтэй төстэй формат ашиглан цахим шуудангаар нөгөө талын хүргүүлэхээр зөвшөөрсөн доорх хаягт эсвэл талуудын доорхоос өөр хаягт хүргүүлэхээр мэдэгдсэн хаягт хүргүүлсэнээр тухайн мэдэгдэл, хүсэлт, бусад захидал харилцааг зохих ёсоор өгсөн, хүргүүлсэн гэж үзнэ.

#### Компанийн хувьд:

ХасБанк ХК  
Монгол Улс  
Улаанбаатар хот, Ерөнхий сайд Амарын гудамж,



Сүхбаатар дүүрэг, ХасБанкны төв байр

Хэнд: Гүйцэтгэх захирал, Гүмэнжавын Цэвэгжав

Цахим шуудан: [tsevegjav.g@xacbank.mn](mailto:tsevegjav.g@xacbank.mn)  
Утасны дугаар: +976 75771888

#### ЕСБХБ-ны хувьд:

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк  
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс  
Лондон E14 4BG  
Банкны гудамж 5

Хэнд: Үйл ажиллагааны удирдлагын хэлтэс - OpID дугаар: 38404

Цахим шуудан: [oad@ebrd.com](mailto:oad@ebrd.com)  
Утасны дугаар: +44 20 7338 6000

#### 4.02 дахь хэсэг. Англи хэл

Энэхүү Гэрээний дагуу үйлдэх, өгөх, хүргүүлэх бүх баримт бичиг, захидал харилцааг Англи хэл дээр үйлдэнэ. Хэрэв өөр хэл дээр үйлдэх бол Компанийн төлөөлөгчийн баталгаажуулсан Англи хэл дээрх орчуулгыг хавсаргах бөгөөд тухайн орчуулга нь Компани болон ЕСБХБ-ны баримтлах хувилбар байна.

#### 4.03 дахь хэсэг. Зохицуулах хууль

Энэхүү Гэрээг Английн хуулийн дагуу зохицуулж, тайлбарлана. Энэхүү Гэрээнээс эсхүл Гэрээтэй холбоотой үүссэн гэрээний бус аливаа үүргийг Английн хуулийн дагуу зохицуулж, тайлбарлана.

#### 4.04 дэх хэсэг. Арбитр болон харьяалал

(а) (1) Энэхүү Гэрээ, (2) Гэрээг зөрчих, цуцлах, хүчингүй болгох, эсвэл (3) энэхүү Гэрээнээс эсхүл Гэрээтэй холбоотой гэрээний бус үүргээс үүссэн аливаа маргаан, зөрчилдөөн, нэхэмжлэлийг НҮБ-ОУХЭЗК-ын дүрмийн дагуу арбитраар шийдвэрлүүлнэ. Нэг (1) арбитрчийн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд арбитрчийг томилох эрх бүхий байгууллага нь ЛОУАШ (Лондонгийн Олон Улсын Арбитрын Шүүх) байна. Арбитрын ажиллагаа явагдах газар нь Английн Лондон хот байх бөгөөд Англи хэл нь арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэл байна. Талууд үүгээр 1996 оны Арбитрын тухай хуулийн дагуу олгогдсон эрх, Английн шүүхүүдэд арбитрын шийдвэрийг давж заалдах эрх болон хуулийн урьдчилсан дүгнэлтийг гаргуулах эрхээсээ татгалзаж байгаа болно. НҮБ-ОУХЭЗК-ын дүрмийг үл харгалзан, арбитр нь ЕСБХБ-ны эсрэг түр арга хэмжээ авах, шийдвэр гарахаас өмнөх арга хэмжээг авах эрхгүй байх бөгөөд Компани нь аливаа шүүх эрх мэдлийн байгууллагаас тухайн арга хэмжээнүүдийг авахуулахаар шаардлага гаргахгүй байхаа зөвшөөрсөн. Арбитр нь ЕСБХБ (өөр ямарваа нэгэн тал бус)-






наас зохих ёсоор гаргасан энэхүү Гэрээнээс үүдэлтэй аливаа нэмэлт маргааныг арбитрын хянан шийдвэрлэх үйл явц, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамруулан авч үзэж, хянан шийдвэрлэж болох боловч дээр дурдсаныг үндэслэн аливаа бусад талууд болон өөр бусад маргааныг арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамруулан авч үзэж, хянан шийдвэрлэхгүй.

(b) 4.04(a) хэсгийг үл харгалзан энэхүү Гэрээ болон энэхүү Гэрээнээс үүссэн буюу Гэрээтэй холбоотой ЕСБХБ-ны аливаа эрхийг ЕСБХБ нь өөрийн сонголтоор Монгол Улсад байрлах Монгол Улсын шүүх болон бусад харьяалагдах шүүхэд хандан хэрэгжүүлж болно. ЕСБХБ-ны ашиг тусын тулд Компани нь энэхүү Гэрээнээс үүссэн буюу Гэрээтэй холбоотой, мөн Гэрээг зөрчих, цуцлах, хүчингүй болгохтой холбоотойгоор үүссэн аливаа маргаан, зөрчилдөөн, нэхэмжлэлээ шийдвэрлүүлэхээр гагцхүү Английн шүүхэд хандана. Компани нь [ ]-ыг өөрийн бүртгэлтэй хаягт (энэ өдрийн байдлаар Английн Лондон хотын [ ]-д байрладаг) арбитрын арга хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх, арбитрын ажиллагааг эхлүүлэх мэдэгдэл болон бусад хууль ёсны шаардлагыг Англид хүлээн авах эрх бүхий агентаар эргэлт буцалтгүйгээр сонгож, томилж, түүнд бүрэн эрхийг олгож байна. Шүүх, арбитрын ажиллагааг эхлүүлэх мэдэгдэл болон бусад хууль ёсны шаардлагын хуулбарыг энд заасан бүртгэлтэй хаягаар төлбөрийг урьдчилан төлсөн агаарын шуудангаар илгээхийг Компани эргэлт буцалтгүйгээр зөвшөөрч байгаа болно. Компани нь энэхүү Гэрээний дагуу ямар нэгэн үүрэг хүлээж байгаа тохиолдолд ЕСБХБ-наас Англид энэхүү Гэрээнд холбогдуулан үүсгэсэн хууль ёсны арга хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүх, арбитрын ажиллагааг эхлүүлэх мэдэгдэл болон бусад хууль ёсны шаардлагыг хүлээн авах зохих ёсоор томилогдсон агентыг ажиллуулах үүрэгтэй бөгөөд ажиллуулна гэдгээ хүлээн зөвшөөрнө. Мөн Компани нь ЕСБХБ-инд тухайн агентын мэдээлэл, байршлын талаар мэдээлнэ. Энд заасан ямар ч зүйл нь аливаа холбогдох шүүхийн харьяалал дахь хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн хэлбэрээр Компанийн эсрэг хууль ёсны арга хэмжээ авах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх ЕСБХБ-ны эрхийг хөндөхгүй. ЕСБХБ нэг буюу хэд хэдэн шүүхийн харьяаллын дагуу хууль ёсны арга хэмжээ авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн нь тухайн ажиллагааг явагдаж байх хугацаанд зэрэгцүүлэн эхлүүлсэн эсэхээс үл хамааран ЕСБХБ-ийг өөр бусад шүүхийн харьяаллын дагуу хууль ёсны арга хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхэд саад болохгүй. Компани нь хууль ёсны арга хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах газрыг тогтоохтой холбоотойгоор одоо болон дараа бий болох ямар нэгэн үндэслэл бүхий татгалзал болон тухайн хууль ёсны арга хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг харьяаллын бус газар гаргасан талаар одоо болон дараа шаардлага гаргахаас эргэлт буцалтгүйгээр татгалзана.

#### **4.05 дахь хэсэг. ЕСБХБ-ны эрх ямба, дархан эрх**

Энэхүү Гэрээ, Танилцуулга, Нийтэд санал болгох нөхцөл, шаардлага, Хөрвүүлэлт, Нэгтгэлтэй холбоотой гэрээнүүдэд заасан ямар ч зүйл нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкныг үүсгэн байгуулах гэрээ, олон улсын конвенц, аливаа холбогдох хуулийн дагуу ЕСБХБ-д олгогдсон аливаа эрх ямба, дархан эрх, чөлөөлөлтөөс түр эсхүл бүрмөсөн татгалзсан, түүнийг өөрчилсөн гэж үзэх үндэслэл болохгүй. Дээр дурдсаныг үл харгалзан, ЕСБХБ нь 4.04(a) хэсгийн дагуу арбитрын шүүхэд шууд хандахаар заасан бөгөөд үүний дагуу бусад эрх



ямба, дархан эрхэд нь халдахгүйгээр (үүнд түүний архивын халдашгүй дархан байдал хамаарах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй) 4.04(a) хэсэгт заасны дагуу арбитрын шүүхэд шууд хандсаны үр дүнд, ЕСБХБ-ны эсрэг зохих ёсоор гаргасан арбитрын шийдвэрийг биелүүлэхтэй холбоотойгоор 1991 оны Хууль ёсны баримт бичиг болох 757 тоот тогтоол (Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (Дархан эрх, эрх ямба))-ын 5(2)-р зүйл эсхүл Английн хуулийн үүнтэй төстэй аливаа заалтын дагуу шүүх ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дархан эрх эдлэхгүй болохыг үүгээр хүлээн зөвшөөрч байна.

#### **4.06 дахь хэсэг. Эрх залгамжлагч, Эрх хүлээн авагч; Гуравдагч этгээдийн эрх**

- (a) Энэхүү Гэрээ нь талуудын тус тусын эрх залгамжлагчдын хувьд заавал биелэгдэх шинжтэй бөгөөд хүчин төгөлдөр байна. Нөгөө талын зөвшөөрөлгүйгээр аль ч тал энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ шилжүүлж болохгүй.
- (b) Энэхүү Гэрээний аль ч нөхцөл нь гуравдагч этгээдээр хэрэгжигдэх зорилгоор хийгдээгүй.

#### **4.07 дахь хэсэг. Бүх тохиролцоо; Нэмэлт өөрчлөлт, Татгалзал**

Энэхүү Гэрээ болон энд дурдагдсан баримт бичгүүд нь талуудын хувьд гэрээгээр зохицуулж буй асуудалтай холбоотойгоор хүлээсэн үүргийг бүхэлд нь илэрхийлэх бөгөөд энэхүү хэлцлийн талаар урьд өмнө гаргасан хүсэл зориг, ойлголтын илэрхийллийг орлоно. Энэхүү Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт, Гэрээний аливаа нөхцөлд холбогдуулан гаргасан ЕСБХБ-ны татгалзал, Гэрээний дагуу ЕСБХБ-наас олгосон зөвшөөрөл (үүнд 4.07 дахь хэсэг хамаарах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй)-ийг заавал бичгээр үйлдэж, ЕСБХБ-наас гарын үсэг зурах ба Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Компаниас гарын үсэг зурж баталгаажуулна.

#### **4.08 дахь хэсэг. Бүрэн эрхт, дархан эрхээс татгалзах**

Компани нь энэхүү Гэрээ болон Хөрвүүлэлт нь нийтээр дагаж мөрдөх буюу төрөөс баталсан хэм хэмжээ бус, харин арилжааны шинж чанартай болохыг үүгээр мэдэгдэж, баталгаажуулж байгаа бөгөөд бүрэн эрхт байдлын үндэслэлээр эсхүл аливаа хууль, энэхүү Гэрээний дагуу болон Гэрээтэй холбоотой аливаа үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой аливаа шүүхийн харьяаллын дагуу Компани, түүний хөрөнгөтэй холбогдуулан явагдах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд дархан эрхтэй гэж шаардах эрхгүй гэдгээ мэдэгдэж, баталгаажуулж байна. Компани болон түүний аливаа хөрөнгө нь бүрэн эрхт байдал болон бусад үндэслэлээр өглөгийг төлбөрт тооцох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрийн биелэлтийг баталгаажуулан битүүмжлэх, шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах бусад арга хэмжээ, шийдвэр гүйцэтгэл зэргээс дархан эрхтэй байх эсхүл цаашид дархан эрхийг олж авах боломжтой бол Компани нь үүгээр энэхүү Гэрээний дагуу үүсэх буюу Гэрээтэй холбоотой үүргийнхээ хувьд дархан эрхээсээ эргэлт буцалтгүй татгалзаж байгаа болно.



**4.09 дэх хэсэг. Гэрээний хувь**

Энэхүү Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж болох ба хувь тус бүрийг эх хувь гэж үзэх бөгөөд бүх хувиуд нь хамтдаа нэг, ижил гэрээнд тооцогдоно.

ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай



**ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН**, талууд зохих ёсоор бүрэн эрх олгогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөрөө төлөөлүүлэн энэхүү Гэрээг дээр дурдсан өдөр ДИЙД ГЭРЭЭГЭЭР байгуулж, хүргүүлсэн болно.

**ХАСБАНК ХК**-ийг төлөөлж )  
Гүйцэтгэх захирал ДИЙД ГЭРЭЭГ )  
гэрч байлцуулан БАЙГУУЛАВ: ).....  
) Нэр: Гүмэнжавын Цэвэгжав  
) Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гэрчийн гарын үсэг:

Гэрчийн нэр:

Гэрчийн хаяг:

Гэрчийн ажил, мэргэжил:

**ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,** )  
**ХӨГЖЛИЙН БАНК**-ыг төлөөлж )  
[Захирал] ДИЙД ГЭРЭЭГЭЭР гэрч ).....  
байлцуулан БАЙГУУЛАВ. ) Нэр: \_\_\_\_\_  
) Албан тушаал: [Захирал]

Гэрчийн гарын үсэг:

Гэрчийн нэр:

Гэрчийн хаяг:

Гэрчийн ажил, мэргэжил:



## **Хурлаар шийдвэрлэх долоодугаар асуудал:**

ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай - Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу

## **ХАСБАНК БОЛОН ОУСК НАРЫН ХООРОНД БОДЛОГЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХЫГ ЗӨВШӨӨРЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД БОДЛОГЫН ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХЫГ ДААЛГАХ ТУХАЙ**

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг ХасБанкны нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН")-ийг ХасБанкинд нэгтгэх замаар хангахаар, өөрчлөн байгуулалтын асуудлыг энэ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж байгаа билээ.

Нэгтгэх өөрчлөн байгуулалтыг хийснээр ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний үйлчлэл зогсох юм. Уг гэрээгээр ХасБанк нь ТСН-ийн охин компанийн хувьд ТСН-ийн онцлог бүхий хувьцаа эзэмшигчид буюу олон улсын санхүүгийн байгууллагууд болох Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ"), Олон Улсын Санхүүгийн Корпораци ("ОУСК") нарын байгаль орчин, нийгмийн асуудал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, авлигын эсрэг зэрэг комплайнсын бодлого журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг ба ийнхүү нэгтгэлийн дараа ЕСБХБ, ОУСК-ийн бодлого журмыг мөрдөх үүргийг ХасБанкинд үргэлжлүүлэн хүлээлгэхийн тулд ЕСБХБ, ОУСК нар олон улсын санхүүгийн байгууллага болохын хувьд тусгайлан гэрээ байгуулах хүсэлтийг гаргасан.

ТСН нь уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцэн дэмжээд ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахыг ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлд албан ёсоор хүсэлт тавьж, эдгээр гэрээг байгуулсан нөхцөлд Нэгтгэх гэрээг байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Хүсэлтийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны R-2024-13 дугаар тогтоолоороо Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад ОУСК-тай Бодлогын гэрээ байгуулах зөвшөөрлийг ХасБанкинд олгох, Бодлогын гэрээг ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулсан өдөр эсхүл түүнээс өмнө байгуулж, гарын үсэг зурахыг ХасБанкны Гүйцэтгэх захиралд даалгах тухай асуудлыг оруулсан болно.

Иймд ХасБанк нь, Нэгтгэх өөрчлөн байгуулалтыг хийх замаар Хуулийн шаардлагыг цаг алдалгүй хангах зорилгоор, ТСН-ийн тавьж буй шаардлага болох ОУСК-тай байгуулахаар санал болгосон Бодлогын гэрээний төслийг хувьцаа эзэмшигчиддээ ийнхүү танилцуулж байна.



ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай



---

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДУГААР 34622**

**ХасБанк Нээлттэй Хувьцаат Компани**

**болон**

**ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ**

**нарын хооронд**

**[ ]-ний өдөр байгуулсан**

**БОДЛОГЫН ГЭРЭЭ**

---



- 1 -

## БОДЛОГЫН ГЭРЭЭ

Энэхүү БОДЛОГЫН ГЭРЭЭ (цаашид энэхүү “Гэрээ” гэх)-г [ ]-ний өдөр

(1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа нээлттэй хувьцаат компани болох ХасБанк нээлттэй хувьцаат компани (цаашид “Компани” гэх); болон

(2) Монгол Улс болон гишүүн орнуудтай байгуулсан Үүсгэн байгуулах хэлэлцээрийн дагуу үүсгэн байгуулагдсан олон улсын байгууллага болох ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ (цаашид “ОУСК” гэх) нарын хооронд байгуулсан болно.

### УДИРТГАЛ

(А) Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг Компанид нэгтгэснээр (цаашид “Нэгтгэл” гэх) ОУСК нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэг болох Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй энгийн хувьцааны тодорхой хэсгийг эзэмших; ба

(В) ОУСК нь хэлцэлд тавигдах тодорхой үйл ажиллагааны бодлогын шаардлагыг баталсан бөгөөд ОУСК нь Компанийг эдгээр тусгай шаардлагууд болон энэхүү Гэрээнд тусгасан заалтуудыг дагаж мөрдөхийг шаардана.

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

#### Нэр томьёо, Тайлбар

1.01 дэх хэсэг. *Нэр томьёо*. Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёо нь дор дурдсан утгыг илэрхийлнэ:

“Мэдээлэлд хандах бодлого” гэж <https://disclosures.ifc.org/access-info-policy> хаягт байршуулсан, 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан ОУСК-ийн Мэдээлэлд хандах бодлогыг хэлнэ;

“Харилцан хамаарал бүхий этгээд” гэж аливаа Этгээдийн хувьд шууд болон шууд бусаар Хянадаг, Хяналтад нь байдаг эсхүл түүнтэй хамт нэгдмэл Хяналтад байдаг Этгээдийг;

“МУТСТ” гэж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхийг хэлнэ;

“Байгаль орчин, нийгмийн холбогдох хууль” гэж тухайн Улсын бүхий л хууль тогтоомж, хууль, захирамж, дүрэм, журмыг хэлэх бөгөөд үүнд Гүйцэтгэлийн стандартад заасан байгаль орчин, нийгэм, хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй байдал эсвэл аюулгүй байдлын эрсдэлтэй холбоотой стандартыг тогтоосон бүх Зөвшөөрөл, тэдгээрийг зөрчихөд ногдуулах хариуцлага зэргийг хамааруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй;



“Холбогдох хууль” гэж тухай бүр хүчин төгөлдөр үйлчилж байгаа аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл эсхүл төрийн байгууллагаас олгосон бусад Зөвшөөрөл зэрэг үүгээр хязгаарлагдахгүй бүхий л холбогдох хууль тогтоомж, хууль, захирамж, дүрэм, журмыг хэлнэ;

“Эрх бүхий байгууллага” гэж аливаа үндэстний, үндэстэн дамнасан, бүс нутгийн эсхүл орон нутгийн эрх бүхий байгууллага эсхүл төрийн байгууллага, хууль тогтоох, захиргааны, гүйцэтгэх, төсвийн, шүүх эсхүл төрийн өмчит байгууллага, газар, комисс, албан тушаалтан, бүрэлдэхүүн, агентлаг эсхүл байгууллага, хөрөнгийн бирж эсхүл төв банк (эсхүл төрийн өмчит эсэх, хэрхэн байгуулагдсан, ямар нэртэй байхаас үл хамааран төв банкны чиг үүргийг хэрэгжүүлдэг аливаа Этгээд)-ийг хэлнэ;

“Зөвшөөрөл” гэж аливаа эрх бүхий байгууллагаас шууд үйлдлээр эсхүл тогтоосон хугацаанд үйлдэл хийгээгүй тохиолдолд олгосон гэж тооцогдох эсэхээс үл хамааран аливаа Эрх бүхий байгууллагаас эсхүл Эрх бүхий байгууллагаар олгогдсон зөвшөөрөл, бүртгэл, мэдүүлэг, гэрээ, нотариатын гэрчилгээ, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, баталгаа, зөвшөөрөл, эрх, чөлөөлөлт болон бүхий л корпораци, зээлдүүлэгч, хувьцаа эзэмшигчдийн баталгаа, зөвшөөрлийг;

“Ажлын өдөр” гэж Нью-Йорк мужийн Нью-Йорк хот болон Улаанбаатар хотод банк ажилладаг өдрийг;

“КЗО” гэж нөлөөлөлд өртсөн иргэдийн байгаль орчин, нийгмийн асуудалд шударгаар хариу өгөх, үр дүнг сайжруулах зорилготой ОУСК-ийн хараат бус хариуцлагын механизм болох Комплаенсийн Зөвлөх Омбудсманыг хэлнэ;

“КЗО-ы чиг үүрэг” гэж:

(a) ОУСК-ийн хувьцаа худалдан авалтын өдрөөс хойш Компанийн санхүүжүүлж буй дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд шууд өртсөн эсхүл өртөж болзошгүй аливаа Этгээдийн гаргасан гомдолд хариу өгөх; мөн

(b) ОУСК-ийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн аудитад хяналт тавих болон ОУСК-ийн байгаль орчин, нийгмийн бодлого, зөвлөмж, журам, системийн хэрэгжилтийг үнэлэх КЗО-ы чиг үүргийг хэлнэ;

“А ангиллын үйл ажиллагаа” Үйлчлүүлэгчийн мэдрэмтгий, олон талт эсхүл урьд өмнө тохиолдоогүй байгаль орчинд их хэмжээний сөрөг нөлөө учруулахуйц аливаа үйл ажиллагааг буюу эргэлзээгүй байх үүднээс, бусад зүйлсийн дотроос (i) албадан нүүлгэн шилжүүлэх; (ii) уугуул иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрсдэл учрах; (iii) байгаль орчин, нийгэм, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, биологийн олон янз байдал, соёлын өвд их хэмжээний эрсдэл учрах эсхүл их хэмжээгээр нөлөөлөх; (iv) их хэмжээний цомхотгол хийх; (v) хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл учрах (ажилчид ноцтой гэмтэх эсхүл амь насаа алдах эрсдэл) зэргийг хэлнэ;

“А ангиллын үйлчлүүлэгч” гэж Компаниас эсхүл Компанийн мэдэж байгаачлан ОУСК-иас А ангиллын үйл ажиллагаа гэж ангилсан аливаа удирдлага, үйл ажиллагаа явуулж байгаа эсхүл хийхээр төлөвлөж буй Үйлчлүүлэгчийг хэлнэ;

“Дүрэм” гэж Компанийн дүрэм эсхүл холбогдох тохиолдолд Охин компанийн дүрмийг хэлнэ;



“**Үйлчлүүлэгч**” гэж ОУСК-ийн худалдан авалтын өдрөөс хойш Компаниас бүрэн эрх олгосон эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг үйлдсэнээр Компанийн үйл ажиллагаанаас шууд эсхүл шууд бусаар санхүүждэг мөн Компани бодитоор санхүүжилт олгосон аливаа зээлдэгч, хөрөнгө оруулагч эсхүл бусад Этгээдийг хэлнэ;

“**Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа**” гэж Компанийн үйл ажиллагаанаас шууд эсхүл шууд бусаар санхүүжсэн Үйлчлүүлэгчийн аливаа үйл ажиллагаа эсхүл арга хэмжээг (эсвэл аль нэг Үйлчлүүлэгчийн хувьд тухайн үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, арга хэмжээг) хэлнэ;

“**Нүүрстэй холбоотой дэд төсөл**” гэж (a) нүүрсний цахилгаан станц, нүүрсний уурхай, зөвхөн нүүрс тээвэрт ашигладаг тээврийн хэрэгсэл эсхүл зөвхөн нүүрсний уурхай, нүүрсний тээвэрлэлтийг дэмжихэд зориулагдсан дэд бүтцийн хөрөнгийг хөгжүүлэх, өргөтгөх эсхүл (b) өмнөх санхүүгийн жилд (i) эрчим хүчний үйлдвэрлэлийнхээ 30 гаруй хувийг нүүрсний цахилгаан станцаас бүрдүүлсэн, (ii) жилийн орлогынхоо 30 гаруй хувийг нүүрснээс бүрдүүлсэн, (iii) 10,000 МВт ба түүнээс дээш хүчин чадалтай нүүрсний цахилгаан станцуудыг суурилуулсан эсхүл (iv) 20 сая тонн ба түүнээс дээш нүүрс үйлдвэрлэсэн аливаа Этгээдийг хэлнэ;

“**Нүүрстэй холбоотой дэд төслийн санхүүгийн эрсдэл**” гэж Компанийн тэнцлийн нийт хөрөнгө (эздийн өмчийг оролцуулан) болон тэнцлийн гадуур бүртгэлтэй Нүүрстэй холбоотой дэд төслийг хэрэгжүүлж буй эсхүл бүрдүүлсэн аливаа Этгээд (тэдний охин компаниудын хамт)-ийн өмнө 36 сараас дээш хугацаа (мөн түүнийг сунгасан, дахин санхүүжүүлсэн хугацаа)-тай хүлээсэн үүрэг, болзошгүй өр төлбөрийн нийлбэрээс Нүүрстэй холбоотой дэд төслийн тодорхойлолтын (b)-д хамаарах хөрөнгө, үүрэг, болзошгүй өр төлбөрийн Нүүрстэй холбоотой дэд төслийн тодорхойлолтын (a)-д хамаарахгүй бүтээн байгуулалт, сайжруулалт, өргөтгөл, худалдан авах төсөлд шууд зориулах орлогыг хасаж тооцсоныг хэлнэ;

“**Албадлагын шинжтэй үйлдэл**” гэж Хавсралт А (ОУСК-ийн хэлцэл дэх авлигын эсрэг зөвлөмж)-д заасан утгатай байна;

“**Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэл**” гэж Хавсралт А (ОУСК-ийн хэлцэл дэх авлигын эсрэг зөвлөмж)-д заасан утгатай байна;

“**Компанийн үйл ажиллагаа**” гэж ОУСК-ийн хувьцаа худалдан авалтын өдрөөс хойш Компаниас эсхүл Компанийн Охин компаниудаас бүрэн эрх олгосон эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг үйлдсэнээр Компанийн болон Компанийн Охин компаниудаас санхүүжүүлэх бүхий л үйл ажиллагааг хэлнэ;

“**Авлигын шинжтэй үйлдэл**” гэж Хавсралт А (ОУСК-ийн хэлцэл дэх авлигын эсрэг зөвлөмж)-д заасан утгатай байна;

“**Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо**” гэж Компаниас Компанийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг Байгаль орчин, нийгмийн шаардлагуудад нийцүүлэн олж тогтоох, үнэлэх, удирдахыг зөвшөөрсөн тухай бүр хүчин төгөлдөр үйлчилж, хэрэгжүүлж байгаа Компанийн байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоог хэлнэ;



- 4 -

“Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайлан” гэж ОУСК-ийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий (а) Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны хэрэгжилт, үйл ажиллагааг; болон (б) Үйлчлүүлэгчдийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар боломжит нарийвчилсан байдлаар тодорхойлсон Компанийн Үйлчлүүлэгчдийн өмнөх Санхүүгийн жилийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг үнэлсэн Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланг хэлнэ;

“Байгаль орчин, нийгмийн шаардлагууд” гэж (а) Хориглох зүйлсийн жагсаалт; (б) Байгаль орчин, нийгмийн холбогдох хуулиуд; болон (с) Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны дагуу тогтоосон аливаа бусад шаардлагуудын хэрэгжилтийг хангах үүднээс Үйлчлүүлэгчдийн хүлээх байгаль орчин, нийгмийн үүргийг хэлнэ;

“БОНМТ-ны ажилтан” гэж Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны удирдлага, хяналтыг хариуцахаар томилогдсон Компанийн ахлах ажилтныг;

“Хориглох зүйлсийн жагсаалт” гэж Хавсралт Б-д заасан хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг хэлнэ;

“Санхүүгийн жил” гэж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болох Компанийн нягтлан бодох бүртгэлийн жилийг эсхүл гучин (30) өдрийн өмнө ОУСК-д бичгээр мэдэгдсэнээр Компаниас тухай бүр нягтлан бодох бүртгэлийн жил гэж тогтоосон бусад хугацааг хэлнэ;

“Залилангийн шинжтэй үйлдэл” гэж Хавсралт А (ОУСК-ийн хэлцэл дэх авлигын эсрэг зөвлөмж)-д заасан утгатай байна;

“ОУСК-ийн худалдан авалт” гэж ОУСК Тэнгэр санхүүгийн нэгдэл ХХК-ийн хувьцааг олж авсан эхний өдөр (Компанид нэгтгэхийн өмнө)-ийг хэлнэ;


“Ноцтой сөрөг нөлөө” гэж:

- (а) Компани эсхүл Компанийн Охин компаниудын аль нэгний өмч, хөрөнгөд;
- (б) Компани эсхүл Компанийн Охин компаниудын аль нэгний бизнесийн хэтийн төлөв эсхүл санхүүгийн нөхцөл байдалд;
- (с) Компани эсхүл Компанийн Охин компаниудын аль нэгний бизнес эсхүл үйл ажиллагаагаа эрхлэхэд; эсхүл
- (д) Компани болон Компанийн Охин компани тус бүр нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, мөн Компани өөрийн болон Компанийн Охин компани бүрийн хувьд тус тусын дүрмийг дагаж мөрдөх чадварт

ноцтой сөрөг нөлөө үзүүлэхийг хэлнэ;

“Саад учруулах үйлдэл” Хавсралт А (ОУСК-ийн хэлцэл дэх авлигын эсрэг зөвлөмж)-д заасан утгатай байна;

“Гүйцэтгэлийн стандарт” гэж хуулбарыг нь Компанид хүргүүлж, Компани түүнийг хүлээн авсан болохоо илэрхийлсэн 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан



- 5 -

Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын тухай ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартыг;

“Этгээд” гэж хувь хүнийхээ хувьд, итгэмжлэлээр эсхүл бусад хэлбэрээр үйлдэл хийж байгаа аливаа хувь хүн, корпораци, компани, нөхөрлөл, фирм, сайн дурын холбоо, хамтарсан нэгдэл, итгэлцлийн компани, нэгдмэл бус байгууллага, Эрх бүхий байгууллага эсхүл аливаа бусад байгууллагыг;

“Холбогдох тал” гэж (a) Компани эсхүл аливаа Охин компанид материаллаг хувь эзэмшдэг; (b) Компани эсхүл охин компани материаллаг хувийг нь эзэмшдэг; (c) өөр бусад байдлаар Компанийн Харилцан хамаарал бүхий этгээд; (d) Компанийн ТУЗ-ийн гишүүн, албан тушаалтан эсхүл ажилтнаар ажилладаг (эсхүл сүүлийн арван хоёр (12) сарын дотор ажиллаж байсан) эсхүл (e) дээр дурдсан зүйлсийн аль нэгэнд хамаарах аливаа хувь хүний гэр бүлийн гишүүн болох аливаа Этгээдийг ойлгоно. Энэхүү нэр томъёоны хувьд "материаллаг хувь" гэж Компани эсхүл Охин компанийн аль нэгний нийт саналын эрхийн эсхүл өөрийн хөрөнгийн тав (5%) болон түүнээс дээш хувийг төлөөлж буй хувьцааг шууд буюу шууд бусаар эзэмшихийг ойлгоно;

“Хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа” гэж энд тодорхойлсон, энэхүү Гэрээний Хавсралт А (ОУСК-ийн хэлцэл дэх авлигын эсрэг зөвлөмж)-д хавсаргасан Авлигын эсрэг зөвлөмжид тайлбарласан аливаа Авлигын шинжтэй үйлдэл, Залилангийн шинжтэй үйлдэл, Албадлагын шинжтэй үйлдэл, Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэл, Саад учруулах үйлдлийг хэлнэ;

“Халхавч банк” гэж бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй бөгөөд зохицуулалттай банк эсхүл санхүүгийн байгууллагын Харилцан хамаарал бүхий этгээд бус банкийг;

“Охин компани” гэж Компанийн хувьд өөрийн хөрөнгийнх нь тавь (50%)-иас илүү хувийг Компани шууд эсхүл шууд бусаар эзэмшдэг эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын бүрэлдэхүүнд нь Компани шууд эсхүл шууд бусаар хяналт тавьдаг Этгээдийг ойлгоно.


## ХОЁРДУГААР ЗҮЙЛ

### Гэрээний үүрэг

2.01 дэх хэсэг. ОУСК-ийн Бодлогын дагуу тайлагнах гэрээний үүрэг.

(a) Бүхий л Холбогдох хуулиудын дагуу, тэдгээрт нийцүүлэн Компани нь (i) Ноцтой сөрөг нөлөөтэй эсхүл Ноцтой сөрөг нөлөөтэй байж болох үндэслэл бүхий аливаа шүүх хурал, хяналт шалгалт эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны тухай; эсхүл (ii) Компани эсхүл аливаа Холбогдох талын эсрэг явагдах мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай мэдмэгц ОУСК-д зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тухайн мэдэгдэлд уг үйлдэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, үүнтэй холбогдуулан Компанийн зүгээс авахаар санал болгож буй аливаа алхмуудыг дурдсан байна.





(b) 2.02(h) хэсэгт заасны дагуу болон түүнд нийцүүлэн, бүхий л Холбогдох хуулиуд, дүрэм журам, Компанийн харьяалагдах улсын үнэт цаасны биржээс баталсан дүрмүүд (үүнд Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журам (цаашид "Бүртгэлийн журам" гэх), Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (цаашид "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" гэх), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй)-ийн дагуу, тэдгээрт нийцүүлэн Компанид боломжит хугацааны өмнө урьдчилан мэдэгдсэний үндсэнд, ОУСК-ийн хүсэлтээр,

(i) Компани нь ОУСК болон КЗО-ын төлөөлөгчдөд ердийн ажлын цагаар:

- (1) Компани, Компанийн Охин компаниудын бизнесийн үйл ажиллагаа явуулж буй аливаа байр, байршилд зочлох;
- (2) Компани, Компанийн Охин компаниудын аливаа оффисын байр, салбар, бусад байгууламжид хяналт, шалгалт хийх; болон
- (3) Компани, Компанийн Охин компаниудын нягтлан бодох бүртгэлийн баримт бичгүүд болон (олон нийтэд мэдээлээгүй, үнэ, ханшид нөлөөлж болох мэдээллээс бусад) бүхий л бүртгэлтэй танилцахыг зөвшөөрөх; ба

(ii) Компани болон/эсхүл Компанийн Охин компаниудын хүлээсэн аливаа нууц хадгалах үүргийн дагуу Компани нь ОУСК эсхүл КЗО-ын хайж байгаа мэдээлэлд хамаарах асуудлаар мэдлэгтэй, эсхүл мэдэж байж болзошгүй Компани болон Компанийн Охин компаниудын ажилтнууд, төлөөлөгчидтэй холбогдоход нь ОУСК-д туслахын тулд боломжит хүчин чармайлт гаргана;

гэхдээ, (А) онцгой тохиолдолд аливаа урьдчилсан мэдэгдлийг боломжит хугацааны өмнө хүргүүлэхийг шаардахгүй байж болно; мөн (В) КЗО-ын хувьд тухайн нэвтрэх эрх нь КЗО-ын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилготой уялдана.

(c) Компани болон Компанийн Охин компаниуд нь дор дурдсаныг биелүүлэх бөгөөд Охин компаниуд нь биелүүлж байгаа эсэхийг Компани хариуцна:

(i) жил бүрийн Санхүүгийн жил дууссанаас хойш ерэн (90) өдрийн дотор дор дурдсан мэдээллийг агуулсан Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланг, энэхүү Гэрээний шаардлагуудад нийцэх хэлбэрээр ОУСК-д хүргүүлэх:

- (А) ОУСК-иас Үйлчлүүлэгчдийн байнгын хөгжлийн үр дүнг хэмжих зорилгоор ОУСК-ийн үндэслэл бүхий хүсэлтээр шаардах ОУСК-ийн Мэдээлэлд хандах бодлогын дагуу ОУСК эзэмшиж, ашиглаж болох мэдээлэл; болон
- (В) (х) Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайлангийн нэг хэсэг болох Нүүрстэй холбоотой дэд төслийн санхүүгийн



- 7 -

эрсдэлийн талаарх мэдээллийг (Нийт хөрөнгөд эзлэх хувиар); мөн (y) ОУСК-ийн санхүүжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зохих ёсоор тодорхойлох, ангилах, үнэлэх, шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын танилцуулгыг багтаасан Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны хураангуйг цахим хуудастаа нийтэлсэн тухай баталгааг хүргүүлнэ. Компани нь ийнхүү олон нийтэд ил болгосон мэдээллийн холбоосыг ОУСК-д илгээх ба ингэснээр ОУСК өөрийн Төслийн мэдээлэл, мэдээллийн портал дээр түүнийг нийтэлж болно;

мөн Компани нь Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланг ОУСК-д хүргүүлэхтэй зэрэгцэн хувьцаа эзэмшигчид хүсэлт гаргасан бол тэднийг Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайлангаар үнэ төлбөргүй танилцах боломжоор хангахад шаардлагатай бүхий л алхмуудыг авч хэрэгжүүлэх үүрэгтэй; ба

- (ii) бүхий л Холбогдох хуулиуд, дүрэм журам, Компанийн харьяалагдах улсын үнэт цаасны биржийн дүрэм (үүнд Бүртгэлийн дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль хамаарах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй)-д нийцүүлэн аливаа Үйлчлүүлэгчтэй холбоотой эсхүл Үйлчлүүлэгчийн аливаа үйл ажиллагаатай холбоотойгоор учирсан нийгэм, хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал эсхүл байгаль орчны аливаа осол, тохиолдол, нөхцөл байдлын талаар, нийгэм болон/эсхүл байгаль орчинд эсхүл Байгаль орчин, нийгмийн шаардлагын дагуу Үйлчлүүлэгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажиллуулахад аливаа ноцтой сөрөг нөлөө учирсан буюу учирч болохуйц осол, тохиолдол, нөхцөл байдлын талаар мэдсэнээс хойш ажлын гурван (3) өдрийн дотор тухайн тохиолдлын мөн чанар, түүнээс үүдэн гарч буй эсхүл бий болох боломжтой үр дагавар, нөлөөллийг тухай бүрд тусгаж, мөн тухайн тохиолдлын талаар мэдсэнээс хойш гучин (30) өдрийн дотор Компани болон/эсхүл Үйлчлүүлэгчээс тэдгээрийг арилгах, цаашид ижил төстэй үйл явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд авч байгаа эсхүл авахаар төлөвлөж буй арга хэмжээний тухай ОУСК-д мэдэгдэх; мөн эдгээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтийн тухай ОУСК-д тогтмол мэдээлэх; бөгөөд
- (iii) бүхий л Холбогдох хуулиуд, дүрэм журам, Компанийн харьяалагдах улсын үнэт цаасны биржийн дүрэм (үүнд Бүртгэлийн дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль хамаарах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй)-д нийцүүлэн ОУСК-д дор дурдсаныг нэн даруй бичгээр мэдэгдэнэ:
  - (A) Компани нь МУТСТ-тэй холбогдох хууль, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй тухай;



- (B) аливаа Эрх бүхий байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө эсхүл аливаа бусад хэлбэрээр Компанийг өөрийн МУТСТ бодлого, журам, хяналтын аль нэг хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөх, сайжруулах эсхүл нэмэлт оруулах хүсэлт гаргасан тухай; эсхүл
- (C) а) Компанийн МУТСТ бодлого, журам, үйл ажиллагаа, хяналтын аль нэг хэсэг нь тун хангалтгүй байгаа, эсхүл б) Компани эсхүл Компанийн ажилтнууд, ТУЗ-ийн гишүүд эсхүл Харилцан хамаарал бүхий этгээдийн аль нэг нь МУТСТ-тэй холбоотой холбогдох хууль, дүрэм журмыг зөрчсөн гэж үзэж аливаа хууль эрх зүйн, зохицуулалтын, захиргааны болон эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буй эсхүл торгууль ногдуулсан тухай;

Компани нь ОУСК-д бичгээр мэдэгдэл хүргүүлэх бүрд үйл явдлын мөн чанар, Компаниас авч хэрэгжүүлж байгаа эсхүл түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэхээр санал болгож байгаа алхмуудыг тодорхой дурдах үүрэгтэй.

2.02 дахь хэсэг. ОУСК-ийн Бодлоготой холбоотой Гэрээний үүрэг.

- (a) Хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа.
- (i) Компани нь Компанитай холбоотой эсхүл энэхүү Гэрээний дагуу хийх аливаа хэлцэлд холбогдуулан аливаа Хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа (аливаа Харилцан хамаарал бүхий этгээд эсхүл аливаа бусад Этгээдэд өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахаар бүрэн эрх, зөвшөөрөл олгохгүй) явуулахгүй байхаа үүгээр хүлээн зөвшөөрч байна;
- (ii) Компани нь цаашид бүхий л Холбогдох хуулиуд, дүрэм журам, Компанийн харьяалагдах улсын үнэт цаасны биржийн дүрэм (Бүртгэлийн дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хамааруулан, үүгээр хязгаарлагдахгүй)-д заасны дагуу болон түүнд нийцүүлэн 2.02(a)(i) дахь хэсгийг аливаа байдлаар зөрчсөн тухай олж мэдсэн тохиолдолд ОУСК-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй; мөн
- (iii) Хэрэв ОУСК 2.02(a)(i) дахь хэсгийг зөрчсөн үйлдэл гарсан гэж үзэж байгаагаар Компанид мэдэгдсэн бол, тухайн зөрчил гарсан эсэхийг тогтооход ОУСК болон түүний төлөөлөгчидтэй үнэнч, шударгаар хамтран ажиллаж, ОУСК-ийн аливаа мэдэгдэлд үндэслэлтэй дэлгэрэнгүй мэдээллийг нэн даруй өгөх үүрэгтэй ба ОУСК-ийн хүсэлтийн дагуу бүхий л Холбогдох хууль, дүрэм журам, Компанийн харьяалагдах улсын үнэт цаасны биржийн дүрэм (Бүртгэлийн дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг



хамааруулан, үүгээр хязгаарлагдахгүй)-д нийцүүлэн тухайн хариуг дэмжих баримт бичгийг өгөх үүрэгтэй.

(b) Байгаль орчин ба нийгмийн баталгааны Гэрээний үүрэг. Компани болон Компанийн Охин компаниуд нь дор дурдсаныг биелүүлэх бөгөөд Охин компаниуд нь биелүүлж байгаа эсэхийг Компани хариуцна:

- (i) Компанийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн гүйцэтгэл нь Байгаль орчин, нийгмийн шаардлагуудад нийцэж байгааг тодорхойлох, үнэлэх, удирдах зорилгоор Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцооны тасралтгүй үйл ажиллагааг хангах бүхий л боломжит хүчин чармайлт гаргах;
- (ii) БОНМТ-ны ажилтны аливаа эрх залгамжлагч эсхүл орлогчийг томилох тохиолдолд тухайн БОНМТ-ны ажилтан нь ОУСК-д үндэслэл бүхий хүлээн зөвшөөрөгдөхүйц байх;
- (iii) хэрэв Компани нь Компаниас эсхүл Компанийн мэдэж байгаачлан ОУСК-иас А ангиллын үйл ажиллагаа гэж ангилсан Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа явуулдаг эсхүл явуулахаар төлөвлөж буй санал болгосон Үйлчлүүлэгчид санхүүжилт олгохоор төлөвлөж буй тохиолдолд: (А) үйл ажиллагаа, төлөвлөгөөний талаар мэдмэгц ОУСК-д нэн даруй, бичгээр мэдэгдэх; ба (В) ОУСК-аас үндэслэл бүхий хүсэлт гаргаж болох тухайн асуудлын талаар ОУСК-ийг мэдээллээр хангах;
- (iv) Хэрэв үйлчлүүлэгч А ангиллын үйлчлүүлэгч болсон эсвэл болох талаар санал гаргавал Компанийн Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо болон Үйлчлүүлэгчийн байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо нь боловсон хүчний чанар, мэргэжлийн ур чадвар зэрэг хангалттай хүчин чадалтай байх ёстой бөгөөд энэхүү Гэрээнд заасны дагуу А ангиллын үйлчлүүлэгчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг тогтмол хянах;
- (v) ОУСК-д үүгээр олгогдсон аливаа бусад эрх, нөхөн төлбөр шаардах, нэхэмжлэх эрхийг хязгаарлахгүйгээр хэрэв Компани Компанийн үйл ажиллагааны цар хүрээнд гарах аливаа өөрчлөлтийн талаар мэдсэн тохиолдолд тухайн өөрчлөлтийн улмаас бий болох байгаль орчны болон нийгмийн аливаа ноцтой эрсдэлийн талаар ОУСК-д мэдээлж, зөвлөлдөх, хэрэв ОУСК-иас хүсэлт гаргасан бол эдгээр эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах зорилгоор Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулах;
- (vi) Хэрэв Компани аливаа Үйлчлүүлэгч нь Байгаль орчин, нийгмийн шаардлагад нийцэхгүй байдлаар Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа явуулсныг олж мэдсэн бол: (А) Компанийн үндэслэл бүхий дүгнэлтээр зохистой эсхүл шаардлагатай гэж үзсэний дагуу холбогдох Үйлчлүүлэгчээс тухайн нийцэлгүй байдал, зөрчлийг залруулах арга хэмжээ авахыг шаардах; бөгөөд (В) хэрэв холбогдох



- 10 -

Үйлчлүүлэгч нь (А)-д заасан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй бол хөрвөх чадвар, зах зээлийн хязгаарлалт, итгэлцлийн хариуцлагыг харгалзан тухайн үйлчлүүлэгчид оруулсан Компанийн хөрөнгө оруулалтыг арилжааны хувьд боломжит нөхцөлөөр захиран зарцуулах боломжит хүчин чармайлт гаргах;

- (viii) санал болгосон аливаа Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа осол, орон нутгийн иргэд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, байгаль орчин, нийгмийн сөрөг гүйцэтгэлийн талаар олон нийтэд нээлттэй мэдээллийг олж авах, хянах, хянан шалгах ба зөвхөн дараах тохиолдолд л санал болгож буй Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох буюу өөр хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй: (А) аливаа тухайн осол, сөрөг нөлөө, сөрөг гүйцэтгэлийг Байгаль орчин, нийгмийн шаардлагуудын дагуу шийдвэрлэсэн; эсхүл (В) хэрэв холбогдох үйлчлүүлэгч нь шаардлагатай бол Компанийн хүлээн зөвшөөрсөн хэрэгжүүлэх хуваарь, төсөв зэрэг нөлөөг бууруулах, нөхөн төлөх, залруулах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бөгөөд түүнийг хэрэгжүүлснээр Байгаль орчин, нийгмийн шаардлагуудын дагуу холбогдох Үйлчлүүлэгч нь санал болгосон Үйлчлүүлэгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой болох бол;
- (ix) (i) 2025 оны Санхүүгийн жилийн эцэс болон түүнээс хойших хугацаанд Нүүрстэй холбоотой дэд төслийн санхүүгийн эрсдэл нь Нийт хөрөнгийнх нь 5%-иас бага хувийг эзэлж байгааг баталгаажуулах.
- (x) (i) Холбогдох хуулиар хориглоогүй бол Үйлчлүүлэгчид нь А ангиллын үйл ажиллагаа гэж ангилагдсан аливаа удирдлага, үйл ажиллагааг дэмжих тохиолдолд Үйлчлүүлэгчдээсээ дараахь зүйлийн зөвшөөрөл авна: (А) Компани жил бүр: (1) холбогдох Үйлчлүүлэгчийн нэр; (2) А ангиллын үйл ажиллагаа явуулах хотуудын байршил; (3) А ангиллын үйл ажиллагааны холбогдох салбарыг олон нийтэд мэдээлэх; бөгөөд (Б) ОУСК жил бүр Төслийн мэдээлэл, мэдээллийн портал дээрх ижил мэдээллийг олон нийтэд мэдээлэх; (ii) ОУСК-д өгөх Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланд дээрх (i)(А)(1)-ээс (3) хүртэлх дэд хэсгүүдэд заасан мэдээллийг тусгана. Хэрэв Компани нь дээрх (i)(А)(1)-ээс (3) болон (ii)-д заасан үүргээ биелүүлэхийг Холбогдох хуулийн дагуу хориглосон бол Компани нь Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланд ерөнхий зөвлөх (эсхүл хөндлөнгийн зөвлөх)-ийн (ОУСК-иас үндэслэл бүхий шаардаж болох хууль зүйн дүгнэлтийг оролцуулан аливаа батлах баримт бичгийн хамт) дагаж мөрдөөгүй шалтгааныг нарийвчлан тодорхойлсон, холбогдох хуулийн холбогдох заалтыг тусгайлан иш татсан захидлыг нэг хэсэг болгож оруулна. ОУСК нь дээрх (i) дэд хэсэгт тодорхойлсон мэдээллийг (эсхүл аливаа зөрчлийн талаарх Компанийн тайлбар)





- 11 -

өөрийн Төслийн мэдээлэл, мэдээллийн портал дээр ил болгож болох бөгөөд эдгээр мэдээллийг жил бүр шинэчилж болно; мөн

- (xi) ОУСК-ийн худалдан авалтын өдрөөс хойш хөдөлмөр болон хөдөлмөрийн нөхцөлийн талаарх Компанийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 2 (Хөдөлмөр ба хөдөлмөрийн нөхцөл)-ийн шаардлагад нийцүүлнэ. Хэрэв ОУСК эдгээр бодлогын аль нэгийг зөрчсөн гэж үзэж байгаагаа Компанид мэдэгдсэн бол тухайн зөрчил гарсан эсэхийг тогтооход ОУСК-тай үнэнч, шударгаар хамтран ажиллаж, ОУСК-иас гаргасан аливаа хүсэлтэд нэн даруй, боломжит дэлгэрэнгүй хариу өгөх бөгөөд ОУСК-иас гаргасан хүсэлтийн дагуу тухайн хариуг дэмжих баримт бичгийг өгөх үүрэгтэй.

(c) Байгаль орчин, нийгмийн сөрөг Гэрээний үүрэг. Компани болон Компанийн Охин компаниуд нь дор дурдсан үйлдлийг гаргахгүй бөгөөд Охин компаниуд нь ийм үйлдэл гаргахгүй байхыг Компани хариуцна:


- (i) Хориглох зүйлсийн жагсаалтад орсон аливаа үйл ажиллагаа эрхэлж буй Үйлчлүүлэгчид зээл, санхүүжилт олгох, хөрөнгө оруулалт хийх эсхүл бусад хэлбэрээр дэмжих; эсхүл
- (ii) Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо болон Байгаль орчин, нийгмийн шаардлагуудад өөрчлөлт оруулах, тэдгээрийг хэрэглэхээс татгалзах эсхүл өөр бусад байдлаар тэдгээрийн хүрээ, үйлчлэлийг ихээхэн хязгаарлах.

(d) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолууд. Компани болон Компанийн Охин компани тус бүр нь: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл эсхүл түүний хороодоос Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн VII бүлэгт заасан аливаа тогтоолын дагуу (i) зарласан жагсаалтад нэр дурдсан аливаа хувь хүн, байгууллагатай эсхүл тэдгээрийн ашиг орлогын төлөө; эсхүл (ii) тийнхүү хориглосон аливаа үйл ажиллагаанд хамаарах аливаа хэлцэл хийхгүй байх үүднээс өөрийн бизнесийн үйл ажиллагаа, харилцагчийн онцлогт нийцүүлэн дотоод бодлого, журам, хяналтыг бий болгож, хадгалж, дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд үүнийг Компани болон Компанийн Охин компаниуд нь биелүүлэх ба Охин компаниуд биелүүлж буй эсэхийг Компани хариуцна.

(e) Халхавч банкнууд. Компани болон Компанийн Охин компани тус бүр нь:

- (i) Компани эсхүл Компанийн Охин компаниудын хамтран бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, аливаа хэлцэл хийдэг эсхүл Компани эсхүл Компанийн Охин компаниудаар дамжуулан мөнгө шилжүүлдэг аливаа санхүүгийн байгууллага нь Халхавч банктай корреспондент банкны харилцаа холбоогүй байх; болон
- (ii) Компани болон Компанийн Охин компани тус бүр нь Халхавч банктай бизнесийн үйл ажиллагаа эрхлэхгүй, хэлцэл хийхгүй, Халхавч банкаар дамжуулан аливаа мөнгө шилжүүлэхгүй байхын





тулд дотоод журам, хяналтыг бий болгож, хадгалж, дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд үүнийг Компани болон Компанийн Охин компаниуд нь биелүүлэх ба Охин компаниуд биелүүлж буй эсэхийг Компани хариуцна.

(f) МУТСТ. Компани болон Компанийн Охин компани тус бүр өөрийн бизнесийн үйл ажиллагаа, харилцагчийн онцлогт нийцүүлэн, үндэсний хууль, дүрэм журам, цаашлаад олон улсын холбогдох МУТСТ шилдэг туршлагын дагуу МУТСТ-тэй холбоотой дотоод бодлого, журам, хяналтыг бий болгох, хадгалах, дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд үүнийг Компани болон Компанийн Охин компаниуд нь биелүүлэх ба Охин компаниуд биелүүлж буй эсэхийг Компани хариуцна.

(g) Мэдээлэл ил тод болгох. Компани нь ОУСК-иас энэхүү Гэрээний дагуу гаргасан олон нийтэд мэдээлээгүй үнэ ханшид нөлөөлж болох мэдээлэл авах хүсэлтэд холбогдуулан, Холбогдох хууль, дүрэм журам, Компанийн харьяалагдах улсын үнэт цаасны биржийн дүрэм (Бүртгэлийн дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хамааруулан, үүгээр хязгаарлахгүй)-ээр тогтоосны дагуу мэдээллийг тэгш түгээх шаардлагыг хангах зорилгоор ОУСК болон олон нийтэд болон/эсхүл хувьцаа эзэмшигчдэдээ нэгэн зэрэг ил тод болгох тухай Компани болон ОУСК-иас танилцаж, зөвшөөрсөн болно.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ

### Гэрээний хугацаа

3.01 дэх хэсэг, Гэрээний хугацаа. Энэхүү Гэрээ нь ОУСК нь Компанийн аливаа хувьцааг цаашид эзэмшихгүй болох хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

### Мэдэгдэл, баталгаа

4.01 дэх хэсэг, Мэдэгдэл, баталгаа. Компани нь дараах мэдэгдэл бүр нь энэхүү Гэрээ батлагдсан өдрийн байдлаар үнэн, бодит, төөрөгдүүлээгүй болохыг үүгээр мэдэгдэж, баталж байна:

(a) Байгууллага, Эрх бүхий байгууллага. Компани нь үүсгэн байгуулагдсан улсынхаа хуулийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа хүчин төгөлдөр эрхэлж байгаа бөгөөд энэхүү Гэрээг байгуулах, түүний дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх хуулийн этгээдийн эрхтэй, бүрэн эрх бүхий хуулийн этгээд мөн болно.

(b) Хүчин төгөлдөр байдал. Энэхүү Гэрээг Компаниас зохих ёсоор зөвшөөрч, байгуулсан бөгөөд үүний нөхцөлүүдийн дагуу хэрэгжих боломжтой, хууль ёсны бөгөөд хүчин төгөлдөр үүргийг бий болгоно.

(c) Зөрчилгүй байх. Энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхэд (i) Компанид холбогдох аливаа хууль, дүрэм журам, тушаал, тогтоол, зөвшөөрлийг; (ii) Компанийн



Дүрмийн аливаа заалтыг; эсхүл (iii) Компани эсхүл Компанийн аливаа хоронгод хамаарах аливаа гэрээний хүчин төгөлдөр хязгаарлалтыг зорчихгүй.

## ТАВДУГААР ЗҮЙЛ

### Бусад зүйл

5.01 дэх хэсэг. *Мэдэгдэл*. Энэхүү Гэрээний дагуу аливаа мэдэгдэл, хүсэлт, бусад харилцаа холбоог бичгээр өгөх буюу хүргүүлнэ. 5.01(с) дэх (*Мэдэгдэл*) хэсэгт заасны дагуу тухайн харилцаа холбоог тухайн талын дор дурдсан хаягаар өгөх буюу хүргүүлэхийг шаардсан эсхүл зөвшөөрсөн бол эсхүл тухайн тал нөгөө талдаа бичгээр өгсөн мэдэгдэлд тухай бүр тогтоосон бусад хаягаар тухайн талын гарт нь, тогтсон шуудангийн үйлчилгээгээр эсхүл цахим шуудангаар хүргүүлэх бөгөөд 5.01(b) хэсэгт заасны дагуу (а) бодитоор хүлээн авсан болон (б) хүлээн авсан гэж тооцогдсон өдрийн аль түрүүлж биелснээр хүргэгдсэнд тооцогдоно.

Компанийн хувьд:

Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж,  
ХасБанкны төв байр

Цахим шуудан: [tsevegjav.g@xacbank.mn](mailto:tsevegjav.g@xacbank.mn)  
Хэнд: Гүйцэтгэх захирал Гүмэнжавын Цэвэгжав-д

ОУСК-ийн хувьд:

Америкийн Нэгдсэн Улс  
20433 Вашингтон ДС  
Баруун хойд Пенсилванийн өргөн чөлөө 2121  
Олон Улсын Санхүүгийн Корпорац

Цахим шуудан: [Notifications@ifc.org](mailto:Notifications@ifc.org)  
ОУСК-ийн 34622 дугаартай хөрөнгө оруулалтад хамаарах  
Хэнд: Санхүүгийн Байгууллагуудын Группийн Хэлтсийн Захирал

Санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан захиралд хандсан хуулбарын хамт  
(төлбөр тооцоотой холбоотой харилцаа холбооны хувьд).

(b) Өөр цагт хүлээн авсан гэх үндэслэл бүхий нотлох баримт байхгүй бол энэхүү 6.01 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдлийг: (i) гараар хүргүүлж, 6.01(a) хэсэгт дурдсан хаягт үлдээсэн тохиолдолд; (ii) улс доторх тогтсон шуудангийн үйлчилгээгээр илгээсэн бол шууданд хийснээс хойш Ажлын гурван (3) өдрийн дараа эсхүл хүлээн авсан нь баталгаажсан өдрийн аль эртэд нь; (iii) хоёр улсын хоорондын тогтсон шуудангийн үйлчилгээгээр илгээсэн бол шууданд хийснээс хойш Ажлын зургаан (6) өдрийн дараа эсхүл хүлээн авсан нь баталгаажсан өдрийн аль эртэд нь; мөн (iv) цахим шуудангаар илгээсэн тохиолдолд өгсөн гэж үзнэ.



- 14 -

(c) ОУСК нь accessifc.ifc.org хаягт байршуулсан "AccessIFC" гэсэн нэртэй, баримт бичиг хуваалцах баталгаатай вэбсайттай бөгөөд хэрэв Компани нь ОУСК-иас тавьсан AccessIFC-д нэвтрэх, ашиглах бүхий л нөхцөл, болзлуудыг зөвшөөрсөн тохиолдолд ОУСК өөрийн үзэмжээр AccessIFC-д нэвтрэх эрхийг Компанид олгож болно. Компанид AccessIFC-д нэвтрэх эрхийг олгосон тохиолдолд Компани болон ОУСК нь харилцан тохиролцсоноор, Компани нь 2.01(c)(i) хэсэг (ОУСК-ийн Бодлогын тайлагналын хэлцэл)-т заасны дагуу шаардлагатай тайлан болон аливаа бусад тайлангийн бусад шаардлагуудыг AccessIFC-ээр дамжуулж хүргүүлнэ.

5.02 дахь хэсэг. Эрхийг хадгалах. (a) ОУСК эсхүл түүний нэрийн өмнөөс Компанийн үйл ажиллагаанд хийх аливаа хяналт шалгалт, энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэх эсхүл ОУСК-ийн эдлэх эрх, авч хэрэгжүүлэх арга хэмжээнд нөлөөлөх магадлалтай ОУСК эсхүл түүний нэрийн өмнөөс хийх аливаа бусад зүйл эсхүл үйлдэл нь Компаниас аливаа худал мэдээлэл өгсөн, баталгааг зөрчсөнтэй холбоотой ОУСК-ийн эдлэх эрх, авч хэрэгжүүлэх арга хэмжээнд нөлөөлөхгүй.

(b) Энэхүү Гэрээ болон аливаа бусад гэрээний дагуу ОУСК-иас аливаа эрх хэмжээ, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сонгох эрх, бүрэн эрх эсхүл эрхээ хэрэгжүүлээгүй, хойшлуулсан, хэрэгжүүлээгүй нь энэхүү Гэрээний дагуу эрх хэмжээ, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сонгох эрх, бүрэн эрх эсхүл эрхийг доройтуулсан, тэдгээрээс татгалзсан, хүлээн зөвшөөрсөн эсхүл аливаа байдлаар нэмэлтээр эсхүл ирээдүйд хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэх үндэслэл болохгүй.

5.03 дахь хэсэг. Англи хэл. Энэхүү Гэрээний дагуу өгөх бүх баримт бичиг, харилцаа холбоо нь англи хэл дээр байх бөгөөд хэрэв тухайн баримт бичиг, харилцаа холбооны эх нь англи хэл дээр байхгүй бол Эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр баталгаажуулсан эх хувийн үнэн, зөв англи хэл дээрх орчуулгыг хавсаргана. ОУСК хэрэв шаардлагатай бол өөр бусад хэлээр хүлээн авсан аливаа баримт бичиг, харилцаа холбооны англи хэл дээрх орчуулгыг Компанийн зардлаар олж авч болно. ОУСК аль ч тохиолдолд тухайн орчуулгыг зохицуулах хувилбар гэж үзэж болно.

5.04 дэх хэсэг. Зохицуулах хууль. Энэхүү Гэрээ болон энэхүү Гэрээнээс эсхүл түүнтэй холбогдуулан үүссэн бүхий л гэрээний бус үүргийг Англи, Уэльсийн хуулийн дагуу зохицуулж, тайлбарлана.

5.05 дахь хэсэг. Арбитр. (a) Энэхүү Гэрээнээс эсхүл түүнтэй холбогдуулан үүссэн маргаан эсхүл энэхүү Гэрээнээс эсхүл түүнтэй холбогдуулан үүссэн бүхий л гэрээний бус үүргээс үүдэн гарсан маргаан (цаашид тус бүрийг “**Маргаан**” гэх)-ыг Олон улсын худалдааны танхим (цаашид “**ОУХТ**” гэх)-ын Арбитрын дүрэм (цаашид “**Дүрэм**” гэх)-ийн дагуу эцэслэн шийдвэрлэнэ.

(b) Энэхүү заалтын дагуу энэхүү Гэрээний аль ч тал Арбитрын ажиллагаа эхлүүлэх хүсэлт (Дүрэмд тодорхойлсны дагуу)-ийг энэхүү Гэрээний бусад бүх талууд (тухайн талууд нь Арбитрын ажиллагаа эхлүүлэх хүсэлтэд хариуцагчаар нэрлэгдсэн эсэхээс үл хамааран)-ад өгөх хуулбарын хамт ОУХТ-д илгээх замаар нөгөө талынхаа эсрэг арбитрын ажиллагааг эхлүүлж болно.

Гуравдагч этгээдэд хамааралтай бусад маргаан эсхүл энэхүү Гэрээтэй холбогдолгүй бусад маргааныг арбитрын ажиллагаанд оруулахгүй бөгөөд нэгтгэхгүй.



(c) Дараах байдлаар гурван арбитрчийг томилно. Хэрэв Арбитрын ажиллагаа эхлүүлэх хүсэлтэд зөвхөн нэг нэхэмжлэгч, нэг хариуцагчийг нэрлэсэн бөгөөд дээрх (b) хэсэгт заасны дагуу аль ч тал нэгдэх, хөндлөнгөөс оролцох эрхээ хэрэгжүүлээгүй бол дээрх (b) хэсэгт заасны дагуу талууд нэгдэх, хөндлөнгөөс оролцох эрхээ хэрэгжүүлэх хугацаа дууссанаас хойш 15 өдрийн дотор нэхэмжлэгч болон хариуцагч тус бүр нэг арбитрчийг нэр дэвшүүлнэ. Хоёр дахь арбитрчийг томилсноос хойш 30 өдрийн дотор талуудын тохиролцоогоор арбитрын бүрэлдэхүүний даргалагчийн үүргийг гүйцэтгэх гурав дахь арбитрчийг томилно. Хэрэв эдгээр хугацаанд аль нэг арбитрчийг нэр дэвшүүлээгүй бол ОУХТ-аас томилно.

Хэрэв Арбитрын ажиллагаа эхлүүлэх хүсэлтэд олон нэхэмжлэгч эсхүл олон хариуцагчийг нэрлэсэн, эсхүл хамгийн багадаа аль нэг тал дээрх (b) хэсэгт заасны дагуу нэгдэх, хөндлөнгөөс оролцох эрхээ хэрэгжүүлж байгаа бол дээрх (b) хэсэгт заасны дагуу талууд нэгдэх, хөндлөнгөөс оролцох эрхээ хэрэгжүүлэх хугацаа дууссанаас хойш 15 өдрийн дотор нэхэмжлэгч(нар) хамтран нэг арбитрчийг, хариуцагч(нар) хамтран нөгөө арбитрчийг тус тус нэр дэвшүүлнэ. Хэрэв талууд дээр дурдсанчлан арбитрчийг нэр дэвшүүлж чадаагүй бол ОУХТ аль нэг талын хүсэлтээр гурван арбитрчийг бүгдийг нь томилж, тэдгээрийн аль нэгийг арбитрын бүрэлдэхүүний даргалагчаар томилно. Хэрэв нэхэмжлэгч(нар) болон хариуцагч(нар) дээр дурдсанчлан арбитрчийг нэр дэвшүүлсэн бол хоёр дахь арбитрчийг томилсноос хойш 30 өдрийн дотор талуудын тохиролцоогоор арбитрын бүрэлдэхүүний даргалагчийн үүргийг гүйцэтгэх гурав дахь арбитрчийг томилно. Талууд дээр дурдсанчлан арбитрын бүрэлдэхүүний даргалагчийг нэр дэвшүүлж чадаагүй бол арбитрын бүрэлдэхүүний даргалагчийг ОУХТ-аас томилно.

(d) Арбитрын ажиллагааг Сингапур улсад явуулна.


(e) Арбитрын ажиллагааг англи хэл дээр явуулна.

(f) Дүрэмд заасныг үл харгалзан, Дүрэмд заасны дагуу томилогдсон арбитрын бүрэлдэхүүн болон онцгой тохиолдолд томилогдсон арбитрч нь ОУСК-ийн эсрэг хамгаалах түр арга хэмжээ авах, шүүхийн шийдвэрийн өмнөх арга хэмжээг авах эрхгүй байх бөгөөд талууд аливаа шүүх эрх мэдлийн байгууллагаас тийнхүү шаардах эрхгүй.

(g) Талууд эдгээр болон/эсхүл Холбогдох гэрээний дагуу эхэлсэн хоёр буюу түүнээс дээш арбитрын ажиллагааг нэг арбитрын хэлэлцээрээр, эсхүл нэгээс олон арбитрын хэлэлцээрээр гаргасан эсэхээс, мөн арбитрын ажиллагааг ижил талууд эсхүл өөр талуудын хооронд явуулах эсэхээс үл хамааран нэгтгэхийг шууд, эргэлт буцалтгүйгээр зөвшөөрсөн болно. Нэгтгэх шийдвэрийг Дүрэмд заасны дагуу ОУХТ-ийн шүүх гаргана.

(h) Талууд энэхүү Гэрээ эсхүл Дүрмүүдийн аль ч заалт болон ОУСК-иас арбитрт хандсан явдал нь холбогдох хууль, олон улсын конвенц, ОУСК-ийн Үүсгэн байгуулах хэлэлцээрийн дагуу ОУСК-д олгогдсон аливаа дархан эрх, эрх ямбаанаасаа татгалзсан, цуцалсан, өөрчилсөн гэж үзэхгүй буюу аливаа байдлаар татгалзаагүй, цуцлаагүй, өөрчлөөгүй, чөлөөлөгдөөгүй болохыг танилцаж, зөвшөөрсөн болно.

5.06 дахь хэсэг. *Эрх залгамжлагч ба Эрх хүлээн авагч.* Талуудын холбогдох эрх залгамжлагч, эрх хүлээн авагчид нь энэхүү Гэрээний дагуу үүрэг хүлээж, эрх эдэлнэ.



Гэсэн хэдий ч, ОУСК-иас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд Компани нь энэхүү Гэрээнд заасан эрх, үүргээ бусдад олгох, шилжүүлэх, залгамжлуулах эрхгүй.

5.07 дахь хэсэг. Нэмэлт, өөрчлөлт оруулах, Татгалзал, болон Зөвшөөрөл. Энэхүү Гэрээний аливаа заалтын дагуу аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах, зөвшөөрөл өгөхдөө бичгээр үйлдэх бөгөөд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бүх талууд гарын үсэг зурна.

5.08 дахь хэсэг. Гэрээний хувь. Энэхүү Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж болох ба хувь тус бүрийг эх хувь гэж үзэх бөгөөд бүх хувиуд нь хамтдаа нэг, ижил гэрээнд тооцогдоно.

5.09 дэх хэсэг. Хүчингүй Заалтууд. Хэрэв аливаа хуульд заасны дагуу энэхүү Гэрээний аливаа заалтыг тухай бүр хууль бус, хүчин төгөлдөр бус эсхүл хэрэгжих боломжгүй гэж үзвэл: (а) тухайн заалт нь бүхэлдээ бие даасан, тусгаар байна; (b) тухайн хууль бус, хүчин төгөлдөр бус эсхүл хэрэгжих боломжгүй заалт нь хэзээ ч энэхүү Гэрээний хэсэг байгаагүй мэтээр энэхүү Гэрээг тайлбарлаж, хэрэгжүүлнэ; мөн (с) энэхүү Гэрээний үлдсэн заалтууд бүрэн хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой хэвээр байх бөгөөд хууль бус, хүчин төгөлдөр бус, хэрэгжих боломжгүй заалт эсхүл тухайн заалтыг тусгаарлах нь үүнд нөлөөлөхгүй.

(Гарын үсэг зурах хуудас дагалдана)

- 17 -



ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН, энэхүү Гэрээний талууд итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөрөө дамжуулан өөрсдийн нэрийн өмнөөс дээр дурдсан өдөр гарын үсэг зурж, байгуулсан болно.

**ХасБанк Нээлттэй Хувьцаат Компани**

Гарын үсэг:  
Нэр:  
Албан тушаал:

**ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ**

Гарын үсэг:  
Нэр:  
Албан тушаал:





## ХАВСРАЛТ А

### ОУСК-ИЙН ХЭЛЦЭЛ ДЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ЗӨВЛӨМЖ

Эдгээр Зөвлөмжийн зорилго нь ОУСК-ийн үйл ажиллагааны хүрээнд “Авлигын шинжтэй үйлдэл”, “Залилангийн шинжтэй үйлдэл”, “Албадлагын шинжтэй үйлдэл”, “Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэл” болон “Саад учруулах үйлдэл” гэх нэр томъёоны утгыг тодруулахад оршино.

#### 1. Авлигын шинжтэй үйлдэл

“Авлигын шинжтэй үйлдэл” гэдэгт нөгөө талынхаа үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор аливаа үнэ бүхий зүйлийг шууд эсхүл шууд бусаар санал болгох, өгөх, хүлээн авах, шаардахыг ойлгоно.

#### Тайлбар

- A. Авлигын шинжтэй үйлдэл гэж хахууль өгөх болон хахууль авахыг хэлнэ. Төлбөр өгч буй этгээд зүй бус давуу байдал олж авах, үүрэг хүлээхээс зайлсхийх зорилгоор төлбөр хүлээн авагчийг хүлээсэн үүргээ зөрчих, түүнээс татгалзах байдалд хүргэх тухайн үйлдэлдээ зүй бус арга хэрэгсэл (тухайлбал хахууль) ашигласан байхыг ойлгоно. Ийм шинж чанар агуулаагүй монополын эсрэг, үнэт цаас болон бусад хууль зөрчсөн үйлдлийг авлигын шинжтэй үйлдлийн тодорхойлолтод хамааруулахгүй.
- B. Гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ, концесс болон бусад төрлийн гэрээгээр ихэвчлэн хөрөнгө оруулагчдаас нийгмийн хөгжлийн төлөө үнэнч, шударгаар хувь нэмрээ оруулах, төсөлтэй холбоогүй дэд бүтцэд санхүүжилт олгохыг шаарддаг болохыг хүлээн зөвшөөрч байгаа болно. Үүний нэгэн адил хөрөнгө оруулагчдаас орон нутгийн буяны байгууллагуудад үнэнч, шударгаар хувь нэмрээ оруулахыг ихэвчлэн шаарддаг болно. Эдгээр үйл ажиллагааг орон нутгийн хууль тогтоомжийн дагуу зөвшөөрсөн, төлбөр төлөгчийн нягтлан бодох бүртгэлийн дэвтэр болон бүртгэлд бүрэн тусгасан тохиолдолд энэхүү тодорхойлолтын дагуу Авлигын шинжтэй үйлдэл гэж үзэхгүй. Үүний нэгэн адил хөрөнгө оруулагч нь нийгмийн хөгжлийн сан, буяны хандивыг захиран зарцуулдаг байгууллагуудын үйлдсэн авлига эсхүл залилангийн шинжтэй үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй.
- C. Хувь этгээдүүдийн хоорондын үйлдлийн хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн салбарын стандартад нийцсэн тогтсон заншил болсон байгууллагын найрсаг байдал, бэлэг дурсгалын зүйлийг санал болгох, өгөх, хүлээн авах, шаардах нь Холбогдох хуулийг зөрчөөгүй тохиолдолд авлигын шинжтэй үйлдэл гэж үзэхгүй.
- D. Хувийн хэвшлийн этгээдээс холбогдох хууль, олон улсын конвенцын дагуу одоогийн практикт нийцүүлэн төрийн албан хаагчийн аялал,



- 19 -

энтертайнментад зориулагдах үндэслэл бүхий зардлын төлбөрийг Авлигын шинжтэй үйлдэл гэж үзэхгүй.

- Е. Дэлхийн банк групп<sup>1</sup> нь зуучлалын аливаа төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй. Үүний хэрэгжилтийг хангахад, зуучлалын зорилготой аливаа төлбөртэй холбоотой “Авлигын шинжтэй үйлдэл”-ийг тайлбарлахдаа авлигын талаарх холбогдох хууль тогтоомж, олон улсын конвенцыг харгалзан үзнэ.

## 2. Залилангийн шинжтэй үйлдэл

"Залилангийн шинжтэй үйлдэл" гэдэгт аль нэг талыг санхүүгийн болон бусад ашиг орлого хүртэх эсхүл үүрэг хүлээхээс зайлсхийхэд нь туслах зорилгоор сааатай эсхүл болгоомжгүй байдлаар худал мэдээлэл өгсөн, төөрөгдүүлсэн, төөрөгдүүлэх оролдлого хийсэн зэрэг аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

### ТАЙЛБАР

- А. Хэрэв аливаа үйлдэл, эс үйлдэхүй, худал мэдээллийг үнэн эсхүл худлыг тогтоохгүйгээр хайхрамжгүйгээр гаргасан бол дээрх үйлдэл, эс үйлдэхүй, худал мэдээлэл нь хайхрамжгүйгээр үйлдэгдсэн гэж үзнэ. Энгийн хайхрамжгүй байдлаас үүдэлтэй тухайн мэдээлэлд үл ялим зөрүүтэй байдал үүссэнийг энэхүү Гэрээний дагуу "Залилангийн шинжтэй үйлдэл" гэж үзэхгүй.
- В. Залилангийн шинжтэй үйлдлүүд нь Дэлхийн банк групп руу чиглэсэн эсхүл түүний эсрэг чиглэсэн үйлдэл, эс үйлдлийг хамааруулах зорилготой. Мөн Дэлхийн банк группээс санхүүжүүлж буй төсөлд холбогдох засгийн газрын гэрээ эсхүл концесс олгох, хэрэгжүүлэхтэй холбогдуулан Дэлхийн банк группийн гишүүн улс руу чиглэсэн эсхүл түүний эсрэг чиглэсэн залилангийн шинжтэй үйлдлүүдийг хамааруулна. Бусад гуравдагч этгээдийн эсрэг хийсэн залиланг хүлээн зөвшөөрч, зөвтгөхгүй боловч ОУСК, ОТХОБА эсхүл ТСГ-ийн үйл ажиллагаанд тусгайлан хариуцлага хүлээлгэхээр заагаагүй. Үүний нэгэн адил бусад хууль бус үйлдлийг хүлээн зөвшөөрч, зөвтгөхгүй боловч тэдгээрийг энэхүү Гэрээний дагуу Залилангийн шинжтэй үйлдэлд тооцохгүй.

## 3. Албадлагын шинжтэй үйлдэл

<sup>1</sup> “Дэлхийн банк” гэж үүсгэн байгуулах хэлэлцээрийн дагуу байгуулагдсан олон улсын байгууллага буюу Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкныг ойлгох бөгөөд “Дэлхийн банк групп” гэдэгт Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын санхүүгийн корпораци, Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг болон Олон улсын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх төвийг ойлгоно.



- 20 -

“Албадлагын шинжтэй үйлдэл” гэдэгт аль нэг талын үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор тухайн тал эсхүл түүний өмч хөрөнгөд шууд эсхүл шууд бусаар хохирол учруулах, гэмтээх, хохирол учруулах эсхүл гэмтээхээр заналхийлэхийг ойлгоно.

#### ТАЙЛБАР

- A. Албадлагын шинжтэй үйлдэл гэдэг нь тендерийг будилаантуулах эсхүл төрийн худалдан авах ажиллагаа, засгийн газартай гэрээ байгуулахтай холбоотой эсхүл Авлигын шинжтэй үйлдэл, Залилангийн шинжтэй үйлдлийг дэмжих зорилгоор хийсэн үйлдлүүд юм.
- B. Албадлагын шинжтэй үйлдэл гэдэг нь хууль бус давуу байдал олж авах, үүрэг хүлээхээс зайлсхийх зорилгоор хүний биед гэмтэл учруулах, хүн хулгайлах, эд хөрөнгөд хохирол учруулах, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах зэрэг заналхийлсэн эсхүл бодитоор үйлдэгдсэн хууль бус үйлдэл юм. Энэ нь хатуу нөхцөлтэй хэлцэл хийх, хуулийн дагуу эсхүл гэрээний дагуу арга хэмжээ авах эсхүл шүүн таслах ажиллагаа явуулахыг хамааруулах зорилгогүй болно.

#### 4. Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэл

“Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэл” гэдэгт хоёр эсхүл түүнээс дээш талууд нөгөө талын үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зэрэг аливаа зохисгүй зорилгод хүрэхийн тулд үгсэн тохиролцохыг ойлгоно.

#### ТАЙЛБАР

Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдэл гэдэг нь тендерийг будилаантуулах, төрийн худалдан авах ажиллагаа, засгийн газрын гэрээ байгуулахтай холбоотой эсхүл Авлигын шинжтэй үйлдэл, Залилангийн шинжтэй үйлдлийг дэмжих зорилгоор хийсэн үйлдлүүд юм.

#### 5. Саад учруулах үйлдэл

"Саад учруулах үйлдэл" гэж (i) авлигын шинжтэй үйлдэл, залилангийн шинжтэй үйлдэл, албадлагын шинжтэй үйлдэл, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдлийн талаарх мэдээллийн дагуух Дэлхийн банкны группийн хяналт шалгалтад бодитой саад учруулах зорилгоор нотлох баримтын материалыг зориудаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуун дарагдуулах, хянан шалгагчид худал мэдүүлэг өгөх болон/эсхүл, хяналт шалгалттай холбоотой асуудлаарх мэдээллийг задруулахгүйн тулд эсхүл хяналт шалгалтыг явуулахад саад учруулах зорилгоор аливаа этгээдийг заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлэхийг эсхүл (ii) Дэлхийн банкны группийн авлигын шинжтэй үйлдэл, залилангийн шинжтэй үйлдэл, албадлагын шинжтэй үйлдэл, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйлдлийн талаарх мэдээлэлд хийх хяналт шалгалттай холбоотойгоор ОУСК гэрээний дагуу шаардлагатай мэдээлэлд нэвтрэх эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитой саад учруулахад чиглэсэн үйлдлийг хэлнэ.

#### ТАЙЛБАР



- 21 -

Үйлчлүүлэгчийн нууц зэрэг дүрэм, журам, хууль болон үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлж, хамгаалахын тулд аль нэг талын хууль ёсны дагуу болон бусад зохих ёсоор хийсэн аливаа үйлдэл нь хяналт шалгалтын ажиллагаанд саад учруулсан эсэхээс үл хамааран Саад учруулах үйлдэлд тооцогдохгүй.

#### Ерөнхий тайлбар

Тухайн хориглосон үйлдэлд аливаа этгээд оролцоогүй бол хамааралгүй гуравдагч этгээдийн хийсэн үйлдлийн төлөө тухайн этгээд хариуцлага хүлээх ёсгүй.



- 22 -

## ХАВСРАЛТ Б

### ХОРИГЛОХ ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ

- Үйл ажиллагаа явуулж буй улсын хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээрийн дагуу хууль бусад тооцогдох бүтээгдэхүүн, үйл ажиллагаа эсхүл эмийн бүтээгдэхүүн, пестицид/гербицид, озон задалдаг бодис, полихлоржуулсан бифенил, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцоор зохицуулсан зэрлэг ан амьтан, бүтээгдэхүүн зэрэг олон улсын хоригт хамаарах үйлдвэрлэл, худалдаа.
- Зэвсэг, цэргийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа.<sup>2</sup>
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа (шар айраг, дарснаас бусад).<sup>2</sup>
- Тамхины үйлдвэрлэл, худалдаа.<sup>2</sup>
- Мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа.<sup>2</sup>
- Цацраг идэвхт материалын үйлдвэрлэл, худалдаа. Энэ нь ОУСК-иас цацраг идэвхт эх үүсвэрийг өчүүхэн ба/эсхүл хангалттай хамгаалагдсан гэж үзсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, чанарын хяналтын (хэмжилтийн) төхөөрөмж болон аливаа тоног төхөөрөмжийг худалдан авахад хамаарахгүй.
- Давхарлаагүй асбестын угас үйлдвэрлэх, худалдаалах. Энэ нь асбестын агууламж 20%-иас бага байх давхарласан асбест цементэн хавтанг худалдан авах, ашиглахад хамаарахгүй.
- Далайн орчимд 2.5 км-ээс урт зайд тор ашиглан дрифт тороор загасчлах.
- Албадан хөдөлмөр<sup>3</sup>/хүүхдэд аюултай хөдөлмөрийн буюу мөлжлөгийн хэлбэрийг агуулсан үйлдвэрлэл, үйл ажиллагаа.<sup>4</sup>
- Энгийн халуун орны чийглэг ойд ашиглах арилжааны мод бэлтгэх үйл ажиллагаа.
- Тогтвортой менежменттэй ойгоос бусад мод болон бусад ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа.

<sup>2</sup> Энэ нь эдгээр үйл ажиллагаанд бодитойгоор оролцдоггүй төслийн санхүүжүүлэгчдэд хамаарахгүй. "Бодитойгоор оролцдоггүй" гэж тухайн үйл ажиллагаа нь төслийн санхүүжүүлэгчдийн үндсэн үйл ажиллагааны дагалдах үйл ажиллагааг хэлнэ.

<sup>3</sup> Албадан хөдөлмөр гэж хүч хэрэглэх, шийтгэхээр заналхийлсний улмаас хувь хүнээс сайн дураар гүйцэтгээгүй бүх ажил, үйлчилгээг хэлнэ.

<sup>4</sup> Хүүхдэд аюултай хөдөлмөр гэж эдийн засгийн хувьд мөлжсөн, хүүхдийн боловсролд хохиролтой, саад учруулах, хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд нь хор хөнөөл учруулахуйц хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хэлнэ.



## **Хурлаар шийдвэрлэх наймдугаар асуудал:**

**ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай**



## КОМПАНИЙГ НЭГТГЭХ ҮНДЭСЛЭЛ

- ТСН ба ХасБанк нь **Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх** хэсэг ба Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа нь **тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй** байх шаардлагатай болсон.
- ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SGR-2023-02 тоот тогтоол ба ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SR-2023-02 тоот тогтоолын дагуу, ТСН-ийн үйл ажиллагааг нэгдэж байгаа компанийн хувьд зогсоож, нэгтгэж байгаа компанийн хувьд **ХасБанкны үйл ажиллагааг үргэлжлүүлэх замаар ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх**, үр дүнд нь **ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болох** нь Банкны тухай хуулийн шаардлагыг хангах хамгийн тохиромжтой арга зам гэж үзэж байна.
- Банкны тухай хуулийн шаардлагыг хангах зорилгоор **Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл ба Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлд** заасны дагуу ТСН ба ХасБанкны Нэгтгэлийг хийж буй болно.

**Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь 2021 оны 1 дүгээр сард батлагдсан бөгөөд тус өөрчлөлтийг дагаж мөрдөх зорилгоор Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д дараах бүтцийн өөрчлөлтийг хийж, дуусгасан болно. Үүнд:**

- ХасЛизинг ХХК-ийг ХасБанкинд нэгтгэсэн;
- Тэнгэр Даатгал ХХК, Тэнгэр Капитал ХХК, болон ТианРонг санхүүгийн байгууллагыг гуравдагч талд худалдсан;
- Глашиер Ассет ХХК-г татан буулгасан.
- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК дахь санхүүгийн өр төлбөрүүдийг барагдуулж, компанийн тайлан тэнцлийг нэгтгэлд бэлдсэн.



\* Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь төлөвлөгөөний дагуу 2023 онд хувьцааг эргүүлэн худалдан авсан.


\*\*ХасБанк IPO хийхээс өмнөх үеийн байдлаарх хувь эзэмшил.

\*\*\*2021 оны 11 сард ХасБанканд нэгтгэсэн.

## 2024 оны 3 дугаар сарын байдлаарх компанийн бүтэц

- Өнгөрсөн 2 жил гаруй хугацаанд Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагаж биелүүлэх зорилгоор ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д холбогдох бэлтгэл ажлуудыг хийж, өнөөдрийн байдлаар (ХЭХурлын материал танилцуулах үеийн) Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанк ХК-д нэгтгэхэд үйл ажиллагаа болон хууль эрх зүйн хувьд бэлэн болсон байна.
- Ийнхүү нэгтгэлийг **Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл ба Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлд** заасны дагуу хийснээр Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, ХасБанк ХК-ийн үйл ажиллагаа цаашид хэвийн үргэлжлэх болно.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ХасБанк дахь шууд бус хувь эзэмшил



\*Компанийн нэгтгэлийн дараа Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК үйл ажиллагаагаа зогсоож (татан буугдах), түүний одоогийн хувьцаа эзэмшигчид нь ХасБанк ХК-ийн шууд хувьцаа эзэмшигчид болно. Энэхүү нэгтгэл нь ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьд ХасБанкны шууд болон шууд бус хувь эзэмшилд аливаа нөлөө үзүүлэхгүй болно.

## ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь хөрөнгө оруулалтын холдинг компани бөгөөд 2021 оноос эхлэн Банкны тухайн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөх зорилгоор үйл ажиллагаагаа хумиж, өнөөдрийн байдлаар зөвхөн ХасБанк ХК-ийн 1,000,000,000 ширхэг хувьцааг хөрөнгө оруулалт хэлбэрээр эзэмшиж байна.
- Компани нь Гүйцэтгэх захирал (Г.Цэвэгжав) болон Нягтлан бодогч (Н.Отгончулуун) гэсэн үндсэн орон тоотой ажилладаг бөгөөд тус ажилтнууд нь ХасБанк ХК-д үндсэн ажилтнаар ажилладаг.
- Компани нь үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө эзэмшдэггүй. Үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр явуулдаг.

**Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн санхүүгийн хураангуй тэнцэл\*:**

Сая төгрөгөөр

2023/12/31-ний өдрийн байдлаарх үлдэгдэл (аудитлагдсан)	
Мөнгөн хөрөнгө	1,307.2
Хөрөнгө оруулалт (ХасБанк ХК-ийн 1,000,000,000 ширхэг хувьцаа)	101,817.8
Бусад	50.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>103,175.2</b>
Татварын болон бусад өр төлбөр	12.2
<b>Нийт өр төлбөр</b>	<b>12.2</b>
Энгийн хувьцаа	16,270.5
Нэмж төлөгдсөн капитал	55,425.2
Нөөцийн сан	809.5
Хуримтлагдсан ашиг	30,657.8
<b>Эздийн өмч</b>	<b>103,163.0</b>
<b>Эздийн өмч ба нийт өр төлбөр</b>	<b>103,175.2</b>

\*Нэгтгэлийн гэрээнд нэгтгэл хийх үеийн байдлаарх хамгийн сүүлийн сарын санхүүгийн тайланг хавсаргаж, нэгтгэлийг хэрэгжүүлэх тул энэхүү танилцуулгад тусгасан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан нь зөвхөн мэдээллийн зорилготой болно.

**Нэг. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр**

- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанк ХК-д нэгтгэх талаар гаргасан хоёр компанийн хувьцаа эзэмшигчдийн тус тусын шийдвэрүүд;

**Хоёр. Зохицуулагч байгууллагуудын зөвшөөрөл**

- ХасБанк ХК-д Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрсөн Монголбанкны албан бичиг;
- ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн талаар Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн зөвшөөрлүүд;
- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, компанийг татварын бүртгэлээс хасалт хийлгэх.

## ХУВЬЦАА ХӨРВҮҮЛЭЛТ

Хувьцаа хөрвүүлэх харьцаа =  $\frac{1,000,000,000}{16,270,503} = 61.46091488...$

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн эзэмшиж буй ХасБанк ХК-ийн хувьцааны тоо ширхэг

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг

	ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчид	ТСН ХХК-ийн хувьцааны тоо ширхэг	Хөрвүүлэх харьцаа	ХасБанк ХК-д эзэмших хувьцааны тоо ширхэг	ХасБанк ХК-ийн гаргасан нийт хувьцаанд эзлэх хувь
1	МАК Invest Kft.	3,316,985	61.46091488	203,864,933	19.37%
2	IFC	2,847,794		175,028,025	16.63%
3	Orix Corporation	2,788,218		171,366,429	16.28%
4	EBRD	2,140,273		131,543,137	12.50%
5	National Bank of Canada	1,744,107		107,194,412	10.18%
6	Ronoc Partners	1,683,342		103,459,739	9.83%
7	Mongolia Financial Services	1,098,764		67,531,041	6.42%
8	Triodos Fair Share Fund	618,680		38,024,639	3.61%
9	М.Болдоо	16,968		1,042,868	0.10%
10	Ч.Ганболд	15,372		944,777	0.09%
	<b>Нийт</b>	<b>16,270,503</b>		<b>1,000,000,000</b>	<b>94.99%</b>

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг

### Нэгтгэлийн өмнөх:


Олон нийт 52,700,000



Хувьцааны тоо:  
1,052,700,000

### Нэгтгэлийн дараах:

Олон нийт 52,700,000



## Нэгтгэлийн дараах үйл явц

- Банкны тухай хуулийн **36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг** ба Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа нь тухайн банкны **нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангана.**
- Нэгтгэлийн дараа ХасБанк ХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд аливаа нөлөө гарахгүй болно.
- Компанийн тухайн хуулийн 53.1.1 дэх хэсэгт заасны дагуу нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардсан тохиолдолд үүнтэй холбоотой санхүүгийн үр дагавар үүсч болно.
- Нэгтгэлийн дараа Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-иас өвлөгдөж болзошгүй, одоогоор мэдэгдээгүй байгаа аливаа санхүүгийн үүрэг, өр төлбөр (татвартай холбоотой төлбөр гэх мэт)-ийг барагдуулах үүднээс Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь тусгай эскроу данс нээлгэж, баталгаа болгох зорилгоор нэгтгэх баланс гарах өдрийн байдлаарх тодорхой дүнг байршуулна. Энэ талаар нэгтгэлийн гэрээний 4.2 дахь хэсгээс үзнэ үү.

## ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн эрх

- Компанийн тухайн хуулийн 53.1.1 дэх хэсэгт заасны дагуу нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.
- Компанийн тухай хуулийн 53.5-д зааснаар Хувьцааг эрх үүсэх үеийн зах зээлийн үнээр худалдан авах ба энэхүү зах зээлийн үнийг Компанийн тухай хуулийн 55.7, 55.2-д зааснаар хараат бус үнэлгээний байгууллага, аудитын байгууллагын дүгнэлтийг үндэслэн, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын болон бусад арилжааны албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөл тодорхойлно.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал болсны дараа Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуулийн 54.1-д заасны дагуу хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх, түүнийг хэрэгжүүлэх журмыг батлан хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Нууц баримт



ӨМГӨӨЛЛИЙН  
БАТБАЯР ЭНД  
ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: [contact@bnp.mn](mailto:contact@bnp.mn). Веб: [www.bnp.mn](http://www.bnp.mn)

Огноо: 2024.03.22  
Дугаар: BNP-87/24  
Утга: Хуулийн дүгнэлтийн хураангуй

ХАСБАНК ХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ  
ТАНАА



Амьдралд - ашигд хамтдаа.

ХАСБАНК ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН  
ХУУЛИЙН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

Нэг. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх асуудлаар:

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны [●] сарын [●]-ны өдрийн ээлжит хурлын №[●] тоот [●] тогтоол гаргасан байна.

[Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаар энэ хэсгийн дүгнэлт бичигдэнэ.]

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч ХасБанк ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд [●] байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Хоёр. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

ХасБанк ХК нь нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдахдаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж хариу авсан байхыг зээлийн гэрээний дагуу шаардаж байх тул ХасБанк ХК нь гэрээний үүргээ хэрэгжүүлэн нэгтгэх замаар Банкны хэлбэрийг өөрчлөх талаар албан ёсны мэдэгдлийг зээлдүүлэгч нарт хүргүүлж хариу авсан байхыг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.

ХасБанк ХК-ийн худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсээгүй байна гэж дүгнэлээ.

Гурав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасныг үндэслэн дүгнэвэл ХасБанк ХК-ийн Батламж гаргах тухай албан бичиг болон аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив болон балансын активын 25 хувийн дүнд үндэслэн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар ХасБанк ХК нь их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.





## ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Нууц баримт

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэж үзвэл ХасБанк ХК-ийн зүгээс 2021 оны 03 сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд байгуулагдсан гэрээ, хэлцлийн жагсаалт болон Банкнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэж үзвэл нийт 23 (хорин гурван) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснийг баталгаажуулсан/зөвшөөрөл олгосон байна.

Дүгнэж үзвэл ХасБанк ХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй 23 (хорин гурван) сонирхлын зөрчилтэй хэлцлийг Банкны төлөөлөн удирдах зөвлөлөөс баталгаажуулсан/зөвшөөрөл олгосон тул холбогдох хуульд нийцсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

**Дөрөв. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан эсэх, үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүрэг, тэдгээрийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэртэй холбоотой шаардах эрх хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан эсэх асуудлаар:**

Хуулийн фирмийн зүгээс ХасБанк ХК-ийн үйл ажиллагаандаа батлан мөрдүүлсэн компанийн засаглалд хамаарах 22 (хорин хоёр) дүрэм, журам нь Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл ХасБанк ХК нь Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүрэг биелүүлэн, тэдгээрийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч **[хэрэгжүүлсэн байна]** гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Тав. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх асуудлаар:**

ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны [●] сарын [●]-ний өдрийн ээлжит хурлын [●] тогтоолын дагуу [●] шийдвэрлэсэн байна.

**[Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр гарахаар энэ хэсгийн дүгнэлт бичигдэнэ.]**

Хуулийн этгээдийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотойгоор хуульд заасан аливаа хязгаарлалт байгаа эсэх асуудлын хувьд Банкны тухай хуульд зааснаар Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж болохоор хуульчилсан. Монголбанкны 2024 оны [●] сарын [●]-ны өдрийн тогтоолын дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанк ХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдахыг зөвшөөрч, [●] байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл ХасБанк ХК-ийн нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж буй шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт **[нийцсэн байна]** гэж үзлээ.

Мөн ХасБанк ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2024 оны 03 сарын ..... өдрийн №..... тоот тушаалаар баталсан “Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам” болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдөр КТХ-ийн 53 болон 54 дүгээр зүйлд шаардсан үүргийг **[хэрхэн хэрэгжүүлснээс хамааран]** байх тул хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт **[нийцсэн]** байна.

**Зургаа. Үнэт цаас гаргагчтай нэгдэж буй хуулийн этгээд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт:**



## ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Нууц баримт

- (i) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл нь улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр эсэх асуудлаар:

Хуулийн дүгнэлт гаргаж өгөх өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байх бөгөөд тус компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл нь улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

- (ii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарласан болон гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон хувьцаанд хамаарах үнэт цаас нь хүчин төгөлдөр эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 24,685,859 (хорин дөрвөн сая зургаан зуун наян таван мянга найман зуун тавин ес) ширхэг зарласан хувьцаатай, 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 16,270,503 (арван зургаан сая хоёр зуун далан мянга таван зуун гурав) ширхэг гаргасан энгийн хувьцаатай бөгөөд үүнээс бусдаар аливаа хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаагүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Хуулийн дүгнэлт хийж гүйцэтгэх өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ирүүлсэн баримт материалд үндэслэн тус Компани нь аливаа хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаагүй бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарласан болон гаргасан хувьцаа нь аливаа үүргийн гүйцэтгэл хангах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

- (iii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ, хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-иас ирүүлсэн баримт материалаас үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 8 (найман) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

- (iv) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Батламж гаргах тухай албан бичигт үндэслэн тасалбар болгосон өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д хүчин төгөлдөр үйлчилж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулаагүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

- (v) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээртэй холбоотой лицензийн гэрээ, оюуны өмчийн аливаа маргаан байгаа эсэх асуудлаар:

Хуулийн дүгнэлт үйлдэх өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д төрийн эрх бүхий этгээдээс тусгай зөвшөөрөл олгогдоогүй байгаа тул тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааны хүрээнд бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр олгогдсон үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл байхгүй, ямар нэгэн лиценз, зохиогчийн эрх, патент эзэмшдэггүй, эрхийн хамгаалалт хийгдэж, бүртгэгдсэн 6 (зургаан) барааны тэмдэг хугацаа дууссан бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна гэж дүгнэлээ.

- (vi) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас гаргаж өгсөн мэдээлэл, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2024 оны 02 сарын 08-ны өдрийн №3 тоот Үнэт цаас эзэмшлийн



## ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Нүүц баримт

тодорхойлолт болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас авсан мэдээлэлд үндэслэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 1 (нэг) төрлийн 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг үнэ хувьцаа эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн хэлцэл хийгдээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ирүүлсэн мэдээлэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 02 сарын 13-ны өдрийн Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх тухай лавлагаа болон 2024 оны 02 сарын 07-ны өдрийн Аж ахуйн нэгж, байгууллагын татварын тодорхойлолтоор зөрүүтэй байдал илэрсэн байх тул дурдагдсан автотээвэр, өөрөө явагч хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгахыг зөвлөж байна.

**(vii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хөдөлмөрийн гэрээ, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөө, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх төлөвлөгөө, болзошгүй өр төлбөрийн бодлого нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:**

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан Үйлчилгээний гэрээ нь Иргэний хуульд, Гүйцэтгэх захирал болон нягтлан бодогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуульд тус тус нийцсэн байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ажилчдад хамаарах хөдөлмөрийн дотоод журам, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөө, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх төлөвлөгөө, болзошгүй өр төлбөрийн бодлогыг Хуулийн фирмд ирүүлээгүй тул дурдсан төлөвлөгөө болон баримт бичгийг батлан мөрдүүлээгүй гэж Хуулийн фирмээс үзлээ.

**(viii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх асуудлаар:**

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 07 сарын 20-ны өдрийн №А-30/2011 тоот тушаалаар “Нийгэм, байгаль орчны удирдлагын бодлого”-ыг өөрийн болон түүний хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөөр баталсан байна.

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байгаа байгаль орчинтой холбоотой журам нь хууль тогтоомжийн хүрээнд байгаа эсэх талаар шалгасан бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг тул хуульд тусгайлан үүрэг болгосон шаардлага байхгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**(ix) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн даатгалын бодлого нь холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангаж байгаа эсэх асуудлаар:**

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2023 оны 05 сарын 25-ны өдөр ТэнГэр даатгал ХХК-тай байгуулсан №23/006 дугаартай Даатгалын ерөнхий гэрээ болон тус гэрээний дэд гэрээ болох Удирдах ажилтны хариуцлагын даатгалын гэрээг тус тус байгуулсан нь тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Удирдах ажилтны хариуцлагын даатгалын дэд гэрээний хувьд 2024 оны 05 сарын 23-ны өдрийн 23 цаг 59 минут хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр хэрэгжихээр байх бөгөөд даатгалын үнэлгээ нь 10,000,000 (арван сая) ам.доллартай тэнцүү төгрөг байхаар талууд харилцан тохиролцжээ.

Тус дэд гэрээнд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь даатгалын хураамж болох 68,545 (жаран найман сая таван зуун дөчин таван мянган) ам.доллартай тэнцүү төгрөгийг 2023 оны 05 сарын 30-ны өдөрт багтаан даатгагчид төлөхөөр заасан байна.

Иймд Хуулийн фирмээс ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ТэнГэр даатгал ХХК-тай байгуулсан Удирдах ажилтны хариуцлагын даатгалын дэд гэрээнд заасан даатгалын хураамж төлөх үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзэх үндэслэлтэй гэж үзсэн бөгөөд ХасБанк ХК нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг өөртөө нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдах тохиолдолд дурдсан



## ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Нууц баримт

даатгалын гэрээний хүчин төгөлдөр байдал болон хэрхэн эрх залгамжлах, дуусгавар болох, цуцлах, асуудлаар нарийвчлан судаллаа.

Энэхүү Даатгалын ерөнхий гэрээ, түүний дэд гэрээ болох Удирдах ажилтны хариуцлагын даатгалын гэрээ цуцлагдсанаар Даатгалын ерөнхий гэрээний 2 дугаар зүйлийн 2.4.2 дахь заалтад заасны дагуу даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд ногдох хураамж болон даатгалтай холбогдон гарсан зардал, үзүүлсэн үйлчилгээний хөлсийг хасаж, хураамжийг дэд гэрээнд заасны дагуу тооцон буцаан олгох үр дагавартай байна. Харин энэхүү даатгалын ерөнхий гэрээний хугацаанд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас нөхөн төлбөр авсан тохиолдолд даатгагч гэрээний үүргээ биелүүлсэн гэж үзэн хураамжийг буцаан олгохгүй байхаар гэрээнд тусгайлан зохицуулсан байна.


(x) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн өмнө нь үүссэн, шийдвэрлэгдсэн, шалгагдаж байгаа аливаа шүүхийн хэрэг маргаан байгаа эсэх асуудлаар:

Нэгтгэн дүгнэж үзвэл ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК тасалбар болгосон өдрийн байдлаар эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй бөгөөд иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй байна. Мөн энэхүү Хуулийн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь гэмт, хэрэг зөрчилд холбогдон шалгагдаагүй, иргэний болон захиргааны хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

(xi) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх асуудлаар:

Монголын татварын албаны 2024 оны 02 сарын 07-ны өдрийн №24.1003.8ea86b45-c611-4447-9bab-d55f8088d003 тоот аж ахуйн нэгж, байгууллагын цахим лавлагаа, тодорхойлолтоос үзвэл ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь 4,336,815.40 (дөрвөн сая гурван зуун гучин зургаан мянга найман зуун арван таван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн дутуу төлөлттэй бөгөөд 62,765,296.44 (жаран хоёр сая долоон зуун жаран таван мянга хоёр зуун ерэн зургаан төгрөг дөчин дөрвөн мөнгө) илүү төлөлттэй болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан төрийн эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь дээр дурдсан татварын дутуу төлөлтөөс бусдаар нийгмийн даатгал, шийдвэр гүйцэтгэх газарт төлөх өр төлбөргүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл ХасБанк нь Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд тогтоосон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой шалгуурыг  байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд бүхэлд нь өгсөн үнэлэлт, дүгнэлтэд тооцогдохгүй бөгөөд Хуулийн фирмийн зүгээс ХасБанк ХК-ийг хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-тай нэгтгэх замаар өөрчлөн байгуулж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан төрийн байгууллагын тавьсан шаардлагын хүрээнд буюу дээр дурдагдсан асуудлуудын хүрээнд хязгаарлагдана.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БООРЧИ





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2024 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-14

Улаанбаатар хот

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг  
ХасБанк ХК-д нэгтгэх зөвлөмж хүргүүлэх тухай

Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 20.2 дэх хэсэг болон 76.1.15 дахь заалт, ХасБанк ХК ("ХасБанк")-ийн Дүрмийн 8.6 дахь хэсэг болон 8.6 (viii) дахь заалт, мөн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТҮЗ")-ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрийн хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ нь:

- ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН") нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг ("Хуулийн шаардлага");
- ХасБанкны хувьцаа эзэмшигчид өмнө нь SR-2023-01 дүгээр тогтоол гаргаж, ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх замаар энэхүү Хуулийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзсэн, нэгдлийн үр дүнд ХасБанк үйл ажиллагаагаа үргэлжлүүлж үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохыг ("Нэгтгэх өөрчлөн байгуулалт");
- ХасБанк нь Банкны тухай хуулийн 4.2 дахь хэсэг болон Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцүүлэн, хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн болохыг;
- ХасБанкны Дүрмийн 8.6 дугаар зүйлд заасны дагуу нэгтгэх талаарх шийдвэр нь стратегийн асуудал болохын хувьд ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдах шаардлагатай болохыг;
- ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх өөрчлөн байгуулалттай холбогдуулан, ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ")-тай Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпораци ("ОУСК")-тай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд, Нэгтгэх гэрээг байгуулахыг SGR-2024-03 дугаар тогтоолоороо шийдвэрлэсэн болохыг;
- ХасБанкны хувьцааны 94.99%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч ТСН-ийн хүсэлтээр, ХасБанкийг ЕСБХБ-тай Фреймворк гэрээ болон ОУСК-тай Бодлогын гэрээг тус тус байгуулахыг зөвшөөрөх тухай ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

гаргуулах саналыг ТУЗ-ийн R-2024-13 дугаар тогтоолын дагуу ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд нэмж оруулсан болохыг; мөн

7. Хуулийн шаардлагыг цаг алдалгүй хангах үүднээс ТУЗ нь Нэгтгэх өөрчлөн байгуулалтыг батлуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

**ТОГТООХ нь:**

1. Нэгтгэх өөрчлөн байгуулалтыг 1 дүгээр хавсралтад хавсаргасан ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээний дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулсугай.
2. Нэгтгэх өөрчлөн байгуулалтад шаардагдах баримт бичгийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх зорилгоор "Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журам"-ыг 2 дугаар хавсралтад хавсаргасан байдлаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулсугай.
3. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав, Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр болон Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэг нарыг Өөрчлөн байгуулах комиссын бүрэлдэхүүнд томилж, холбогдох баримт бичгийг үйлдэх, түүнд гарын үсэг зурах, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх, бүртгүүлэх, шаардлагатай бол Банкны тухай хуулийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах комисс байгуулах зэрэг энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг даалгаж, холбогдох эрхийг тус тус олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Н.МӨНХЦЭЛМЭГ



ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Хувилбар: 2024.01.24

ОГНОО



[\*\*\*]

**Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК**

-ба-


**ХасБанк ХК-ийн**

**ХООРОНД БАЙГУУЛСАН**

**НЭГТГЭХ ГЭРЭЭ**

Монгол Улс, Улаанбаатар хот

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



Энэхүү Нэгтгэх гэрээ (бүхий л хавсралтуудын хамт цаашид "Гэрээ" гэх) [\*\*\*]-ний өдөр (цаашид "Хүчин төгөлдөр болох өдөр" гэх)


- (1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компани болох Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жамъяан Гүний гудамж, Олон улсын арилжааны төв, 16 давхар албан ёсны хаягт бүртгэлтэй, 2595788 регистрийн дугаартай Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (цаашид "ТСН" гэх); ба
- (2) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа нээлттэй хувьцаат компани болох Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, ХасБанкны байр албан ёсны хаягт бүртгэлтэй, 2578697 регистрийн дугаартай ХасБанк ХК (цаашид "ХасБанк" гэх)

(цаашид хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал" гэх) нар хоорондоо байгуулав.

УДИРТГАЛ

- A. ХасБанк нь Банкны тухай хуулийн дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банк бөгөөд ТСН нь одоогийн байдлаар ХасБанкны нийт зарласан болон гаргасан хувьцааны 94.99 хувь буюу 1,000,000,000 (нэг тэрбум) ХасБанкны Хувьцааг эзэмшиж байгаа нөлөө бүхий хувьцаа эзэмшигч мөн болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- B. ТСН ба ХасБанк нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг ба Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа нь тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг (цаашид "Банкны тухай хуулийн шаардлага" гэх) 2023 оны 12 дугаар зүйлийн 31-ний өдрөөс өмнө хангах шаардлагатай болсныг **ТЭМДЭГЛЭН**;
- C. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SGR-2023-02 тоот тогтоол ба ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SR-2023-02 тоот тогтоолын дагуу, ТСН-ийн үйл ажиллагааг нэгдэж байгаа компанийн хувьд зогсоож, нэгтгэж байгаа компанийн хувьд ХасБанкны үйл ажиллагааг үргэлжлүүлэх замаар ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх, үр дүнд нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болох (цаашид "Нэгтгэл" гэх) нь Банкны тухай хуулийн шаардлагыг хангах хамгийн тохиромжтой арга зам хэмээн тодорхойлсныг **ТЭМДЭГЛЭН**;
- D. ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн SR-2023-22 тоот тогтоолоор баталсан ХасБанкны одоогийн Дүрмийн 1.5.17, 6.10, 6.11, болон 6.12 дахь заалтуудад (Банкийг Нэгтгэх) Нэгтгэлийн тухай заасан болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- E. Нэгтгэл нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3.4 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарахгүйг тогтоосон болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- F. Нэгтгэлийг ТСН ба ХасБанк нь тус тус [\*\*\*], [\*\*\*] тоот тогтоол батлах замаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг **ТЭМДЭГЛЭН**;

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



- G. Талууд Нэгтгэл ба энэхүү Гэрээний нөхцөл, шаардлагууд нь дор заасны дагуу Монгол Банк, СЗХ, МХБ (дор тодорхойлсон) зэрэг байгууллагуудаар хязгаарлагдахгүйгээр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудын шаардлагатай бүхий л зохицуулалтын зөвшөөрөл, зөвшөөрөл, шийдвэр, тогтоолд нийцсэн байх ёстойг ойлгож, хүлээн зөвшөөрсөн болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- H. Банкны тухай хуулийн шаардлагыг хангах зорилгоор Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл ба Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу ТСН ба ХасБанкны Нэгтгэлийг хийх зорилгоор энэхүү Гэрээг байгуулсан болохыг Талууд ойлгож, харилцан тохиролцсон бөгөөд Тал тус бүр энэхүү Гэрээнд заасны дагуу Нэгтгэл хийсний үр дүнд аливаа эдийн ба эдийн бус ашиг, орлого, шагнал, аливаа хэлбэрийн мөнгөн урамшуулал авахгүй гэдгийг зөвшөөрсөн болохыг тус тус **ТЭМДЭГЛЭН**;

Дор дурдсаныг харилцан тохиролцож **ШИЙДВЭРЛЭВ**:

1. **НЭР ТОМЬЁО, ТАЙЛБАР**

1.1 **Нэр томьёо**

Энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёо нь дор дурдсан утгыг илэрхийлнэ:

“**Холбогдох хууль**” гэж энэхүү Гэрээтэй холбогдуулан Талуудын хувьд хууль ёсны, хэрэгжих боломжтой, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, журам, дүрэм, мэдэгдэл ба бусад хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэр, мэдэгдлийг хэлнэ;

“**Зөвшөөрөл**” гэж Төрийн эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, баталгаажуулалт, баталгаа эсхүл бүртгэл эсхүл Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн бүртгэлийг хэлнэ;

“**Банкны тухай хууль**” гэж 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Монгол Улсын Банкны тухай хуулийг хэлнэ;

“**Монгол Банк**” гэж Монгол Улсын Төв банкиг хэлнэ;

“**Компанийн тухай хууль**” гэж 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Монгол Улсын Компанийн тухай хуулийг хэлнэ;

“**ЕСБХБ**” гэж энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар ТСН-ийн хувьцаа эзэмшигч буюу олон улсын гэрээний дагуу байгуулагдсан олон улсын байгууллага болох Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкныг хэлнэ;

“**СЗХ**” гэж Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороог хэлнэ;

“**Төрийн эрх бүхий байгууллага**” гэж Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч, зохицуулагч, тохируулагч агентлаг, албан тушаалтан ба бусад хуулийн этгээд (үүнд төрийн захиргааны төв, аймаг, өөрөө удирдах болон орон нутгийн байгууллагууд хамаарна), тэдгээрийн аливаа газар, хэлтэс, түүнчлэн төрийн өмчит эсхүл төрийн өмчийн оролцоотой аливаа хуулийн этгээд, аж ахуйн нэгж эсхүл шүүх, шүүхийн бусад байгууллагыг хэлнэ;

## ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



“ОУСК” гэж энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар ТСН-ийн хувьцаа эзэмшигч буюу Монгол Улс ба гишүүн орнуудтай байгуулсан Үүсгэн байгуулах хэлэлцээрийн дагуу үүсгэн байгуулагдсан олон улсын байгууллага болох Олон Улсын Санхүүгийн Корпорацийг хэлнэ;

“ХЭБГ” гэж Монгол Улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрыг хэлнэ;

“ҮЦТХТ” гэж Монгол Улсын Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийг хэлнэ;

“Нэгтгэх зөвшөөрөл” гэж Нэгтгэлийг баталсан ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын [\*\*\*] өдрийн [\*\*\*] тоот тогтоолыг хэлнэ;

“Нэгтгэлийн хаалтын өдөр” гэж энэхүү Гэрээний 4.1 дэх заалтад заасан өдрийг хэлнэ;

“Төгрөг” гэж Монгол Улсын одоогийн хууль ёсны мөнгөн тэмдэгт буюу төгрөгийг хэлнэ;”

“МХБ” гэж Монголын Хөрөнгийн Биржийг хэлнэ;

“Нэгтгэсний дараах нэгдсэн тайлан баланс” гэж 4.5 дахь заалт дахь нэр томъёонд заасан утгатай байна;

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” гэж 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хэлнэ;

“ХЭГ” гэж ТСН ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн хооронд, тэдгээрийн байгуулсан 2013 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн (тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан) хувьцаа эзэмшигчдийн гэрээг хэлнэ;

“Хувь нийлүүлсэн хөрөнгө” гэж компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй буюу компанийн гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн нийт дүнг хэлэх бөгөөд үүнд зарласан буюу эргүүлэн худалдаж авсан хувьцаа хамаарахгүй;

“ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид” гэж энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар ТСН-ийн Хувьцааг эзэмшиж байгаа, ХЭБГ-т бүртгэлтэй 3 дахь заалтад жагсаасан арван хувьцаа эзэмшигчийг хэлнэ;

“ТСН-ийн Хувьцаа” гэж ТСН-ийн Хувь нийлүүлсэн хөрөнгө дэх энгийн хувьцааг хэлнэ;

“ХасБанкны Хувьцаа эзэмшигчид” гэж ХасБанкны Хувьцааг эзэмшиж байгаа, ҮЦТХТ-д данстай аливаа этгээдийг хэлнэ;

“ХасБанкны Хувьцаа” гэж ХасБанкны Хувь нийлүүлсэн хөрөнгө дэх энгийн хувьцааг хэлнэ;

### 1.2 Тайлбар

(а) Энэхүү Гэрээнд:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай




- (i) өөрөөр заагаагүй бол зүйл, хэсэг, хавсралтыг иш татсаныг энэхүү Гэрээний Зүйл, Хэсэг, Хавсралтыг иш татсан гэж ойлгоно;
  - (ii) аливаа хууль тогтоомж, хууль тогтоомжийн заалтуудыг иш татсан нь Хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө шинэчлэн найруулсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацааг сунгасан байдлаар тухайн хууль тогтоомж, хууль тогтоомжийн заалтуудыг иш татсан гэж ойлгох бөгөөд үүнд Хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө дагалдан гарсан аливаа хууль тогтоомж (шинэчлэн найруулсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацааг сунгасан байдлаар)-ийг иш татсан гэж ойлгоно;
  - (iii) "этгээд" гэж иш татсаныг аливаа хувь хүн, компани, корпорац, фирм, нөхөрлөл, хамтарсан нэгдэл, үйлдвэр, холбоо, улс, засгийн газрын агентлаг, институц, траст (тусдаа хуулийн этгээдийн эрхтэй эсэхээс үл хамааран) гэж ойлгоно;
  - (iv) нэг хүйсийг иш татсаныг аливаа эсхүл бүхий л хүйсийг иш татсан гэж ойлгоно;
  - (v) өөрөөр заагаагүй бол өдрийн тодорхой нэг цагийг иш татсаныг Монгол Улсын Улаанбаатар хотын цагийг иш татсан гэж ойлгоно;
  - (vi) "үүнд хамаарах" ба "хамаарах" гэж иш татсаныг тодорхойлж байгаа үгийн утгын хамрах хүрээг хязгаарлахгүйгээр ойлгоно;
- (b) Хавсралт нь энэхүү Гэрээний нэг хэсэг болох бөгөөд "энэхүү Гэрээ" гэж иш татсаныг Гэрээний Хавсралтуудыг хамааруулан иш татсан гэж ойлгоно; мөн
- (c) Энэхүү Гэрээний гарчгууд нь Гэрээг тайлбарлахад нөлөөлөхгүй.

2. **Нэгтгэл**

- 2.1 Нэгтгэлийг Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл ба Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт нийцүүлэн энэхүү Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 2.2 Нэгтгэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТСН-ийн эзэмшиж байгаа ХасБанкны Хувьцааг энэхүү Гэрээний 3 дахь заалтад заасны дагуу хөрвүүлнэ.
- 2.3 Зөвхөн дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд, ХасБанк, ТСН нь Нэгтгэлийг ХЭБГ-т бүртгүүлэх, ТСН-ийг татвар төлөгчийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлээс хасуулахаар хүсэлт гаргаж болно:
- (a) ТСН ба ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гаргаж энэхүү Гэрээний дагуу Нэгтгэл хийхийг зөвшөөрч, баталсан байх;
  - (b) ХасБанк нь Холбогдох хуулийн дагуу Нэгтгэлтэй холбогдуулан Монгол Банкнаас зохих ёсоор зөвшөөрөл авсан байх;
  - (c) ХасБанк нь Нэгтгэл, үнэт цаасны бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах тухайд СЗХ, МХБ-ээс зохих ёсоор зөвшөөрөл авсан байх;
  - (d) СЗХ-ны зохих зөвшөөрлийг авч, ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид ХасБанкны Хувьцааг доорх 3-р зүйлд заасан тоогоор эзэмших эрхийг ҮЦТХТ-д нэр тус бүрээр бүртгүүлсэн байх;


Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



- 2.4 (i) Нэгтгэлийг баталсан ТСН болон ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурал тус тус хуралдсан өдөр; эсхүл (ii) Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь хэсэгт заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй болох тухай бичгээр хүргүүлсэн мэдэгдлийг тус тус хүлээн авсан өдрүүдийн аль сүүлчээс нь эхлэн ажлын гучин (30) өдрийн дотор Талууд Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1 дэх заалт ба 54 дүгээр зүйлийн дагуу ТСН болон ХасБанкны өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгүүлнэ.
- 2.5 Хэрэв өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй аливаа хувьцаа эзэмшигч дээрх 2.4 дэх заалтад заасны дагуу ажлын гучин (30) өдрийн дотор эрхээ хэрэгжүүлэх шийдвэрээ бүртгүүлээгүй бол тухайн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн дагуу хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзнэ. ТСН ба ХасБанк нь хувьцаа эзэмшигчдэд өгөх холбогдох мэдэгдэл, баримт бичгүүдэд энэ асуудалтай холбоотой татгалзлын тухай тодорхой мэдээллийг зааж өгнө.
- 2.6 ТСН ба ХасБанкны Хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх нь зөвхөн СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан шаардлагын дагуу СЗХ-оос Нэгтгэлийг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой болно.
- 2.7 Энд өөрөөр заасныг үл харгалзан, Нэгтгэх зөвшөөрөл олгосон өдөр ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх нь ХасБанкны Хувьцааг ХасБанк эргүүлэн худалдаж авахыг Монгол Банкнаас зөвшөөрснөөр хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой болно.
- 2.8 Талууд компанийн хувьд шаардлагатай бүхий л зөвшөөрлийг бэлтгэх, олгох, батлах, мөн Зөвшөөрөл авахад шаардлагатай бүхий л хүсэлтийг дагалдах баримт бичгийн хамт Монгол Банк, СЗХ, МХБ, ХЭБГ, харьяа татварын алба зэрэг байгууллагуудаар хязгаарлагдахгүйгээр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудад бэлтгэж хүргүүлэх үүрэгтэй бөгөөд Нэгтгэлийг хэрэгжүүлж, дуусгахад шаардлагатай аливаа үйлдлийг хийх үүрэгтэй.
- 2.9 Талууд дээрх 2.3 дахь заалтын нөхцөлүүдийг хангахад шаардлагатай бүхий л үйлдлийг хийхэд бүрэн дүүрэн хамтран ажиллах, Нэгтгэлийг хэрэгжүүлж, дуусгахад шаардлагатай эсхүл шаардсан аливаа бусад гэрээ байгуулах, баримт бичгийг батлах үүрэгтэй.
- 2.10 Талууд Холбогдох хуулийн дагуу Нэгтгэлийн тухай өөрсдийн бүх зээлдүүлэгч, үйлчлүүлэгчдэд зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
3. **ХУВЬЦААНЫ ҮНЭ ТОГТООХ, ХӨРВҮҮЛЭХ ЖУРАМ**
- 3.1 Энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар ТСН нь ХасБанкны нийт зарласан болон гаргасан хувьцааны 94.99 хувь буюу нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг ХасБанкны Хувьцааг эзэмшиж байгаа болно. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид нь ТСН-ийн зарласан болон гаргасан хувьцааны 100 хувийг бүрдүүлж буй нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй 16,270,503 (арван



ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



зургаан сая хоёр зуун далан мянга таван зуун гурав) ширхэг ТСН-ийн Хувьцааг хамтран эзэмшиж байгаа болно.

- 3.2 ТСН-ийн Хувьцаа бүрийг ХасБанкны Хувьцаанд хөрвүүлэх харьцааг тогтоохдоо ТСН-ийн эзэмшиж байгаа ХасБанкны Хувьцаа (1,000,000,000 ширхэг хувьцаа)-ны тоог ТСН-ийн нийт Хувьцаа (16,270,503)-ны тоонд хуваана. Үүний үр дүнд 61.46091488 ширхэг ХасБанкны Хувьцаа нь ТСН-ийн нэгж Хувьцаа бүрд ногдохоор хөрвүүлэх харьцааг ТСН-ийн Хувьцаа эзэмшигч бүрд хуваарилагдах ХасБанкны нийт хувьцааны тоог тодорхойлоход ашиглана. ХасБанкны Хувьцааг эцсийн байдлаар хөрвүүлэхэд бутархай тоо гарах тохиолдолд тухайн бутархай тоо нь 0.5-аас бага бол бүхэл тоо болгож бууруулах, 0.5-аас их бол бүхэл тоо болгож нэмэгдүүлнэ.
- 3.3 Энэхүү Гэрээний 3.2 дахь заалтыг үл харгалзан, Магван овогтой Болдоо нь Хавсралт 1-д хавсаргасан нэмэлт баримт бичиг (цаашид "Нэмэлт баримт бичиг" гэх)-ийг үйлдэж, хүргүүлснээр ТСН-ийн нэгж Хувьцаа бүрийг ХасБанкны Хувьцаанд хөрвүүлэхэд энэхүү Гэрээнд заасны дагуу хөрвүүлэх харьцааг хэрэглэсний үр дүнд ХасБанк дахь өөрийн эзэмшлийн бутархай хувьцааг 3.2 дахь заалтад заасны дагуу нэмэгдүүлэх бус ХасБанкны Хувьцааны хамгийн ойр бүтэн тоо болгож бууруулан тооцох талаар тодорхой ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно. Нэмэлт баримт бичигт гарын үсэг зурснаар Магван овогтой Болдоо нь сайн дураар энэхүү арга замыг зөвшөөрч, 3.2 дахь заалтын дагуу бутархай хувьцаагаа бүхэл тоо болгож нэмэгдүүлэхийг шаардах аливаа эрхээсээ татгалзаж байгаа болно.
- 3.4 Дээр дурдсаныг үндэслэн, ТСН-ийн Хувьцааг ХасБанкны Хувьцаанд хөрвүүлсэн үр дүн, ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдэд олгох хуваарилалт нь дор дурдсаны дагуу байна. Үүнд:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	ТСН-ийн Хувьцаа	Хөрвүүлсний дараах ХасБанкны Хувьцаа
1	МАК Инвест КэйЭфТи	3,316,985.00	203,864,933.00
2	Олон Улсын Санхүүгийн Корпорац	2,847,794.00	175,028,025.00
3	ОРИКС Корпорац	2,788,218.00	171,366,429.00
4	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк	2,140,273.00	131,543,137.00
5	Канадын Үндэсний Банк	1,744,107.00	107,194,412.00
6	Ронк Партнерз КэйЭфТи	1,683,342.00	103,459,739.00
7	Монголия Файненшл Сервизис Пти. Лтд	1,098,764.00	67,531,041.00
8	Триодос Фэйр Шэйр Фанд	618,680.00	38,024,639.00
9	Магван овогтой Болдоо	16,968.00	1,042,868.00
10	Чулуун овогтой Ганболд	15,372.00	944,777.00
	<b>НИЙТ</b>	<b>16,270,503.00</b>	<b>1,000,000,000.00</b>

- 3.5 Энэхүү Гэрээний дагуу хөрвүүлж, нэгтгэж дуусмагц ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй ХасБанкны Хувьцааг хөрөнгийн биржид бүртгүүлж, чөлөөтэй арилжих боломжтой болно.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



4. Бусад эрх, үүргээ шилжүүлэх үүрэг

4.1 4.2 дахь заалтын дагуу, Нэгтгэлийг бүртгүүлж, ТСН-ийг ХЭБГ-ийн бүртгэлээс хасуулснаар (цаашид "Нэгтгэлийн хаалтын өдөр" гэх) ТСН нь аливаа гуравдагч этгээдтэй холбоотой болон аливаа гэрээ, санхүүгийн хэлцэл эсхүл Холбогдох хуульд заасны дагуу хүлээсэн эсэхээс үл хамааран бүхий л эд хөрөнгө, эрх, үүрэг, нэхэмжлэл гаргах эрх ба үүрэг хариуцлагаа ХасБанканд шилжүүлж байгаа болохыг Талууд ойлгож, зөвшөөрсөн болно. ТСН-ээс ХасБанканд шилжүүлж, хүлээлгэж өгөх эд хөрөнгө, өмч, эрх, үүрэг, нэхэмжлэл гаргах эрх, үүрэг хариуцлагыг Хавсралт 2-т заасан болно.

4.2 Энэхүү Гэрээнд заасан аливаа заалтыг үл харгалзан, ТСН-ийг татвар төлөгчийн бүртгэл ба ХЭБГ-ын бүртгэлээс хасах хүртэл аливаа гэрээ, санхүүгийн хэлцэл эсхүл Холбогдох хуульд заасны дагуу хүлээсэн эсэхээс үл хамааран татварын өр төлбөр болон аливаа бусад болзошгүй үүрэг хариуцлагыг төлөх зорилгоор ТСН нь эскроу данс үүсгэнэ. Эскроу данс дахь аливаа үлдэгдэл мөнгөн дүнг Нэгтгэл дуусгавар болсны дараа ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдэд ТСН-д эзэмшиж байгаа хувьцаанд нь хувь тэнцүүлэн хуваарилна. Үлдэгдэл мөнгөн дүнг хуваарилах нөхцөл, шаардлагуудыг ТСН ба эскроу данс нээсэн банкны хооронд байгуулах эскроу дансны гэрээнд тусгана. Энэхүү Гэрээ байгуулах өдрийн байдлаар, эскроу дансанд байршуулсан мөнгөн дүн нь [\*\*\*] байна.

4.3 Нэгтгэлийн хаалтын өдрийн байдлаар, ТСН нь 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг ХасБанкны Хувьцаа болон энэхүү гэрээний 4.2 дахь заалтад заасан эскроу дансанд байршуулсан мөнгөн дүнгээс 4.2 дахь заалтад заасны дагуу болзошгүй өр төлбөрт төлөхөөр хассан мөнгөн дүнгээс өөр эд хөрөнгөгүй буюу аливаа үүрэг хариуцлагагүй байна.

4.4 Талууд эцсийн балансыг бэлтгэн гаргаж, эцсийн балансаа харьяалах татварын алба, Сангийн яамны бусад нэгж, газруудыг хамааруулах ба үүгээр хязгаарлагдахгүйгээр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудаар батлуулах үүрэгтэй.


4.5 Энэхүү Гэрээний 4.1 дэх заалтад нөлөөлөхгүйгээр, ТСН-ийн бүхий л эд хөрөнгө, өр төлбөр, үүрэг хариуцлагыг Хавсралт 3-т заасны дагуу ХасБанкны Нэгтгэлийн дараах нэгдсэн тайлан балансд бүртгэнэ. Талууд Нэгтгэлийн дараах нэгдсэн тайлан балансаа холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж, батлуулна.

4.6 4.1 дэх заалтын ерөнхий байдлыг үл харгалзан, ТСН-ийн өмчилж, эзэмшиж буй бүх эдийн ба эдийн бус хөрөнгийн өмчлөх, эзэмших, ашиглах эрх болон аливаа гуравдагч этгээдэд хамааралтай эсхүл гуравдагч этгээдийн эсрэг гаргах ТСН-д хамааралтай бусад холбогдох эрх, үүрэг, нэхэмжлэл гаргах эрх, үүрэг хариуцлагыг ХасБанкинд тухайн нөхцөлөөр нь шилжүүлнэ.

4.7 Татвар ба зардлууд

Тал тус бүр энэхүү Гэрээ болон Нэгтгэлээс үүдэн гарах өөрсдийн зардал, хураамж, татварыг хариуцан төлөх ба Талуудын хооронд хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон Холбогдох хуульд заасны дагуу гарах бусад татвар, хураамж, төлбөр, зардал (үүнд холбогдох алданги, торгууль, аливаа бусад нэмэлт зардал, төлбөр хамаарна)-ыг тэнцүү хуваах буюу Тал тус бүр холбогдох зардлын 50%-ийг хариуцан төлнө.

Дээр дурдсаныг үл харгалзан, ТСН нь МХБ, СЗХ-оос Нэгтгэлтэй холбогдуулан зөвшөөрөл авах хүсэлт гаргах болон дээрх 2.3(d) заалтад заасны дагуу ХасБанкны



Хувьцааг ҮЦТХТ-д ТСН-ийн Хувьцаа эзэмшигч бүрийн нэр дээр үнэт цаасны хадгаламжид бүртгүүлэхтэй холбоотойгоор үүдэн гарах аливаа үйлчилгээний төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс эсхүл аливаа бусад ижил төстэй төлбөр, зардлыг хариуцан төлнө.

#### 4.8 Ажилтнууд

Энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар, ТСН нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Компанийн Нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч гэсэн ажилтнуудаас бүрдсэн бүрэлдэхүүнтэй байгаа тухай үүгээр мэдэгдэл, баталгаа гаргасан болно. 4.8 дахь заалтад шууд зааснаас бусад байдлаар, ТСН-тэй хөдөлмөрийн харилцаа, бие даасан гүйцэтгэгч, бусад албан тушаалд хамаарах ямар нэг хувь хүн байхгүй болно.

Энэхүү 4.8 дахь заалтад нэр дурдсан бүх хувь хүмүүс, тухайлбал Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Компанийн Нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч нар нь аль хэдийн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Компанийн Нарийн бичгийн дарга, Нягтлан бодогчийн албан тушаалд орсон болохыг ойлгож, баталгаажуулсан болно. Үүний үр дүнд, ТСН-ийг ХасБанкинд нэгтгэсэнтэй холбогдуулан эдгээр хувь хүмүүст ХасБанктай хөдөлмөрийн харилцааг шинээр үүсгэх, үргэлжлүүлэн үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй, тийнхүү хүлээлт үүсгэх шаардлагагүй болохыг тодорхой ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно.

ТСН нь өөрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Компанийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогчийн өмнө хүлээсэн тэдний холбогдох чиг үүргээс эсхүл хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгохтой холбогдуулан үүдэн гарах бүхий л үүрэг, хариуцлага, амлалтуудаа ТСН Хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө биелүүлж, хангасан байх ба ХасБанк тодорхой нөхцөлд бичгээр хүлээн авч буйгаа илэрхийлээгүй тохиолдолд эдгээр үүрэг, хариуцлага, амлалтыг ХасБанк хариуцахгүй.

Эргэлзээгүй байх үүднээс, 4.8 дахь заалт нь эдгээр хувь хүмүүс болон ХасБанкны хоорондын одоогийн хөдөлмөрийн ба бусад харилцаанд нөлөөлөхгүй, өөрчлөхгүй, өөрчлөлт оруулахгүй болно. Энэхүү Гэрээг байгуулах өдрийн байдлаар үйлчилж байгаа тэдний ХасБанкинд ажиллах нөхцөл, үйлчилгээ үзүүлэх нөхцөл, шаардлагууд нь хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд холбогдох хууль, журам, ХасБанкны бодлого, журмын дагуу өөрчлөлт оруулж болно.

#### 4.9 Дотоод дүрэм, журам

Нэгтгэлийн хаалтын өдрийн байдлаар, Хавсралт 4-т жагсаасан ТСН-ийн бүхий л дотоод дүрэм, журам нь ХасБанктай холбоотой аливаа асуудалд үйлчлэхээ болино. Хэрэв шаардлагатай гэж үзвэл, ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл Гүйцэтгэх захирал тус дүрэм, журмуудыг баталсан тогтоол, тушаал гаргаж болно.

#### 5. ЕСБХБ-ны Бодлогууд

Нэгтгэлийн хаалтын өдрийн байдлаар, ХасБанк нь ЕСБХБ-ны Ерөнхий нөхцөлийн гэрээнд тодорхойлсон ЕСБХБ-ны тодорхой бодлогуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

#### 6. ОУСК-ын Бодлогууд

Нэгтгэлийн хаалтын өдрийн байдлаар, ХасБанк нь ОУСК-ын Бодлогын гэрээнд тодорхойлсон ОУСК-ын тодорхой бодлогуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



7. Нэгтгэлийн ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ТАЙЛАГНАЛЫН ШААРДЛАГУУД

(a) Нэгтгэлийн хаалтын өдөр ба тус өдрөөс эхлэн ХасБанк нь:

- (i) ХасБанкны өөрийн хөрөнгийн арван тав (15%) хувиас дээш хэмжээний зээлийн эх үүсвэрийг нэг зээлдэгч эсхүл групп компаниудад санхүүжилттэй ба санхүүжилтгүй үүрэг даалгавраар олгохгүй, сунгахгүй. Энэхүү 7(a)(i) заалтын хувьд, "групп компаниуд" гэж групп доторх нэг хуулийн этгээд буюу этгээдийн саналын эрх бүхий хувьцааны 20% буюу түүнээс дээш хувийг нөгөө хуулийн этгээд буюу этгээд эзэмшдэг хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээд буюу этгээдийг хэлнэ. Иймд хэрэв ХасБанкны хоёр зээлдэгч нь: (i) нэг зээлдэгч нөгөө зээлдэгчийн саналын эрх бүхий хувьцааны 20% ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа; эсхүл (ii) нэг хуулийн этгээд буюу этгээд нь хоёр зээлдэгчийн саналын эрх бүхий хувьцааны 20%-аас дээш хувийг эзэмшдэг бол тэдгээрийг ижил групп компанийн нэг хэсэг гэж үзнэ. Дээр дурдсан хязгаарлалт нь ХасБанкнаас мөнгөний зах зээлийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад хамаарахгүй;
- (ii) ХасБанктай холбоотой мэдээллийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Мэдээлэл ил тод болгох бодлогын дагуу ХасБанкны Хувьцаа эзэмшигчдэд гаргаж өгөх;
- (iii) энэхүү Мэдээлэл ил тод болгох бодлогод аливаа өөрчлөлт оруулах тохиолдолд (Монгол Улсын холбогдох хууль тогтоомж эсхүл Монгол Улсын холбогдох журамд өөрөөр заагаагүй бол) ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (дөрөвний гурав)-ын саналаар батална.

(b) Энэхүү **Error! Reference source not found.** заалтын дагуу гаргах бүхий л тайланг Монгол хэл ба Англи хэл дээр гаргана.

8. БУСАД ЗААЛТ

8.1 Бүх тохиролцоо

Энэхүү Гэрээ нь энд заасан Нэгтгэлтэй холбоотой Талуудын хоорондын бүхий л тохиролцоог тусгасан болно.

8.2 Холбогдох хуультай зөрчилдөх

Энэхүү Гэрээний заалтууд нь тухайн цаг үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Холбогдох хуультай зөрчилдөх эсхүл үл нийцэх тохиолдолд Монгол Улсын Холбогдох хуулийн заалтууд, дүрэм журмуудыг баримтална.

8.3 Холбогдох хууль

Энэхүү Гэрээнд заагаагүй асуудлыг Холбогдох хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу шийдвэрлэнэ.

8.4 Зохицуулах хууль

Энэхүү Гэрээний хүчин төгөлдөр байдал, түүнийг тайлбарлах, хэрэгжүүлэх, дуусгавар болгох болон энэхүү Гэрээнээс үүсэх аливаа харилцааг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулж, түүний дагуу тайлбарлана.



**8.5 Харьяалал**

Энэхүү Гэрээнээс эсхүл энэхүү Гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаан эсхүл эрх зүйн харилцааг Монгол Улсын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

**8.6 Хүчин төгөлдөр байдал, Нэмэлт өөрчлөлт**

- (a) Энэхүү Гэрээ нь дараахь нөхцөлүүдийг хангаснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү Гэрээний нөхцөл хангагдсан өдөр эсхүл Нэгтгэлийн хаалтын өдөр буюу аль хожим тохиосон өдөр дуусгавар болно:
  - (i) ХасБанк ба ЕБСХБ хооронд ерөнхий нөхцөлийн гэрээ (цаашид "ЕБСХБ-ны Ерөнхий нөхцөлийн гэрээ" гэх)-г байгуулснаар;
  - (ii) ХасБанк ба ОУСК хооронд бодлогын гэрээ (цаашид "ОУСК-ийн Бодлогын гэрээ" гэх)-г байгуулснаар.
- (b) Нэгтгэлийн хаалтын өдрөөс өмнө, Талууд энэхүү Гэрээнд бичгээр аливаа нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд Зөвшөөрөл олгохтой холбогдуулан аливаа Төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлтэд нийцүүлэхийн тулд Талууд өөрчлөлт оруулах шаардлагатай болох зэрэг нөхцөл хамаарна. Энэхүү Гэрээнд өөрөөр заасныг үл харгалзан, Талууд энэхүү Гэрээнд ЕБСХБ, ОУСК-ийн эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй буюу үүнд 2.3, 5, 6, 8.6(a), 8.6(c) болон 8.7 дахь заалтуудад нэмэлт, өөрчлөлт буюу өөрчлөлт оруулах, эсхүл тэдгээрт заасан аливаа шаардлагуудаас ЕБСХБ эсвэл ОУСК-аас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр татгалзах зэрэг хамаарна.
- (c) Энэхүү Гэрээнд өөрөөр заасныг үл харгалзан, энэхүү 8 дугаар заалтын (a) хэсэгт заасны дагуу 1, 5, 6, 7, 8 дахь заалтууд нь энэхүү Гэрээ дуусгавар болсон ч хүчинтэй хэвээр байна.

**8.7 Гуравдагч этгээдийн эрх**

- (a) Энэхүү Гэрээ нь талуудын тус тусын эрх залгамжлагчдын хувьд заавал биелэгдэх шинжтэй бөгөөд хүчин төгөлдөр байна. Нөгөө талын зөвшөөрөлгүйгээр аль ч тал энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ шилжүүлж болохгүй.
- (b) Доорх (c) ба (d) хэсэгт заасныг харгалзан, энэхүү Гэрээний тал биш этгээд энэхүү Гэрээний аливаа нөхцөлийг хэрэгжүүлэх, ашиг тусыг нь эдлэх эрхгүй.
- (c) Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкний Байгуулсан тухай Гэрээ, олон улсын конвенц, аливаа холбогдох хуулийн дагуу ЕБСХБ-д олгогдсон аливаа эрх ямба, дархан эрх, чөлөөлөлтөд халдахгүйгээр ЕБСХБ нь энэхүү Гэрээний тал мэт 2.3, 5, 8.6(a) болон 8.6(c) дахь заалтуудын дагуу хүлээх Талуудын үүргийн ашиг тусыг эдэлж болно.
- (d) Олон Улсын Санхүүгийн Корпорацыг Үүсгэн Байгуулах Хэлэлцээр, олон улсын конвенц, аливаа холбогдох хуулийн дагуу ОУСК-д олгогдсон аливаа эрх ямба, дархан эрх, чөлөөлөлтөд халдахгүйгээр ОУСК нь энэхүү Гэрээний тал мэт 2.3, 5, 8.6(a) болон 8.6(c) дахь заалтуудын дагуу хүлээх Талуудын үүргийн ашиг тусыг эдэлж болно.



**8.8 Англи хэл**

Энэхүү Гэрээний дагуу эсвэл үүнтэй холбоотойгоор ХасБанкнаас үйлдэгдэх, өгөх, хүргүүлэх бүх баримт бичиг, захидал харилцааг Англи хэл дээр үйлдэх буюу хэрэв өөр хэл дээр байх бол Англи хэл дээрх орчуулгыг хавсаргана.



ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



**ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН** энэхүү Гэрээг Талууд Хүчин төгөлдөр болох өдөр байгуулсан болно.

**ХасБанк ХК-г төлөөлж, түүний нэрийн өмнөөс**

---

Нэр: Г.ЦЭВЭГЖАВ  
Албан тушаал: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

**Тэнгэр Санхүүгийн Нэгдлийг төлөөлж, түүний нэрийн өмнөөс**

---

Нэр: [Г.ЦЭВЭГЖАВ]  
Албан тушаал: [ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ]



**ХАВСРАЛТ 1- НЭМЭЛТ БАРИМТ БИЧИГ**

**ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХХК БА ХАСБАНК ХК-ИЙН ХООРОНД [\*\*\*]-НИЙ ӨДӨР  
БАЙГУУЛСАН НЭГТГЭХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ БАРИМТ БИЧИГ**

**Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК  
(цаашид “Компани” гэх)**

Хэнд: Магваны Болдоод  
[ХАЯГ]

2024 ОНЫ [ОГНОО]

Хүндэт танаа,

**Нэгтгэх гэрээний дагуу хувьцаа хөрвүүлэх тухай**

Бид Компани ба ХасБанк Нээлттэй ХК (цаашид “ХасБанк” гэх)-ийн хооронд 2024 оны [\*\*\*]-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээ (“Нэгтгэх гэрээ”)-ний дагуу бичиж байна.

Компанийн хувьцаа эзэмшигч, Магваны Болдоо нь Компанийн хувьцаа бүрийг ХасБанкны хувьцаанд хөрвүүлэх хувьцаа хөрвүүлэх харьцааг хамгийн ойрхон бүхэл тоо бүхий ХасБанкны Хувьцаа болгож бууруулах ба Нэгтгэх гэрээний 3.2-р зүйлд зааснаар бүхэл тоо болгож нэмэгдүүлэхгүйг зөвшөөрсөн гэдгээ үүгээр баталгаажуулж байгаа бөгөөд үүгээр Нэгтгэх гэрээнд заасны дагуу ХасБанкны бутархай хувьцааг бүхэл тоо болгож нэмэгдүүлэх аливаа эрх, шаардах эрх, нэхэмжлэл гаргах эрхээсээ татгалзаж байгаа болно.

Энэхүү баримт бичиг нь Нэгтгэх гэрээ хүчин төгөлдөр болсноор хүчинтэйд тооцогдоно.

Хүндэтгэсэн,

.....  
Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн нэрийн өмнөөс

Нэр:

Албан тушаал:

Магваны Болдоо нь 2024 оны [\*\*\*]-ны өдөр танилцаж, хүлээн зөвшөөрөв.

.....

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



**ХАВСРАЛТ 2 – ХАСБАНКИНД ШИЛЖҮҮЛЭХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ТСН-ИЙН ХӨРӨНГӨ, ЭД ХӨРӨНГӨ, ЭРХ, ҮҮРЭГ, ШААРДАХ ЭРХ, НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ, ӨР ТӨЛБӨР**

**2023 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР**

#	ТСН-ИЙН ХӨРӨНГӨ, ЭД ХӨРӨНГӨ, ЭРХ, ҮҮРЭГ, ШААРДАХ ЭРХ, НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ, ӨР ТӨЛБӨР	ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН ДҮН	ТАЙЛБАР
1.	Аливаа хөрөнгө	0.00	Одоогийн байдлаар байхгүй
2.	Аливаа эрх	0.00	Одоогийн байдлаар байхгүй
3.	Аливаа үүрэг	0.00	Одоогийн байдлаар байхгүй
4.	Аливаа өр төлбөр	0.00	Одоогийн байдлаар байхгүй

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай




**ХАВСРАЛТ 3 - ХАСБАНКНЫ НЭГТГЭЛТИЙН ДАРААХ  
НЭГДСЭН ТАЙЛАН БАЛАНС\***

Тасалбар болгох огноо: 2023 оны 12-р сарын 31

	ХасБанк ХК Нэгтгэхийн өмнө 12/31/2023 Мян.төг	ХасБанк ХК дараах 12/31/2023 Мян.төг	Өөрчлөлт 12/31/2023 Мян.төг
<b>ХӨРӨНГӨ</b>			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	358,359,279	358,359,279	-
Монголбанк дахь заавал байлгах нөөц	239,378,375	239,378,375	-
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд			
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	56,800,918	56,800,918	-
Үнэт цаас	110,309,146	110,309,146	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	93,116,520	93,116,520	-
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө			
Өмчийн үнэт цаас	5,052,206	5,052,206	-
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө			
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	393,769,064	393,769,064	-
Урвуу репо хэлцэл	99,740,669	99,740,669	-
Өрийн хэрэгслүүд	960,070,624	960,070,624	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,627,234,410	2,627,234,410	-
Бусад хөрөнгө	71,277,148	71,277,148	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	1,387,250	1,387,250	-
Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө	75,388,849	75,388,849	-
Биет бус хөрөнгө	18,667,114	18,667,114	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	8,870,069	8,870,069	-
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,119,421,641</b>	<b>5,119,421,641</b>	<b>-</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд			
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	14,332,115	14,332,115	-
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр			
Репо хэлцэл	149,611,113	149,611,113	-
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	36,937,419	36,937,419	-
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,876,117,299	2,876,117,299	-
Зээлээр авсан санхүүжилт	1,238,768,595	1,238,768,595	-
Хойшлогдсон нөхцөлт хандив	12,564,957	12,564,957	-
Түрээсийн өр төлбөр	7,675,609	7,675,609	-
Бусад өр төлбөр	131,592,516	131,592,516	-
Орлогын албан татварын өглөг	29,759,280	29,759,280	-
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,497,358,903</b>	<b>4,497,358,903</b>	<b>-</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Энгийн хувьцаа	105,270,000	105,270,000	-
Нэмж төлөгдсөн капитал	30,586,768	30,586,768	-
Нөөцүүд	86,418,906	86,418,906	-
Хуримтлагдсан ашиг	399,787,064	399,787,064	-
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>622,062,738</b>	<b>622,062,738</b>	<b>-</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>5,119,421,641</b>	<b>5,119,421,641</b>	<b>-</b>


\* Нэгтгэлийн гэрээг байгуулахдаа нэгтгэл хийх үеийн байдлаарх хамгийн сүүлийн сарын санхүүгийн тайланг хавсаргаж, нэгтгэлийг хэрэгжүүлэх тул энэхүү 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан нь өөрчлөгдөнө.



**ХАВСРАЛТ 4 – ТСН-ИЙН ДОТООД ДҮРЭМ, ЖУРАМ**


#	ТСН-ИЙН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭР	
1.	2021 оны 6-р сарын 30-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2021-22 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.
2.	2011 оны 11-р сарын 24-ний өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2011-13 тоот тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.
3.	2011 оны 11-р сарын 24-ний өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2011-15 тоот тогтоолоор баталж, сүүлийн байдлаар 2022 оны 9-р сарын 21-ний өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2022-25 тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй. 2023 оны 7-р сарын 7-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар журамтай хамт шинэчлэх шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийсэн.
4.	2018 оны 12-р сарын 5-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2018-24 тоот тогтоолоор баталсан Дотоод мэдээлэл зээмшигчийн арилжааны бодлого	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.
5.	2011 оны 11-р сарын 24-ний өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2011-14 тоот тогтоолоор баталж, 2021 оны 3-р сарын 30-ний өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2021-07 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.
6.	2014 оны 12-р сарын 10-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн 2014-26 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо ("ЗНДЦУХ")-ны дүрэм	ХасБанкны ЗНДЦУХ нь өөрийн журамтай. Батлах шаардлагагүй. 2023 оны 7-р сарын 7-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар журамтай хамт оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийсэн.
7.	Сүүлийн байдлаар 2019 оны 9-р сарын 19-ний өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2019-35 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ")-ны дүрэм	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.
8.	2019 оны 9-р сарын 18-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2019-41 тоот тогтоолоор баталсан Ажилтны зээлийн ерөнхий журам	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.
9.	2008 оны 12-р сарын 5-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2019-41 тоот тогтоолоор баталсан Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.
10.	2011 оны 5-р сарын 25-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2011-07 тоот тогтоолоор баталсан ТСН-ийн засаглалын кодекс	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



11	2012 оны 10-р сарын 29-ний өдрийн ТСН-ийн Гүйцэтгэх захирлын А-54-2012 тоот тушаалаар баталсан Мэдээллийн аюулгүй байдлын бодлого	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.
12	2015 оны 11-р сарын 23-ны өдрийн ТСН-ийн Гүйцэтгэх захирлын А-03/2015 тоот тушаалаар баталсан Шүгэл үлээх бодлого	2023 оны 7-р сарын 7-ны өдөр ХасБанкны ТУЗ-өөс энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хамт баталсан.
13	2019 оны 9-р сарын 18-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2019-39 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөр	ХасБанкны ТУЗ-өөс зөвшөөрсний дагуу энгийн хувьцаанд суурилсан урт хугацааны урамшууллын төлөвлөгөө нь энэхүү бодлогыг орлоно. Энэхүү Бодлого нь зөвхөн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөс өмнө ХасБанкны ажилтнуудад хуваарилагдсан Хувьцааны үнэд суурилсан урамшууллын нэгжид хамаарах бөгөөд эдгээр нэгжийн эрх олгох хугацаа дуусах хүртэл үргэлжилнэ.
14	2009 оны 11-р сарын 28-ны өдрийн ТСН-ийн ТУЗ-ийн ГР-2009-09 тоот тогтоолоор баталсан Ногдол ашгийн бодлого болон Нөөц хуваарилалтын бодлого	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.
15	2011 оны 7-р сарын 23-ны өдрийн ТСН-ийн Гүйцэтгэх захирлын А-30/2011 тоот тушаалаар баталсан Нийгэм, байгаль орчны бодлого	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.
16	2011 оны 8-р сарын 16-ны өдрийн ТСН-ийн Гүйцэтгэх захирлын А-35/2011 тоот тушаалаар баталсан Аюулгүй байдлын бодлого	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.
17	2013 оны 6-р сарын 24-ний өдрийн ТСН-ийн Гүйцэтгэх захирлын А-28 тоот тушаалаар баталсан Улс төрийн нам, эвслээс хараат бус, төвийг сахих зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК, түүний охин болон хараат компанийн нийт ажилтны дагаж мөрдөх хязгаарлалт	ХасБанк өөрийн журамтай. Батлах шаардлагагүй.





### НЭГТГЭХ ХЭЛБЭРЭЭР ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ: НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

1. **Ерөнхий Зүйл**
  - 1.1 Энэхүү баримт бичигт Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК ба ХасБанк ХК (цаашид хамтад нь "Талууд" гэх)-ийн хооронд байгуулсан Нэгтгэх Гэрээ (цаашид "Нэгтгэх гэрээ" гэх)-ний дагуу Талуудыг нэгтгэх (цаашид "Нэгтгэл" гэх) нөхцөл, шаардлага (цаашид "Нөхцөл" гэх)-ыг тусгасан бөгөөд энэхүү баримт бичгийг зөвхөн Нэгтгэл хийх ажиллагааны шаардлагатай баримт бичгүүдийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид албан ёсоор хүргүүлэх зорилгоор бэлтгэсэн болно.
  - 1.2 Энд заасан Нөхцөлийг Нэгтгэх Гэрээнд нийцүүлэн, нэмэлтээр боловсруулсан болно. Энэхүү Нөхцөл ба Нэгтгэх Гэрээний хооронд ямар нэгэн зөрүү, зөрчилдөөн, хоёрдмол утга үүссэн тохиолдолд Нэгтгэх Гэрээний заалтыг баримтална. Энэхүү Нөхцөлийг Нэгтгэх Гэрээний дагуу ойлгох бөгөөд энэхүү Нөхцөлийн аль нь ч Нэгтгэх Гэрээний аливаа заалтыг хүчингүй болгох, сулруулах зорилгогүй болно.
  - 1.3 Энэхүү Нөхцөлийн дагуу Нэгтгэх Гэрээнээс тусдаа ямар нэг үүрэг, өр төлбөр, хариуцлага үүсэхгүй бөгөөд үүссэн гэж үзэхгүй. Энэхүү баримт бичгийн хүчин төгөлдөр байдал нь Нэгтгэх Гэрээний хүчин төгөлдөр байдалтай шууд хамааралтай байна.
2. **НЭР ТОМЬЁО БА ТАЙЛБАР**
  - 2.1 **Нэр томьёо**

Энэхүү Нөхцөлд том үсгээр бичигдсэн нэр томьёо нь Нэгтгэх Гэрээнд заасан утгыг илэрхийлнэ.
  - 2.2 **Тайлбар**

Нэгтгэх Гэрээний нөхцөлийг ойлгох, тайлбарлах зорилгоор тусгагдсан заалтууд нь энэхүү Нөхцөлд мөн адил хамаарна.
3. **Нэгтгэл**
  - 3.1 Нэгтгэлийг Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт нийцүүлэн Нэгтгэх Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлнэ.
  - 3.2 Нэгтгэлийг хэрэгжүүлэх зорилгоор, ТСН-ийн эзэмшиж байгаа ХасБанкны Хувьцааг Нэгтгэх Гэрээний дагуу хөрвүүлнэ.
  - 3.3 Нэгтгэх Гэрээнд заасны дагуу, зөвхөн дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд, ХасБанк ба ТСН тус бүр нь Нэгтгэлийг ХЭБГ-т бүртгүүлэх, ТСН-ийг татвар төлөгчийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлээс хасуулахаар хүсэлт гаргаж болно:
    - (a) ТСН ба ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гаргаж энэхүү Нөхцөлд заасны дагуу Нэгтгэл хийхийг зөвшөөрч, баталсан байх;
    - (b) ХасБанк нь Холбогдох хуулийн дагуу Нэгтгэлтэй холбогдуулан Монгол Банкнаас зохих ёсоор зөвшөөрөл авсан байх;

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



- (с) ХасБанк нь Нэгтгэл болон үнэт цаасны бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах тухайд СЗХ, МХБ-ээс зохих ёсоор зөвшөөрөл авсан байх;
  - (d) СЗХ-ны зохих зөвшөөрлийг авч, ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид ХасБанкны Хувьцааг доорх 4-р зүйлд заасан тоогоор эзэмших эрхийг ҮЦТХТ-д нэр тус бүрээр бүртгүүлсэн байх;
- 3.4 (i) Нэгтгэлийг баталсан ТСН болон ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурал тус тус хуралдсан өдөр; эсхүл (ii) Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь хэсэгт заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй болох тухай бичгээр хүргүүлсэн мэдэгдлийг тус тус хүлээн авсан өдрүүдийн аль сүүлчээс нь эхлэн ажлын гучин (30) өдрийн дотор Талууд Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1 дэх заалт ба 54 дүгээр зүйлийн дагуу ТСН болон ХасБанкны өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгүүлнэ.
- 3.5 Хэрэв өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй аливаа хувьцаа эзэмшигч дээрх 3.4 дэх заалтад заасны дагуу ажлын гучин (30) өдрийн дотор эрхээ хэрэгжүүлэх шийдвэрээ бүртгүүлээгүй бол тухайн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн дагуу хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзнэ. ТСН ба ХасБанк нь хувьцаа эзэмшигчдэд өгөх холбогдох мэдэгдэл, баримт бичгүүдэд энэ асуудалтай холбоотой татгалзлын тухай тодорхой мэдээллийг зааж өгнө.
- 3.6 ТСН ба ХасБанкны Хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх нь зөвхөн СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан шаардлагын дагуу СЗХ-оос Нэгтгэлийг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой болно.
- 3.7 Энд өөрөөр заасныг үл харгалзан, Нэгтгэх зөвшөөрөл олгосон өдөр ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх нь ХасБанкны Хувьцааг ХасБанк эргүүлэн худалдаж авахыг Монгол Банкнаас зөвшөөрснөөр хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой болно.
- 3.8 Талууд компанийн хувьд шаардлагатай бүхий л зөвшөөрлийг бэлтгэх, олгох, батлах, мөн Зөвшөөрөл авахад шаардлагатай бүхий л хүсэлтийг дагалдах баримт бичгийн хамт Монгол Банк, СЗХ, МХБ, ХЭБГ, харьяа татварын алба зэрэг байгууллагуудаар хязгаарлагдахгүйгээр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудад бэлтгэж хүргүүлэх үүрэгтэй бөгөөд Нэгтгэлийг хэрэгжүүлж, дуусгахад шаардлагатай аливаа үйлдлийг хийх үүрэгтэй.
- 3.9 Талууд дээрх 3.3 дахь заалтын нөхцөлүүдийг хангахад шаардлагатай бүхий л үйлдлийг хийхэд бүрэн дүүрэн хамтран ажиллах, Нэгтгэлийг хэрэгжүүлж, дуусгахад шаардлагатай эсхүл шаардсан аливаа бусад гэрээ байгуулах, баримт бичгийг батлах үүрэгтэй.
- 3.10 Талууд Холбогдох хуулийн дагуу Нэгтгэлийн тухай өөрсдийн бүх зээлдүүлэгч болон үйлчлүүлэгчдэд зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай



4. Хувьцааны үнэ тогтоох, хөрвүүлэх журам

- 4.1 Энэхүү Нөхцөл хүчин төгөлдөр болох өдрийн байдлаар ТСН нь ХасБанкны нийт зарласан болон гаргасан хувьцааны 94.99 хувь буюу нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг ХасБанкны Хувьцааг эзэмшиж байгаа болно. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид нь ТСН-ийн зарласан болон гаргасан хувьцааны 100 хувийг бүрдүүлж буй нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй 16,270,503 (арван зургаан сая хоёр зуун далан мянга таван зуун гурав) ширхэг ТСН-ийн Хувьцааг эзэмшиж байгаа болно.
- 4.2 ТСН-ийн Хувьцаа бүрийг ХасБанкны Хувьцаанд хөрвүүлэх харьцааг тогтоохдоо ТСН-ийн эзэмшиж байгаа ХасБанкны Хувьцаа (1,000,000,000 ширхэг хувьцаа)-ны тоог ТСН-ийн нийт Хувьцаа (16,270,503)-ны тоонд хуваана. Үүний үр дүнд 61.46091488 ширхэг ХасБанкны Хувьцаа нь ТСН-ийн нэгж Хувьцаа бүрд ногдохоор хөрвүүлэх харьцааг ТСН-ийн Хувьцаа эзэмшигч бүрд хуваарилагдах ХасБанкны нийт хувьцааны тоог тодорхойлоход ашиглана. ХасБанкны Хувьцааг эцсийн байдлаар хөрвүүлэхэд бутархай тоо гарах тохиолдолд тухайн бутархай тоо нь 0.5-аас бага бол бүхэл тоо болгож бууруулах, 0.5-аас их бол бүхэл тоо болгож нэмэгдүүлнэ.
- 4.3 Дээр дурдсаныг үндэслэн, ТСН-ийн Хувьцааг ХасБанкны Хувьцаанд хөрвүүлсэн үр дүн, ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдэд олгох хуваарилалт нь дор дурдсаны дагуу байна. Үүнд:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	ТСН-ийн Хувьцаа	Хөрвүүлсний дараах ХасБанкны Хувьцаа
1	МАК Инвест КэйЭфТи	3,316,985.00	203,864,933.00
2	Олон Улсын Санхүүгийн Корпорац	2,847,794.00	175,028,025.00
3	ОРИКС Корпорац	2,788,218.00	171,366,429.00
4	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк	2,140,273.00	131,543,137.00
5	Канадын Үндэсний Банк	1,744,107.00	107,194,412.00
6	Ронк Партнерз КэйЭфТи	1,683,342.00	103,459,739.00
7	Монголия Файненшл Сервизис Пти. Лтд	1,098,764.00	67,531,041.00
8	Триодос Фэйр Шэйр Фанд	618,680.00	38,024,639.00
9	Магван овогтой Болдоо*	16,968.00	1,042,868.00
10	Чулуун овогтой Ганболд	15,372.00	944,777.00
	<b>НИЙТ</b>	<b>16,270,503.00</b>	<b>1,000,000,000.00</b>

[\* Нэгтгэх Гэрээний дагуу энэхүү хувьцаа эзэмшигч нь ХасБанкны Хувьцааг хамгийн ойрхноор нь бүхэл тоо болгож бууруулахыг сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрсөн бөгөөд 4.2-р зүйлийн дагуу өөрийн бутархай хувьцаагаа бүхэл болгож тооцохтой холбоотойгоор маргах, шаардах эрхээ хэрэгжүүлэх, нэхэмжлэл гаргах аливаа эрхээсээ татгалзсан болно.]

- 4.4 Нэгтгэх Гэрээний дагуу хөрвүүлж, нэгтгэж дуусмагц ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй ХасБанкны Хувьцааг хөрөнгийн бирж дээр бүртгүүлж, чөлөөтэй арилжих боломжтой болно.



5. **Бусад Эрх, Үүргээ шилжүүлэх**

ХасБанкинд шилжүүлэх, хүлээлгэн өгөх ТСН-ийн хөрөнгө, эд хөрөнгө, эрх, үүрэг, шаардах эрх, нэхэмжлэл гаргах эрх, өр төлбөрийг Нэгтгэх Гэрээнд тусгасан болно.

6. **Бусад Зүйл**

Нэгтгэх Гэрээний бүх заалтуудыг энэхүү баримт бичигт шууд тусгагдсан эсэхээс үл хамааран энэхүү баримт бичгийн салшгүй хэсэг гэж үзнэ. Энэхүү Нөхцөлийг уншиж, тайлбарлахдаа Нэгтгэх Гэрээний бүх заалтыг хамааруулах бөгөөд тэдгээрийг энэхүү баримт бичиг дээр бүрэн тусгагдсан мэт хүчин төгөлдөр гэж үзнэ.



## **Хурлаар шийдвэрлэх есдүгээр асуудал:**

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

## Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

ХасБанк ХК (“Банк”) нээлттэй хувьцаат компани болсноос хойш Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг анх удаа зохион байгуулах гэж байна. Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэгт зааснаар хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар, бүрэн бүрэлдэхүүнээр нь сонгоно.

Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх 2 (хоёр) жилийн хугацаатай. Иймд 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон ТУЗ нь бүрэн эрхээ 2026 оны хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хэрэгжүүлнэ.

Банкны гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журмын 5.1 дэх хэсэгт заасны дагуу Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”) 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаараа хэлэлцээд зөвлөмж гаргаж, Банкны ТУЗ-ийн 12 гишүүний орон тоонд нэр дэвшсэн нийт 14 нэр дэвшигчдийг Банкны хувьцаа эзэмшигчдэд санал болгож, Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авахаар хүргүүлсэн.

МонголБанк эдгээр нэр дэвшигчдээс дор дурдсан 13 хүнийг нэр дэвшүүлэхэд татгалзах зүйлгүйгээ мэдэгдэж холбогдох хариуг ирүүлсэн болно.

### Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад гишүүнд нэр дэвшигчид

#	Нэр	Нэр дэвшиж буй албан тушаал	ТУЗ-д ажилласан жил
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн гишүүн	7 жил
2	Албертус Браггинк	ТУЗ-ийн гишүүн	3 жил
3	Анджей Витак	ТУЗ-ийн гишүүн	5 жил
4	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	15 жил
5	Сюзанна Херринг Карр	ТУЗ-ийн гишүүн	2 жил
6	Нямтайширын Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	11 жил
7	Гүмэнжавын Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	4 жил
8	Доминик Жак	ТУЗ-ийн гишүүн	Шинэ нэр дэвшигч



### Санжай Гүпта

Боловсрол

- Сэинт Стивинг коллежийг Физикийн шинжлэх ухааны бакалавр;
- Дели Их Сургуулийн Менежментийн факультетыг Бизнесийн удирдлагын магистр.

### Ажлын туршлага

1981-2001

БНЭУ, Англи болон ХонгКонг дахь Банк оф Америка банкинд Байгууллагын банк хариуцсан захирал, Энэтхэг дэх Файнэншл Инститюшнс Групп хариуцсан захирал, Европ, Ойрх Дорнод, Африкийн (ЕОДА) Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, ЕОДА-ийн Стракчард Кредит Группийн гүйцэтгэх захирал, Ази дахь Инвестмент Банкинг Группийн гүйцэтгэх захирал;

2001-2006

Кредит Агриколь Группийн Кредит Лионассд Ази Номхон далайн бүсийн Байгууллагын Зээл хариуцсан захирал;



**Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай**

2007-2009	Кредит Агриколь Группэд Ази дахь зээлийн дахин санхүүжилт хариуцсан захирал;
2009-2015	Глобал Энержи Группийн Ази хариуцсан захирал;
2020- өнөөг хүртэл	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн/дарга.



**Албертус Браггинк**

Боловсрол

- Нидерландын Твенте их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр болон докторын зэрэгтэй.

**Ажлын туршлага**

1986-2016	Нидерландын хамгийн том санхүүгийн байгууллага болох Рабо банкинд Санхүү эрсдэл хариуцсан захирал, Группын Санхүү хяналт шалгалт хариуцсан захирал болон Санхүү хяналт шалгалтын захирал;
2016-өнөөг хүртэл	Орикс Корпорацийн ТУЗ-ийн зөвлөхөөр ажиллахаас гадна Нидерландын болон бусад улс орны томоохон байгууллага, компаниудад ТУЗ-ийн гишүүн;
2020- өнөөг хүртэл	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн.



**Анджей Витак**

Боловсрол

- Польш улсын Силезиа их сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй.

**Ажлын туршлага**

1985-1987	Фоско (Fosco) компанид Санхүүгийн ахлах мэргэжилтэн;
1987-1990	Коррект (Corect) компанид бие даасан зөвлөх;
1990 – 1991	Гливице Банкинд Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн;
1992-2007	Польш улс дахь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Санхүүгийн зөвлөх, удирдах албан тушаалууд мөн Украин, Узбекистан зэрэг улс дахь ЕСБХБ-ийн суурийн төлөөлөгч, орлогч;
2007-өнөөг хүртэл	Чанаргүй актив, эрсдэлтэй зээлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж буй ЕСБХБ-ийн төслүүдэд бие даасан зөвлөх;
2019- өнөөг хүртэл	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн.



## Майкл Мадден

Боловсрол

- Лимерикийн Менежмент судлалын коллеж /Ирланд улс/-Аж үйлдвэрлэлийн инженер

### Ажлын туршлага

1990-2003

Американ Экспресс санхүүгийн байгууллагын Ирланд дахь салбарт хэд хэдэн албан тушаал хашиж, ОХУ-д карт нутагшуулах ажлыг гардан гүйцэтгэж, хамгийн сүүлд Их Британид дэд ерөнхийлөгч, Европ, Ойрх Дорнод, Африкийн франчайз хариуцсан захирлын албан тушаал хашиж байсан;

2007-өнөөг хүртэл

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг Ронок компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх партнер;

2009- өнөөг хүртэл

ХасБанкны ТУЗ-ийн гишүүн.



## Сюзанна Херринг Карр

Боловсрол

- Дьюкийн их сургууль, Эдийн засгийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

### Ажлын туршлага

1987 – 1993

Фёрст Фиделити Банк Корпорейшн/СМС Компани Филадельфия-Хөрөнгө оруулалтын банкир;

1994 – 1995

Солидарити Үйлдвэрчний Эвлэл/Энх тайвны Корпус Варшав, Польш Улс-Бизнесийн Зөвлөх;

1996 – 2019

Дэлхийн Банкны Группийн Олон Улсын Санхүүгийн Корпораци (Вашингтон, Колумбия Дүүрэг)-д Хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн, Ахлах Зөвлөх, Хөрөнгө оруулалтыг хариуцсан захирал, Бизнесийн төлөвлөлт, удирдлагын газрын захирал, Зээлийн бодлого, үнийн газрын захирал, Дэд Захирал;

2020-өнөөг хүртэл

ПроКредит Банк, Белград, Серб Улс, ТУЗ-ийн гишүүн;

2021-өнөөг хүртэл

Дэлхийн Банкны Хараат бус үнэлгээний группийн Зөвлөх (Вашингтон, Колумбия Дүүрэг);

2022- өнөөг хүртэл

ХасБанкны ТУЗ-ийн гишүүн.



## Нямтайширын Цэлмүүн

Боловсрол

- АНУ-ын Индиана мужийн Валпараисо Их Сургуулийг Бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн бөгөөд санхүүгийн инженерингийн чиглэлээр Стэнфордын Их Сургуулийн Хонгконг гэрчилгээт сургалт, Харвардын Бизнесийн сургуулийн хөтөлбөрүүдэд тус тус суралцсан.

### Ажлын туршлага

2012-2016

Монголын Алт (МАК) ХХК-ийн Худалдаа, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Бодлогын зөвлөлийн гишүүн;

2016-өнөөг хүртэл

Монголын Алт (МАК) ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Бодлогын зөвлөлийн гишүүн;

2012- өнөөг хүртэл

ХасБанкны ТУЗ-ийн гишүүн.



## Гүмэнжавын Цэвэгжав

Боловсрол

- АНУ-ын “Колорадогийн Их Сургууль”- Олон улсын бизнес, мэдээллийн системийн чиглэлээр бизнесийн удирдлагын Бакалавр;
- АНУ-ын “Рэжис Их Сургууль”-Санхүү нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр Бизнесийн удирдлагын Магистр.

### Ажлын туршлага

2004-2008

Вагнер экьюпмент /АНУ, Денвер хот/- Санхүүгийн шинжээч;

2008-2011

Ресторейшн Хардвер /АНУ, Сан Франциско/-Хөрөнгө зохицуулалтын менежер;

2011-2013

ТэнГэр Санхүүгийн нэгдэл ХХК, ХасБанк-Санхүү харицсан захирал;

2013-2019

ХасЛизинг ХХК-Гүйцэтгэх захирал;

2014-2017

ТэнГэр даатгал-ТУЗ-ийн гишүүн;

2015-2019

ХасБанк-Иргэдийн банк хариуцсан захирал, Ерөнхий захирал;

2019-өнөөг хүртэл

ХасБанк-Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн гишүүн.



## Доминик Жак

Боловсрол

- НЕС Монреаль их сургууль /Монреаль, Канад улс/-Бизнес удирдлагын бакалавр (БАА);
- НЕС Монреаль их сургууль /Монреаль, Канад улс/-Мэргэшсэн нягтлан бодогч.

### Ажлын туршлага

2001-2004	ПрайсВотерХаусКүүперс /Канад улс/- Шинжээч;
2004-2006	ПрайсВотерХаусКүүперс /Англи улс/-Менежер;
2006-2009	ПрайсВотерХаусКүүперс /Франц улс/-Ахлах менежер;
2010-2014	Канадын үндэсний банк- Ахлах менежер;
2014-өнөөг хүртэл	Канадын үндэсний банк- Олон улсын асуудал хариуцсан Тэргүүн дэд ерөнхийлөгч.

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

## Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчид

#	Нэр	Нэр дэвшиж буй албан тушаал	ТУЗ-д ажилласан жил
1	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	5 жил
2	Баянсаны Уламбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	9 жил
3	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	1 жил
4	Лоуренс Цонг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Шинэ нэр дэвшигч
5	Стюард Доналд Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Шинэ нэр дэвшигч



### Нираж Вэдва

Боловсрол

- Дели их сургуулийн Хинди Коллеж-Бакалавр;
- Индира Гандигийн нэрэмжит их сургууль-Худалдаа маркетингийн чиглэлээр Магистр.

### Ажлын туршлага

1987-1994	Нэтворк Лимитед компани- Худалдааны менежер;
1994-1997	ТиЭнТи Экспресс БиВи /TNT Express BV/- Хойд Энэтхэл, Балба бүсийн худалдааны менежер;
1997-1999	Модикорп Лимитед /Графтек Лимитед/- Дотоод худалдааны менежер;
1999-2011	Нуклеус Софтвэр (зээлийн программ хангамж чиглэлээр тэргүүлэгч улс дамнасан компани) - Үйл ажиллагаа хариуцсан захирал;
2011-2013	Швейцар Улсын Темонос (банкны программ хангамж чиглэлээр дэлхийд тэргүүлэгч компани) - Олон улсын иргэдийн банкны болон Ази, Номхон Далайн бүсийн захирал, Удирдлагын Зөвлөлийн гишүүн;
2013-2019	Энэтхэг Улсын Тек Махиндра (Энэтхэг Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, технологийн чиглэлээр дэлхийн Топ 20-д багтдаг компани)- Банк, төлбөр тооцоо, төлбөрийн картыг олон улсын хэмжээнд хариуцсан захирал;
2019-өнөөг хүртэл	Акселерик Эф Зи компани /Арабын Нэгдсэн Эмират улс/- Гүйцэтгэх захирал;
2018-өнөөг хүртэл	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн.



## Баянсаны Уламбаяр

Боловсрол

- Токиогийн Технологийн Их Сургуулийг электроникийн инженерийн Бакалавр, Магистр;
- АНУ-ын Чикагогийн их сургууль бизнесийн удирдлагын Магистр.

### Ажлын туршлага

2001-2005	Сони Корпораци /Япон улс/-Хөгжүүлэлтийн инженер/Төслийн дэд ахлагч;
2007-2009	Лиман Бродерс/Номура Секьюритис /Япон улс/- Мэргэжилтэн;
2009-2011	Монет ХХК-Зөвлөх/ТУЗ-ийн дарга;
2009-2011	Алтай Холдинг ХХК-Гүйцэтгэх захирал;
2011 он	Композит Капитал /хөрөнгө оруулалтын сан/- ХХК-Захирал;
2010-2012	Скайтел ХХК-ТУЗ-ийн гишүүн;
2013 өнөөг хүртэл	Говь Бизнес Финанс ХХК;
2014-2016	Дрейпер Капитал /хөрөнгө оруулалтын сан/-Ахлах зөвлөх;
2015-өнөөг хүртэл	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн.



## Эми Чой

Боловсрол

- Политехникийн их сургууль, /Хонгконг/-Дээд боловсролын диплом, Мэдээллийн систем анализ болон дизайн;
- Лондонгийн их сургууль, /Их Британи/- Шинжлэх ухааны Магистр, Бизнесийн систем анализ болон дизайн.

### Ажлын туршлага

1978-1979	Армитэйж Консалтинг- Программист;
1980-1980	АйСиЭйч- Системийн инженер;
1982-1983	АйБиЭм Банк- Системийн инженер/Ахлах инженер/Санхүүгийн үйлчилгээний систем хариуцсан менежер;
1994-2010	Ситибанк /Хонгконг/- Систем хөгжүүлэлтийн менежер, Салбарын менежер, Цахим борлуулалтын харилцагч татах хэлтсийн удирдагч, Олон улсын иргэдийн банкны газрын удирдагч, Дүүрэг хариуцсан менежер, Цахим банкны Газрын захирал, Борлуулалт & нийлүүлэлт хариуцсан захирал зэрэг албан тушаалуудад ажиллаж байсан.
2010-2013	Хятадын Гуангфа Банк-Иргэдийн банкны газрын захирал;
2013-2017	Пинг Ань Банк- Иргэдийн банкны газрын захирал;
2017-2020	Зүүн Азийн Банк- Дэд захирал;
2023-өнөөг хүртэл	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн.



Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай



### Лоуренс Цонг

Боловсрол

- Хонг Конгийн их сургууль- Нийгмийн ухааны бакалавр

#### Ажлын туршлага

1984-1998	Американ Экспресс- Зүүн Азийн Харилцаа холбоо, удирдлагын газрын Захирал;
1998-2001	ПиСиСи Дабл Ю /Хонгконг/- Маркетинг, бизнесийн удирдлага хариуцсан захирал;
2001-2006	Юнайтед Оверсийс Банк, /Хонгконг/-Тэргүүн дэд ерөнхийлөгч, Зээлийн картын төвийн дарга;
2007-2019	Транс-Юнион Ази /Хонгконг/- Бүс нутгийн ерөнхийлөгч;
2021-өнөөг хүртэл	Акюраси-Ахлах зөвлөх.



### Стюарт Доналд Холл

Боловсрол

- Шинэ Өмнөд Вэйлсийн их сургууль- Худалдааны чиглэлээр Бакалавр;
- Мэргэшлийн нягтлан бодогчдын институт /Австрали улс/- Мэргэжил дээшлүүлэх сургалт

#### Ажлын туршлага

1983-1985	Туш Росс анд Ко /Сиднэй, Австрали/- Мэргэшсэн нягтлан бодогч;
1985-1986	Фокс ассошиэт /Лондон, Англи/-Мэргэшсэн нягтлан бодогч;
1986-1994	Американ Экспресс Банк / Нью-Йорк, Лондон/- Аудитын менежер, Захиргаа хариуцсан захирал болон Хөрөнгө зохицуулалт, маркетингийн газрын захирал зэрэг удирдах албан тушаалуудад ажиллаж байсан;
1994-2013	Стандарт Чартеред Банк /Индонез, Вьетнам болон Өмнөд Солонгос, Лондон/- Санхүү хариуцсан захирал, Хөрөнгө зохицуулалт маркетингийн хэлтсийн захирал, Дэлхийн зах зээлийн хэлтсийн захирал, Азийн Худалдааны Банкны ТУЗ-ийн гишүүн, Филиппин дэх Стандарт Чартеред Банкны Гүйцэтгэх захирал зэрэг удирдах албан тушаалуудад ажиллаж байсан;
2018 – 2021	Индонез дахь КьюЭнБи (QNB) банк- Зөвлөх болон Гүйцэтгэх захирал;
2022-өнөөг хүртэл	Пиуур Фүүд Аллианс- Захирал.



## **Хурлаар шийдвэрлэх аравдугаар асуудал:**

ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай

## ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ЦАЛИН УРАМШУУЛЛЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

ТУЗ-ийн гишүүдэд хувьцаа эзэмшигчдийн SR-2022-04 дүгээр тогтоолын дагуу жилд 45,0 мянган ам.доллартай тэнцэх хэмжээний хөлсийг төгрөгөөр тогтоон олгож ирсэн. Мөн түүнчлэн нэг болон түүнээс дээш тооны хороод даргалж буй бол 5,0 мянган ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн нэмэгдэл олгож байна.

Тус Банктай харьцуулах боломжтой компаниудын ТУЗ-ийн гишүүдэд санал болгож буй цалин урамшууллын багцын талаар нарийвчилсан дүн шинжилгээг хөндлөнгийн зөвлөгөө өгөх байгууллагаар хийлгэсний үндсэн дээр ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцээд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоохыг санал болгосон.

Саналд ТУЗ-ийн гишүүдийн хөлсийг дараах байдлаар өөрчлөхөөр тусгасан:

### Жилд олгох хөлс:

<b>45,000</b> ам.доллартай тэнцэх төгрөг	+	<b>5,000</b> ам.доллартай тэнцэх төгрөг	=	<b>50,000</b> ам.доллартай тэнцэх төгрөг
(SR-2022-04 дүгээр тогтоолын дагуу олгож буй хөлс)		(Нэмэгдүүлэхээр санал болгож буй дүн)		(Жилд олгох нийт хөлсний хэмжээ)

### Жилд олгох нэмэгдэл:

<b>5,000</b> ам.доллартай тэнцэх төгрөг	=	<b>5,000</b> ам.доллартай тэнцэх төгрөг
(SR-2022-04 дүгээр тогтоолын дагуу олгож буй Хороо даргалсны нэмэгдэл)		Хэвээр тогтоох

Уг саналыг ТУЗ хэлэлцээд R-2024-10 дугаар тогтоолоороо дэмжин, хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулж буй болно.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-10

Улаанбаатар хот

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоох зөвлөмж хүргүүлэх тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.4 дэх хэсэг болон 8.6 (v) дахь заалт, мөн Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

### ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлж, амжилтыг хангахын тулд ТУЗ-ийн гишүүдийг татах, тогтоон барих, урамшуулах зайлшгүй шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч;
2. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн SR-2022-04 дүгээр тогтоолоор тогтоон баталсан ТУЗ-ийн гишүүний хөлсийн одоогийн бүтэц нь олон улсын зах зээлийн өнөөгийн жишиг, гишүүдийн өсөн нэмэгдэж буй үүрэг хариуцлага, мөн Банкны стратегийн зорилтод нийцэхээ больсныг ухамсарлан;
3. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”) нь Банктай харьцуулах боломжтой компаниудын ТУЗ-ийн гишүүндээ санал болгож буй цалин урамшууллын багцын талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийлгэсний үндсэнд 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн хурлаараа хэлэлцээд, ТУЗ-ийн гишүүний хөлсийн хэмжээг шинэчлэн тогтоохыг санал болгосныг; мөн
4. ТУЗ нь ЗНДЦУХ-ноос санал болгосны дагуу ТУЗ-ийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоолгохоор Банкны хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

### ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн Даргаас бусад гүйцэтгэх удирдлагын бус ТУЗ-ийн гишүүний хөлсийг дараах байдлаар тогтоохыг хувьцаа эзэмшигчдэд санал болгосугай:
  - 1.1. Жилд олгох нийт хөлсийг 50,000 (тавин мянган) ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоох буюу өмнө тогтоосон 45,000 ам.долларыг 5,000 ам.доллараар нэмэгдүүлэн тогтоосугай. Хөлсийг улирал тутам тооцож олгосугай. Энэхүү өөрчлөлтийг 2024 оны санхүүгийн жилээс эхлэн мөрдсүгэй.
  - 1.2. ТУЗ-ийн дэргэдэх нэг болон түүнээс дээш хороодын даргаар ажиллаж буй гишүүн бүрд жилд олгох нийт 5000 (таван мянга) ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн нэмэгдлийг хэвээр тогтоож, 2024 оны санхүүгийн жилд үргэлжлүүлэн мөрдсүгэй.

ХасБанкны төв байр,  
Ерөнхий сайд Амарын гудамж,  
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,  
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888  
Утас: 7577-1888  
Веб: www.xacbank.mn  
И-мэйл: info@xacbank.mn

2. Банкны хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, ТУЗ-ийн гишүүний хөлсийг 2024 оны санхүүгийн жилээс эхлэн шинэчлэн тогтоож, ийнхүү тогтоосонтой холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн SR-2022-04 дүгээр тогтоолын 1 болон 2 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЛГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

# Хурлаар шийдвэрлэх арван нэгдүгээр асуудал:

ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай



## ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

ХасБанкны дүрмийн 8.6 (v) дахь заалтад зааснаар ТУЗ-ийн төсөв тогтоох нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэрлэх асуудал болно. Иймд хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр ХасБанкны ТУЗ-өөс 2024 оны төсвийг 6,773,500,000 төгрөгийн дүнтэйгээр оруулж байна.

ТУЗ-ийн төсөв 2023 онд 5 тэрбум 922 сая төгрөгөөр батлагдаж байсан бөгөөд бодит гүйцэтгэл 5 тэрбум 938 сая төгрөг байсан.

ТУЗ-ийн төсөв нь (i) хөлс, нэмэгдэл, урамшуулал (үүнд ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, урамшуулал багтах ба гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүнээр ажилласныхаа төлөө аливаа, хөлс, нэмэгдэл, урамшуулал авдаггүй), (ii) Бусад зардал (татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зорчих болон буудаллах зардал, хурал зохион байгуулах зардал, ТУЗ-д үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээний төлбөр зэрэг)-аас бүрдэнэ.

	2023 оны төсөв	2023 оны гүйцэтгэл	2024 оны төсөв
(Сая төгрөгөөр)	5.922.2	5,938.4	6,773.5

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ



2024 оны 03 сарын 07 өдөр

№ R-2024-11

Улаанбаатар хот

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны төсвийг батлах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.4, 8.6 (v) дэх хэсгийн дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2024 оны 3 дугаар сарын 06-07-ний өдөр болсон ээлжит хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

**ТЭМДЭГЛЭХ нь:**

1. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо ("ЗНДЦУХ") 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдөр болсон хурлаараа хэлэлцээд Банкны ТУЗ-ийн 2024 оны санхүүгийн жилийн төсөв ("ТУЗ-ийн 2024 оны төсөв")-ийг хавсралтад заасны дагуу санал болгосныг; мөн
2. ТУЗ нь ТУЗ-ийн 2024 оны төсвийг ЗНДЦУХ-наас санал болгосноор Банкны Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулах хүсэлтэй байгааг тус тус дурдав.

**ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн 2024 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралтад заасны дагуу Банкны Хувьцаа эзэмшигчдэд санал болгон танилцуулж, батлуулахыг дэмжсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙГ  
ТӨЛӨӨЛЖ ТУЗ-ИЙН ГИШҮҮН



  
МАЙКЛ МАДДЕН

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

  
Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-11 дүгээр тогтоолын Хавсралт




**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
2024 ОНЫ ТӨСӨВ**

Банкны Хувьцаа эзэмшигчдээр батлуулах

Д	Зориулалт	Дүн төгрөгөөр (сая)
1	Хөлс <sup>1</sup>	5,256.9
2	Бусад зардал	1,516.6
	<b>Нийт дүн</b>	<b>6,773.50</b>

-оОо-

<sup>1</sup> Хөлс гэдэгт хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, мөн ТУЗ-ийн даргатай байгуулсан хүчин төгөлдөр хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлд заасан ТУЗ-ийн даргын хөлс, урамшууллыг ойлгоно.



**Хувьцаа эзэмшигчдийн  
хурлын тогтоолын төслүүд**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]-1

2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх  
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

### ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2023 оны үйл ажиллагааны тайлан ("2023 оны үйл ажиллагааны тайлан")-г хянан хэлэлцээд 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-12 тоот тогтоол гарган, 2023 оны үйл ажиллагааны тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв бөгөөд бодитоор илэрхийлсэн гэж дүгнэж ("ТУЗ-ийн дүгнэлт"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус дурдав.

### ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралт ёсоор Банкны 2023 оны үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

2023 оны санхүүгийн тайлангийн талаарх  
ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн баталгаажуулсан Банкны 2023 оны санхүүгийн тайлан ("**2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан**")-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**") хянан хэлэлцээд тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу үнэн зөв бөгөөд бодитоор илэрхийлсэн гэж 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-19 тоот тогтоолоороо дүгнэн ("**ТУЗ-ийн дүгнэлт**"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус дурдав.

## ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралт ёсоор Банкны 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА



Банкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас  
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах эсэх нь стратегийн асуудал болохын хувьд Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны 2023 оны цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (“Ногдол ашиг”)-ыг 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн R-2024-02 дугаар тогтоолоороо хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
3. ТУЗ нь 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-19 дүгээр тогтоолоороо 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг баталсан бөгөөд тус тайлан аливаа материаллаг өөрчлөлтгүйгээр батлагдсан болохыг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Ногдол ашигт нийт 26,580,675,000.00 (хорин зургаан тэрбум таван зуун наян сая зургаан зуун далан таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 25.25 (хорин таван төгрөг хорин таван мөнгө) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийг Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү шийдвэр батлагдсан өдрөөс хойших 7 хоногос хэтрүүлэлгүйгээр Банкны ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлж эхэлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Хувьцаа эзэмшигчид өмнө нь ХасБанк ХК-ийн Дүрэм (“Банкны Дүрэм”)-ийг SR-2023-22 дугаартай тогтоолоор баталсан болохыг;
2. Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолдоо өөрчлөлт оруулж, нээлттэй хувьцаат компаниудад ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор СЗХ-нд ирүүлэхийг үүрэг болгосныг;
3. СЗХ нь 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 3/712 тоот албан бичгээрээ ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Банкнд үүрэг болгосныг;
4. Банкны хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дүрэмд заасны дагуу ногдол ашиг тараах эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэдэг бөгөөд энэ нь СЗХ-ноос тогтоосон ногдол ашиг хуваарилах, тайлагнах үүрэгт хугацааг дагаж мөрдөхөд бэрхшээл үүсгэж байгааг; мөн
5. Хувьцаа эзэмшигчид нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн R-2024-17 дугаар тогтоолоор зөвлөмж болгосны дагуу Банкны Дүрэмд оруулах өөрчлөлтийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Дээрхийг үндэслэн, Банкны Дүрмийн 6.5 дахь хэсэгт дараах байдлаар өөрчлөлт оруулсугай:

Одоогийн заалт	Өөрчлөлт оруулсан заалт
6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.	6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс <del>тогтоож</del> , Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны <u>шийдвэрлэсний</u> үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.

2. Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг хүчингүй болгосугай.
3. Дээр дурдсан өөрчлөлтүүдийг тусгасан Банкны дүрмийг тогтоолд хавсаргасугай.
4. Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт дээр дурдсан Дүрмийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн бүртгэлийн ерөнхий газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж бүртгүүлэхийг даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны хувьцаа эзэмшигчид өмнө нь ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг SR-2024-01 дугаартай тогтоолоор баталсан болохыг (“**Ногдол ашгийн бодлого**”);
2. Санхүүгийн Зохицуулах Хороо (“**СЗХ**”) нь 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолдоо өөрчлөлт оруулж, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор СЗХ-нд ирүүлэхийг үүрэг болгосныг;
3. СЗХ нь 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 3/712 тоот албан бичгээрээ ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Банкинд үүрэг болгосныг;
4. СЗХ-ны тогтоосон журмыг дагаж мөрдөх зорилгоор Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийн R-2024-18 дугаар тогтоолоор зөвлөмж болгосны дагуу Хувьцаа эзэмшигчид нь Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Дээрхийг үндэслэн, Ногдол ашгийн бодлогын 3.2, 3.3 болон 4.1 дүгээр хэсгүүдэд дараах өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулсугай:

Одоогийн заалт	Өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулсан заалт
<p>3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</p>	<p>3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <del>Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг</del> Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</p>

<p>3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй.</p> <p>4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ.</p>	<p>3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>шийдвэрлэснээр шийдвэрлэж, Хувьцаа-эзэмшигчдийн баталснаар</u> ногдол ашиг авах эрхтэй.</p> <p>4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ шийдвэрлэнэ.</u></p>
---	--

2. Ногдол ашгийн бодлогод дээр дурдсан өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийг тусган, энэхүү тогтоолд хавсаргасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанкинд ЕСБХБ-тай Фреймворк гэрээ  
байгуулах зөвшөөрөл олгох тухай

ХасБанк ХК (“ХасБанк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаараа хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“ТСН”) нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг (“Хуулийн шаардлага”);
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид өмнө нь SR-2023-01 дүгээр тогтоол гаргаж, ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх замаар энэхүү Хуулийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзсэн, нэгдлийн үр дүнд ХасБанк үйл ажиллагаагаа үргэлжлүүлж үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохыг (“Нэгтгэх өөрчлөн байгуулалт”);
3. ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх өөрчлөн байгуулалттай холбогдуулан, ХасБанкийг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ”)-тай Фреймворк гэрээг Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд Нэгтгэх гэрээг байгуулахыг SGR-2024-03 дугаар тогтоолоороо шийдвэрлэсэн болохыг; мөн
4. ХасБанк нь ЕСБХБ-тай Фреймворк гэрээг Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулах урьдчилсан нөхцөлийг хангах үүднээс болон тус гэрээг хянасны үндсэнд, Хувьцаа эзэмшигчид нь ХасБанкинд ЕСБХБ-тай Фреймворк гэрээ байгуулах зөвшөөрөл олгохыг дэмжсэн болохыг тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. ЕСБХБ болон ХасБанкны хооронд Фреймворк гэрээг энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулах өдөр эсхүл түүнээс өмнө Фреймворк гэрээг байгуулж, түүнд гарын үсэг зурахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанкинд ОУСК-тай Бодлогын гэрээ  
байгуулах зөвшөөрөл олгох тухай

ХасБанк ХК (“ХасБанк”) -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаараа хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“ТСН”) нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг (“Хуулийн шаардлага”);
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид өмнө нь SR-2023-01 дүгээр тогтоол гаргаж, ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх замаар энэхүү Хуулийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзсэн, нэгдлийн үр дүнд ХасБанк үйл ажиллагаагаа үргэлжлүүлж үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохыг (“Нэгтгэх өөрчлөн байгуулалт”);
3. ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх өөрчлөн байгуулалттай холбогдуулан, ХасБанкийг Олон Улсын Санхүүгийн Корпораци (“ОУСК”) -тай Бодлогын гэрээг Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд, Нэгтгэх гэрээг байгуулахыг SGR-2024-03 дугаар тогтоолоороо шийдвэрлэсэн болохыг; мөн
4. ХасБанк нь ОУСК-тай Бодлогын гэрээг Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулах урьдчилсан нөхцөлийг хангах үүднээс болон тус гэрээг хянасны үндсэнд, Хувьцаа эзэмшигчид нь ХасБанкинд ОУСК-тай Бодлогын гэрээ байгуулах зөвшөөрөл олгохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. ОУСК болон ХасБанкны хооронд Бодлогын гэрээг энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулах өдөр эсхүл түүнээс өмнө Бодлогын гэрээг байгуулж, гарын үсэг зурахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА



ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр  
ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

Банкны тухай хуулийн 4.2 дахь хэсэг, 29.2.4 дэх заалт болон 36.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 18.1, 20.4 дэх хэсэг болон 62.1.2 дахь заалт, ХасБанк ХК (“**ХасБанк**”)-ийн Дүрмийн 8.6 дахь хэсэг болон 8.6 (viii) дахь заалтыг тус тус үндэслэн, ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

### ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“**ТСН**”) нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг (“**Хуулийн шаардлага**”);
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид өмнө нь SR-2023-01 дүгээр тогтоол гаргаж, ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх замаар энэхүү Хуулийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзсэн, нэгдлийн үр дүнд ХасБанк үйл ажиллагаагаа үргэлжлүүлж үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохыг (“**Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах**”);
3. ХасБанк нь Банкны тухай хуулийн 4.2 дахь хэсэг болон Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцүүлэн, хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн болохыг;
4. ХасБанкны Дүрмийн 8.6 дугаар зүйлд заасны дагуу нэгтгэх талаарх шийдвэр нь стратегийн асуудал болохын хувьд ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдах шаардлагатай болохыг;
5. ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан, ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“**ЕСБХБ**”)-тай Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпораци (“**ОУСК**”)-тай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд, Нэгтгэх гэрээг байгуулахыг SGR-2024-03 дугаар тогтоолоороо шийдвэрлэсэн болохыг;
6. ТСН-ийн хүсэлтээр, ХасБанкийг ЕСБХБ-тай Фреймворк гэрээ болон ОУСК-тай Бодлогын гэрээг тус тус байгуулахыг зөвшөөрөх тухай ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргуулах саналыг Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийн R-2024-13 дугаар тогтоолын дагуу ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд оруулсан болохыг;
7. ХасБанкны хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн тавьсан урьдчилсан нөхцөл буюу ХасБанк ЕСБХБ-тай Фреймворк гэрээ, ОУСК-тай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулах нөхцөлийг биелүүлэхээр SR-2024-[\*] болон SR-2024-[\*] дугаар тогтоолуудаараа шийдвэрлэсэн болохыг; мөн
8. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн зөвлөмжийн дагуу Хуулийн шаардлагыг цаг алдалгүй биелүүлэх үүднээс, Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад хавсаргасан ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээний дагуу ТСН-ийн үйл ажиллагааг зогсоож, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хуулийн этгээд болох ХасБанкинд Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулсугай.
2. Нэгтгэх өөрчлөн байгуулалтад шаардагдах баримт бичгийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх зорилгоор “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журам”-ыг 2 дугаар хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
3. ХасБанкийг өөрчлөн байгуулах комиссын гишүүдээр Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав, Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр болон Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэг нарыг томилж, тэдэнд энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах, үүний дотор холбогдох баримт бичгийг үйлдэх, түүнд гарын үсэг зурах, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх, бүртгүүлэх, шаардлагатай тохиолдолд Банкны тухай хуулийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах комисс байгуулж ажиллахыг даалгаж, холбогдох эрхийг тус тус олгосугай.
4. Үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн үлдэх компани болох ХасБанкны хөндлөнгийн аудитор байгууллагаар Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийг хэвээр үргэлжлүүлэн ажиллуулсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, Банкны тухай хуулийн 29.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн бүрэн эрх 2 жилийн хугацаатай бөгөөд одоогийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа нь Банкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын өдрөөр дуусгавар болохыг;
2. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журмын 5.1 дэх хэсэгт заасны дагуу Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”) нь Банкны хувьцаа эзэмшигчдэд 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн зөвлөмжөөрөө Банкны ТУЗ-ийн 12 орон тоонд нэр бүхий нэр дэвшигчдийг санал болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь кумулятив аргаар хураасан санал хураалтын үр дүнг тодорхойлсон Тооллогын комиссын шийдвэрт үндэслэн, дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. Дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгосугай:
  1. [\*\*\*];
  2. [\*\*\*];
  3. [\*\*\*];
  4. [\*\*\*];
  5. [\*\*\*];
  6. [\*\*\*];
  7. [\*\*\*];
  8. [\*\*\*];
  9. [\*\*\*];
  10. [\*\*\*];
  11. [\*\*\*]; мөн
  - 12 [\*\*\*];
2. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай эсхүл зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгаж, холбогдох эрхийг олгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоох тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.4 дэх хэсэг болон 8.6 (v) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-10 дугаар тогтоолоороо ТУЗ-ийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоох тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн даргаас бусад гүйцэтгэх удирдлагын бус ТУЗ-ийн гишүүний хөлсийг дараах байдлаар тогтоосугай:
  - 1.1. Жилд олгох нийт хөлсийг 50,000 (**тавин мянга**) ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоож улирал тутам тооцож олгосугай. Энэхүү өөрчлөлтийг 2024 оны санхүүгийн жилээс эхлэн мөрдсүгэй
  - 1.2. ТУЗ-ийн дэргэдэх нэг болон түүнээс дээш хороодын даргаар ажиллаж буй гишүүн бүрд жилд олгох нийт 5,000 (**таван мянга**) ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн нэмэгдлийг хэвээр тогтоож, 2024 оны санхүүгийн жилд үргэлжлүүлэн мөрдсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн дагуу ТУЗ-ийн гишүүний хөлсийг 2024 оны санхүүгийн жилээс эхлэн шинэчлэн тогтоож, ийнхүү тогтоосонтой холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн SR-2022-04 дүгээр тогтоолын 1 болон 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, ХасБанк ХК (“**Банк**”)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 8.6 (v) дахь заалтыг үндэслэн, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

### ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”) 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-11 тоот тогтоолоороо ТУЗ-ийн 2024 оны төсөв (“**ТУЗ-ийн 2024 оны төсөв**”)-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг дурдав.

### ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2024 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

## ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ

Д	Зориулалт	Дүн төгрөгөөр (сая)
1	Хөлс <sup>1</sup>	5,256.9
2	Бусад зардал	1,516.6
	<b>Нийт дүн</b>	<b>6,773.50</b>

<sup>1</sup> Хөлс гэдэгт хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, мөн ТУЗ-ийн даргатай байгуулсан хүчин төгөлдөр хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлд заасан ТУЗ-ийн даргын хөлс, урамшууллыг ойлгоно.



## ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
3 сарын 15-ны өдрийн R-2024-20 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

Комиссын дарга: Б.Ананд, гүйцэтгэх захирал, Кэй И Партнерс ХХН

Комиссын гишүүд: М.Лхамсүрэн, партнер, Кэй И Партнерс ХХН

Г.Хажидмаа, туслах хуульч, Кэй И Партнерс ХХН



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 сарын 15-ны өдрийн Р-2024-20 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

**ЕРДИЙН ЖУРМААР ӨГӨХ САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР**

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4.	Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5.	Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.	ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7.	ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8.	ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9.	ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

10.	ТУЗ-ийн 2024 оны төсөв	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
-----	------------------------	--------------------------	--------------------------	--------------------------

Хувьцаа эзэмшигчдийн хуралд тавих асуулт болон санал\*

\*Цаг хугацааны бололцоог харгалзан, хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн зарим асуулт, саналыг ээлжит хурлын үеэр танилцуулж, хариулт өгч болно. Ийнхүү хэлэлцэх нь урьдчилан ирүүлсэн саналд гагцхүү хамаарахыг анхаарна уу. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид нь хурлын үеэр асуултаа шууд тавих боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Бүртгэсэн (үнэт цаасны компани) \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:  
\_\_\_\_\_ / \_\_\_\_\_

2024 оны ... сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
2. Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот болон орон нутаг дахь ХасБанкны салбар, тооцооны төвүүдээр дамжуулан цаасан хэлбэрээр, эсхүл цахим хэлбэрээр өгөх боломжтой.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

-----  
Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 сарын 15-ны өдрийн R-2024-20 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

### КУМУЛЯТИВ АРГААР ӨГӨХ САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

#### Тайлбар/Санамж:

Таны өгөх нийт саналын тоо нь бүртгэлийн өдрөөр таны эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн нийт гишүүдийн тоо<sup>1</sup> буюу Банкны Дүрмийн дагуу 12-оор үржүүлж тооцогдоно. ТУЗ-ийн 12 гишүүний 8 нь ердийн, 4 нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.

#### Томьёо:

$$\boxed{\text{Саналын эрхийн тоо}} = \boxed{\text{Бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй таны хувьцааны тоо}} \times 12$$

Хувьцаа эзэмшигч нь саналаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой. Энэхүү арга нь хувьцаа эзэмшигч өөрийн хүсэл зоригоор нэг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид саналаа төвлөрүүлэн өгөх боломжийг олгодог.<sup>2</sup> Санал хураалтын үр дүнд хамгийн олон санал авсан нэр дэвшигчид нь ТУЗ-ийн гишүүдээр сонгогдоно. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Тооллогын төрөл (ердийн болон хараат бус гишүүн) тус бүрээр хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг сонгоно.<sup>3</sup>

#### Саналаа хуваарилан өгөх жишээ:

<sup>1</sup> Компанийн тухай хуулийн 72.1.3 дахь заалт; СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 2.1 дэх хэсэг

<sup>2</sup> СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 3.1 дэх хэсэг

<sup>3</sup> СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 4.1 дэх хэсэг

Хувьцаа эзэмшигч А нь ХҮ ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 12 гишүүнтэй, үүнээс 4 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 1200 саналтай болно. Тэрээр дараах байдлаар саналаа хуваарилан өгөх боломжтой:

- Нийт 1200 саналаа бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэр дэвшигчид өгөх; эсхүл
- Нийт 1200 саналын 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 8 хүртэл нэр дэвшигчид, үлдсэн 600 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид тус тус өгөх; эсхүл
- Өөрийн нийт саналыг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

**САНУУЛГА:** Өөрийн саналыг хэрхэн хуваарилан өгөхөөс үл шалтгаалан, таны өгөх нийт саналын тоо нь дээр дурдсан Томьёоны дагуу тодорхойлсон саналын эрхийн тоотой тэнцүү байх шаардлагатай. Хэрэв таны өгсөн саналын тоо нь таны саналын эрхийн тооноос илүү байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
<b>ТУЗ-ийн ердийн гишүүнд</b>		
1.	Н.Цэлмүүн	
2.	Сюзанна Херринг Карр	
3.	Албертус Браггинк	
4.	Анджей Витак	
5.	Доминик Жак	
6.	Майкл Мадден	
7.	Санжай Гүпта	
8.	Г.Цэвэгжав (ХасБанкны Дүрмийн 8.39 дэх хэсгийн дагуу)	
<b>ТУЗ-ийн хараат бус гишүүнд</b>		
1.	Б.Уламбаяр	
2.	Нираж Вэдва	
3.	Эми Чой	
4.	Лоуренс Цонг	
5.	Стюарт Доналд Холл	

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Бүртгэсэн (үнэт цаасны компани) \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_

2024 оны ... сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот болон орон нутаг дахь ХасБанкны салбар, тооцооны төвүүдээр дамжуулан цаасан хэлбэрээр, эсхүл цахим хэлбэрээр өгөх боломжтой.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
3. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

-----  
Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: \_\_\_\_\_

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



